numur

Golomt Capital
Delivering diversity



# “Нөмөр Кредит Ассет” ХБҮЦ

| Андеррайтер | Хөрөнгө итгэмжлэн удирдагч | Зээлийн шинжилгээ гаргагч | Хуулийн фирм |
| --- | --- | --- | --- |
| Golomt Capital Delivering diversity | UAF Юнайтед Айр Файнэнс | MOORE | KhanLexPartners |

БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2022-09-29
БҮРТГЭВ-03

## АГУУЛГА

1. ХҮСНЭГТҮҮДИЙН ЖАГСААЛТ ........
2. ГРАФИКУУДЫН ЖАГСААЛТ ........ 5
3. СХЕМИЙН ЖАГСААЛТ ........ 6
ҮНЭТ ЦААС ГАРГАХАД ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГУУД ........ 7
ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД ........ 8
НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР ........ 9
ТОВЧИЛСОН ҮГНИЙ ТАЙЛБАР ........ 10
1 ҮНЭТ ЦААСНЫ ХУРААНГУЙ ТАНИЛЦУУЛГА ........ 12
1.1 Үнэт цаасны товч танилцуулга ........ 12
1.2 Үнэт цаас гаргагчийн мэдээлэл ........ 13
1.3 Үүсгэн байгуулагчийн тухай ........ 14
1.4 Мөнгөн урсгалын тооцоолол ........ 14
1.5 Хөрөнгийн багцын мэдээлэл ........ 15
2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧИН ........ 17
2.1 Макро эдийн засгийн төлөв байдал ........ 17
2.2. Хөрөнгийн зах зээлийн нөхцөл байдал ........ 24
2.3. ХБҮЦ-ны тухай, давуу болон сул талууд ........ 27
3 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ ........ 35
3.1 Үнэт цаас гаргагчийн ерөнхий мэдээлэл ........ 35
3.2 Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагчийн тухай ........ 35
3.3 Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн мэдээлэл ........ 36
3.1.1. ТУЗ-ийн гишүүдийн мэдээлэл ........ 37
3.1.2. ТУЗ-ийн эрх үүрэг ........ 37
3.4 Үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайлан ........ 38
3.5 Үнэт цаас гаргагчийн Санхүүгийн төсөөлөл ........ 39
3.6 Зөвшөөрөгдсөн данснуудын мэдээлэл ........ 40
3.7 Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг буцаан дуудах нөхцөл ........ 41
4 ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ ........ 43
4.1 Үнэт цаасжуулах хэлцлийн зураглал ........ 43
4.2 Санал болгож буй хүүгийн түвшин болон хүү тогтоосон үндэслэл ........ 45
4.3 Үнэт цаас эзэмшигчдэд төлөх төлбөрийн эх үүсвэр, төлбөрийн хуваарь ........ 46
4.4 Хөрөнгийн багц, багцад тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтүүд ........ 47
4.5 Хөрөнгийн багцын мэдээлэл ........ 49
Зээлийн төвлөрөл ........ 51
4.6 Үнэт цаасанд нөлөөлөх эрсдэлийн шинжилгээ ........ 52



УЛААНБААТАР ХОТ
АССЕТ ХХК
9022080593
6062705 СБТ19638

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -09- 29
БҮРТГЭВ 03
2022 .09. 21 өдөр
БҮРТГЭВ
№

4.7 Хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах, багцаас хөрөнгө хасах журам ........ 56
5 АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧ ББСБ-ЫН ТУХАЙ ........ 59
5.1 Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн ерөнхий мэдээлэл ........ 59
5.2 Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хувьцаа эзэмшигч, холбоотой этгээдийн мэдээлэл ........ 59
5.3 Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн удирдлагын баг ........ 62
5.3.1 Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн ТУЗ-ийн гишүүдийн мэдээлэл ........ 62
5.3.2 Компанийн бүтэц ........ 63
5.4 ББСБ салбарын судалгаа, хэтийн төлөв ........ 63
5.5 Банк бус санхүүгийн байгууллагын салбарын цаашдын чиг хандлага ........ 67
5.6 Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн санхүүгийн байдал ........ 71
5.7 Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эрсдэлийн удирдлага ........ 76
6 ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ ........ 79
6.1 Үйлчилгээ үзүүлэгчийн тухай мэдээлэл, үүрэг ........ 79
6.2 Үйлчилгээ үзүүлэгчтэй байгуулсан гэрээ ........ 79
6.3 Үйлчилгээ үзүүлэгчтэй байгуулсан гэрээг цуцлах нөхцөл ........ 81
7 ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАГЧИЙН ТУХАЙ ........ 83
7.1 Ерөнхий танилцуулга ........ 83
7.2 Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний тухай ........ 84
7.3 Хөрөнгө итгэмжлэн удирдагчийг солих ........ 84
8 ХБҮЦ-НЫ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН ........ 87
8.1 Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааг зохицуулах хууль эрх зүйн орчин ........ 87
8.2 Үнэт цаас гаргах үйл ажиллагааг зохицуулах хууль эрх зүйн орчин ........ 88
8.3 Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон хөрөнгийн багцтай холбоотой хууль эрх зүйн орчин 90
8.4 ТЗК-ийн ХБҮЦ-тай холбоотой үйл ажиллагааны зохицуулалт: ........ 90
9 ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААГ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАХ ........ 94
9.1 Үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах ........ 94
9.2 Үнэт цаасны арилжаанд оролцох, захиалга авах заавар ........ 95
9.3 Албан татвар ........ 96
9.4 Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа ........ 96
9.5 Үнэт цаасны арилжаа, хүүгийн төлбөр, эргэн төлөлтийн график ........ 96
9.6 Үнэт цаас эзэмшигчийн эрх, үүрэг ........ 97
9.7 Үнэт цаас гаргагчийн эрх, үүрэг ........ 97
10 ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДАД ТАЙЛАГНАХ ........ 99



УЛААНБААТАР ХОТ
НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЗК ХХК
9022080593
6862705 СБТ19638

10.1 Хөрөнгө оруулагчдад танилцуулах мэдээллүүд, тэдгээрийн тайлангийн хугацаа 99

10.2 Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журмын тухай ............................ 101

11 ҮНЭТ ЦААС ГАРГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХӨНДЛӨНГИЙН ДҮГНЭЛТ ӨГСӨН КОМПАНИУД ............................ 103

11.1 Андеррайтер ............................ 103

11.2 Зээлийн шинжилгээ гаргагч ............................ 104

11.3 Хуулийн шинжилгээ гаргагч ............................ 105

11.4 Хэлцлийн зөвлөх, Хэлцэл эрхлэн гүйцэтгэгч ............................ 107

12 ХАВСРАЛТУУД ............................ 108

12.1 Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, түүний бэлтгэл ажлыг хангах тухай тогтоол ............................ 109

12.2 Хуулийн дүгнэлт ............................ 113

12.3 Зээлийн шинжилгээ гаргагчийн дүгнэлт ............................ 135

12.4 Хөрөнгийн багц дахь хуулийн дүгнэлт ............................ 150

12.5 Үнэт цаас гаргагчийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар ............................ 172

12.6 Үнэт цаас гаргагчийн дүрмийн хуулбар ............................ 174

12.7 Үнэт цаас гаргагчийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар ............................ 179

12.8 Үнэт цаас гаргагчийн эхлэлтийн баланс ............................ 185

12.9 Үнэт цаас гаргагчийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрмийн хуулбар ............................ 190

12.10 Үүсгэн байгуулагч, Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар ............................ 199

12.11 Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн ТУЗ-ийн тогтоол ............................ 203

12.12 Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар ... 204

12.13 Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээ ............................ 206

12.14 Санхүүгийн ашиг сонирхлын талаарх мэдэгдэл ............................ 207

numur
СЭХ
2022.09.21 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-09-29
БҮРТГЭВ-03

## 1. ХҮСНЭГТҮҮДИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. ХБҮЦ эзэмшигчдэд төлбөрийн хуваарь, сая төгрөг (хүү тооцох суурь 365 хоног) ..... 15
Хүснэгт 2. Хөрөнгийн багцын үндсэн үзүүлэлт ..... 15
Хүснэгт 3. Эдийн засгийн голлох үзүүлэлтүүд ..... 18
Хүснэгт 4. Бодит ДНБ-ийн өсөлтийн төсөөлөл, хувиар ..... 19
Хүснэгт 5. Инфляцын төсөөлөл, хувиар ..... 21
Хүснэгт 6. Хөрөнгийн зах зээлийн голлох үзүүлэлтүүд ..... 24
Хүснэгт 7. Бондын анхдагч зах зээлийн арилжаа ..... 26
Хүснэгт 8. Үнэт цаас худалдан авагчид үүсэх давуу тал ..... 31
Хүснэгт 9. Хувьцаа эзэмшлийн бүтэц ..... 35
Хүснэгт 10. Үнэт цаас гаргагчийн эхлэлтийн тайлан баланс ..... 38
Хүснэгт 11. Үнэт цаас гаргагчийн орлогын тайлан төсөөлөл /сая төгрөг/ ..... 39
Хүснэгт 12. Үйл ажиллагааны голлох зардал ..... 39
Хүснэгт 13. ХБҮЦ-д хөрөнгө оруулсан хөрөнгө оруулагчийн жилийн өгөөж ..... 46
Хүснэгт 14. Хүснэгт 14. ХБҮЦ эзэмшигчдийн төлбөрийн хуваарь, сая.төг (хүүгийн тооцоолол хийсэн жилийн суурь хоног 365/А) ..... 47
Хүснэгт 15. Хөрөнгийн багцын үндсэн үзүүлэлт ..... 49
Хүснэгт 16. Автомашины зээлийн багц анх олгосон хугацаагаар /сая төгрөг/ ..... 50
Хүснэгт 17. Зээлийн төвлөрөл /үнийн дүнгээр/ ..... 51
Хүснэгт 18. Зээлийн хугацаа ..... 52
Хүснэгт 19. Хувьцаа эзэмшигчдийн бүтэц ..... 59
Хүснэгт 20. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдлын тайлан ..... 71
Хүснэгт 21. Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд ..... 74
Хүснэгт 22. Орлого үр дүнгийн тайлан ..... 74
Хүснэгт 23. Үнэт цаас гаргагчийн бизнес төлөвлөгөөнд учирч болох эрсдэлүүд ..... 77
Хүснэгт 24. Хууль, дүрэм журмууд ..... 88
Хүснэгт 25. ХБҮЦ эзэмшигчдэд төлөх төлбөрийн хуваарь ..... 96
Хүснэгт 26. Үнэт цаас эзэмшигчдэд тайлан мэдээлэл түгээх нь ..... 99

## 2. ГРАФИКУУДЫН ЖАГСААЛТ

График 1. ТЗК-ийн мөнгөн урсгалын үзүүлэлтүүд /сая төгрөг/ ..... 14
График 2. Монгол Улсын нэрлэсэн ДНБ(их наяд төгрөг) болон бодит ДНБ-ний өсөлт .. 19
График 3. Инфляцийн түвшин хувиар ..... 20
График 4. Төсвийн тэнцэл (тэрбум төгрөг) ..... 21
График 5. Гадаад худалдааны тэнцэл (сая ам.доллар) ..... 22
График 6. М2 мөнгөний нийлүүлэлт (их наяд төгрөг) ..... 23
График 7. ГВАН (сая ам.доллар) vs. төгрөгийн эсрэг ам.долларын ханш ..... 24
График 8. МХБ-ийн индексүүд, оны эхэн үетэй харьцуулахад ..... 26
График 9. ХБҮЦ-ны зах зээлийн өсөлт ..... 32
График 10. ХБҮЦ-ны бүтээгдэхүүний 2021 оны зах зээлд эзлэх хувь ..... 33
График 11. Төгрөгийн хадгаламжийн хүү (2022 оны 8 сарын байдлаар) ..... 46
График 12. Автомашины зээлийн задаргаа /үнийн дүнгээр/ ..... 50
График 13. Финтек зээлийн багцын задаргаа /сая төгрөг/ ..... 51
График 14. Санхүүгийн салбарын бүтэц ..... 64



Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital

УЛААНБААТАР ХОТ
НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЗК ХХК
9022030593

График 15. Санхүүгийн салбарын өсөлт /дэд салбар/ ........ 64
График 16. ББСБ-ын үйл ажиллагааны үзүүлэлтүүд ........ 65
График 17. ББСБ салбарын хөрөнгийн бүтэц (тэрбум төгрөг) ........ 65
График 18. ББСБ салбарын зээлийн бүтэц (тэрбум төгрөг) ........ 66
График 19. ББСБ салбарын эх үүсвэрийн бүтэц (тэрбум төгрөг) ........ 66
График 20. Монгол улсын финтек ББСБ-уудын өсөлт ........ 67
График 21. Улс орнуудын зээлийн хүрэлцээ ба финтек хөгжлийн хамаарал ........ 68
График 22. Дэлхийн финтекийн салбарын хөрөнгө оруулалт ........ 69
График 23. Хөдөлгөөнт банкны тоон үзүүлэлтүүд ........ 70
График 24. ББСБ салбарын нийт зээлийн өсөлт ба эдийн засгийн өсөлт ........ 70
График 25. ББСБ салбарын чанаргүй зээлийн хувь ба эдийн засгийн өсөлт ........ 71
График 26. Нийт хөрөнгө (сая төгрөг), График 27. Нийт хөрөнгийн бүтэц ........ 72
График 28. Цэвэр зээл (сая төгрөг), График 29. Бусад авлага, хөрөнгө (сая төгрөг) ........ 73
График 30. Нийт өр төлбөр (сая төгрөг), График 31. Эздийн өмч (сая төгрөг) ........ 73
График 32. Хүүгийн орлого (сая төгрөг), График 33. Хүүгийн зардал (сая төгрөг) ........ 75
График 34. Цэвэр ашиг (сая төгрөг), График 35. Ашигт ажиллагааны харьцаа ........ 75

## 3. СХЕМИЙН ЖАГСААЛТ

Схем 1. ХБҮЦ-ны зураглал ........ 28
Схем 2. ХБҮЦ хөгжил ........ 31
Схем 3. ХБҮЦ төрлүүд ........ 33
Схем 4. Үнэт цаасжуулах процесс зураглал ........ 43
Схем 5. Анхдагч зах зээлийн арилжааны төлөвлөгөө ........ 94
Схем 6. Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаанд оролцох заавар ........ 95

СЗХ
2022 он сар өдөр
БҮРТГЭВ
№ 11

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -09- 29
БҮРТГЭВ-03

## ҮНЭТ ЦААС ГАРГАХАД ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГУУД

### Андеррайтер

“ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК” ХХК
info@golomtcapital.com
+ 976-7012 1530
www.golomtcapital.com

### Зээлийн шинжилгээ гаргагч

“МҮҮРЬ АУДИТ” ХХК
info@moore-mongolia.mn
+ 976-7015 0003
www.moore-mongolia.mn

### Хуулийн фирм

“ӨМГӨӨЛЛИЙН ХААНЛЕКС ПАРТНЕРС ” ХХН
info@khanlex.mn
+ 976-7747 1122
www.khanlex.mn

### Хөрөнгө Итгэмжлэн Удирдагч

“ЮНАЙТЕД АЙР ФАЙНЕНС ” ХХК
info@uaf.mn
+ 976-7712 2346
www.uaf.mn

Голомт Капитал ҮЦК ХХК



УЛААНБААТАР ХОТ
НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЗК ХХК
9022080563
6062705 СБТ19638

СЗХ
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
Үнэт цаасны танилцуулга
2022-09-29
БҮРТГЭВ-03

## ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД

Үнэт цаас гаргагч нь Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр Баталгаажсан Үнэт Цаасны тухай хууль болон Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Биржийн холбогдох дүрэм, журмуудын дагуу Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргаж байгаа болно.

Энэхүү Үнэт цаасны танилцуулгыг Үнэт цаас гаргагчаас нэг бүрийн 100,000 төгрөгийн үнийн дүн бүхий 100,000 ширхэг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг Монголын Хөрөнгийн Бирж дээр гарган олон нийтэд нээлттэй арилжихтай холбоотойгоор хөрөнгө оруулагчдад зориулж бэлтгэсэн болно.

Энэхүү Үнэт цаасны танилцуулга нь Хөрөнгө оруулагч таны хараат бус үнэлгээ гаргах, шинжилгээ хийхийг орлохгүй бөгөөд тэдгээрт тооцогдохгүй. Хөрөнгө оруулагч та Үнэт цаас гаргагч болоод түүний гаргаж буй үнэт цаас, холбогдох мэдээллийн талаар өөрийн хөндлөнгийн судалгаа шинжилгээг хийсний үндсэн дээр хөрөнгө оруулалт хийж буй бөгөөд өөрийн мэргэжлийн санхүүгийн, хуулийн болон бусад зохих мэргэжлийн зөвлөхүүдтэйгээ зөвлөлдөхийг зөвлөж байна.

Энэхүү Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан зарим ирээдүйн болон зөвхөн одоогоор цаг хугацааны шинж чанартай гаргасан мэдээлэл, мэдэгдэл, тооцоолол, төсөөлөл нь Андеррайтерийн холбогдох эх сурвалжаас цуглуулсан мэдээлэл, итгэл үнэмшил дээр тулгуурласан бөгөөд санаатайгаар ямар нэгэн мэдээллийг орхигдуулаагүй болно. Андеррайтер нь эдгээр мэдээлэл, мэдэгдэл, тооцоолол, төсөөллийг гаргахдаа аль болох үнэн зөв мэдээллийг ашиглан бодит байдалд нийцүүлэхийг зорьсон боловч мэдээллийн үнэн зөв байдалд хариуцлага хүлээхгүй бөгөөд тооцоолол, ирээдүйн төсөөллийн биелэлтэд баталгаа өгөөгүй болно.

**ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААСЫГ САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО БОЛОН МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ БҮРТГЭСЭН НЬ УГ ҮНЭТ ЦААСНЫ ЭРСДЭЛИЙН ТАЛААР АЛИВАА БАТАЛГАА ГАРГААГҮЙ БОЛОХЫГ АНХААРАХ НЬ ЗҮЙТЭЙ. ЭНЭХҮҮ ҮНЭТ ЦААСЫГ ХУДАЛДАН АВАХ ЗАМААР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ТАНЫ ХУВЬД ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ ҮЙЛДЭЛ БАЙДГИЙГ ОНЦГОЙЛОН АНХААРЧ, ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА, ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААГ САЙТАР АНХААРАН СУДАЛСНЫ ҮНДСЭН ДЭЭР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЙДВЭРЭЭ ГАРГАХЫГ ЗӨВЛӨЖ БАЙНА.**

Энэхүү үнэт цаасны танилцуулгад хөрөнгө оруулагч танд тус үнэт цаасыг худалдан авах шийдвэр гаргахад туслах шаардлагатай бүхий л мэдээллийг агуулахыг зорьсон болно. Хөрөнгө оруулагч таны шийдвэр гаргалтад танилцуулгад тусгагдсан мэдээллээс илүү дэлгэрэнгүй, нэмэлт мэдээлэл шаардлагатай болох буюу лавлаж тодруулах зүйл байвал Үнэт цаас гаргагч болон Андеррайтер Голомт Капитал ҮЦК ХХК-д хандаж тодруулна уу.

Голомт Капитал ҮЦК ХХК



УЛААНБААТАР ХОТ
НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЗК ХХК
9022080593
6862705 СБТ19638

СЗХ
2022 .10. 01
numur дэр
БҮРТГЭВ
№

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
Үнэт цаасны танилцуулга
2022 -09- 29
БҮРТГЭВ-03

## НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

| Нэр томьёо | Тайлбар |
|---|---|
| Үүрэг гүйцэтгэгч | Гэрээнд заасны дагуу хөрөнгөтэй холбоотой мөнгөн төлбөрийн үүрэг хүлээсэн этгээд |
| Үйлчилгээ үзүүлэгч | Үүрэг гүйцэтгэгчтэй харилцаж, хөрөнгөтэй холбоотой төлбөрийг цуглуулан тусгай зориулалтын компанид шилжүүлэх, бүртгэх болон гэрээнд заасан бусад үйлчилгээг үзүүлэх хуулийн этгээд |
| Тусгай зориулалтын компани | Хорооноос хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авсан хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| Хөрөнгө итгэмжлэн удирдагч | Тусгай зориулалтын компанитай гэрээ байгуулсан, хөрөнгө оруулагчид барьцаалуулсан хөрөнгийг түүний эрх ашигт нийцүүлэн эзэмшиж, удирдах үүрэг бүхий этгээд |
| Хөрөнгийн багц | Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны нэг удаагийн гаргалтыг баталгаажуулж байгаа хөрөнгийн нийлбэр |
| Анхдагч зах зээлийн арилжаа | Үнэт цаас гаргагчийн шинээр болон нэмж гаргасан хувьцаа, өрийн хэрэгсэл болон бусад санхүүгийн хэрэгслийг анхдагч зах зээлд байршуулах, хуваарилалт хийх арилжих үйл ажиллагааг |
| Хороо | Санхүүгийн Зохицуулах Хороо |
| Бирж | Монголын Хөрөнгийн Бирж |

Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital



УЛААНБААТАР ХОТ
НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЗК
9022080593
6862705 СБТ19638

СЗХ
2022 . 09 . 21 . өдөр
БҮРТГЭВ
№ 31

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -09- 29
БҮРТГЭВ-03



## ТОВЧИЛСОН ҮГНИЙ ТАЙЛБАР

| Товч үг | Тайлбар |
|---|---|
| ХБҮЦ | Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас |
| СЗХ | Санхүүгийн Зохицуулах Хороо |
| МХБ | Монголын Хөрөнгийн Бирж |
| ХОС | Хөрөнгө оруулалтын сан |
| ДНБ | Дотоодын нийт бүтээгдэхүүн |

Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Улаанбаатар хот



УЛААНБААТАР ХОТ
НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЗК ХХК
9022080593
6862705 СБТ19638

# ҮНЭТ ЦААСНЫ ХУРААНГУЙ ТАНИЛЦУУЛГА

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-09-29
БҮРТГЭВ-03

# 1 ҮНЭТ ЦААСНЫ ХУРААНГУЙ ТАНИЛЦУУЛГА

## 1.1 Үнэт цаасны товч танилцуулга

| | |
|---|---|
| **Үнэт цаас гаргагч** | **Нөмөр Кредит Ассет ТЗК ХХК** |
| **Анхны үүрэг гүйцэтгүүлэгч** | Нөмөр Кредит ББСБ ХХК |
| **Бүртгэл** | Монголын Хөрөнгийн Бирж |
| **Үнэт цаасны төрөл** | Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас |
| **Нэрлэсэн үнэ** | 100,000 төгрөг |
| **Санал болгож буй тоо ширхэг** | 100,000 ширхэг |
| **Татан төвлөрүүлэх нийт дүн** | 10,000,000,000 |
| **Үнэт цаасны хугацаа** | 24 сар |
| **Үнэт цаасны хүү** | 17.5% |
| **Хүү төлөх давтамж** | Улирал бүр |
| **Үндсэн төлбөр төлөгдөх давтамж** | 12 сар бүр |
| **Үнэт цаас төлбөр төлөгдөх эх үүсвэр** | Хөрөнгийн багц дах зээлийн үндсэн төлбөр болон хүүгийн төлбөр |
| **Үнэт цаасны хүүд ногдох татвар** | Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн дагуу Хөрөнгө оруулагч нь үнэт цаасны хүүгийн орлогоос 5 хувийн албан татварыг суутгуулна |

Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Ulaanbaatar хот

УЛААНБААТАР ХОТ
НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЗК ХХК
9022080593
6862705

numur

## 1.2 Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

| | |
|---|---|
| **Үнэт цаас гаргагч** | Нөмөр Кредит Ассет ТЗК ХХК |
| **Улсын бүртгэлд бүртгүүлсэн огноо** | 2022 оны 5 сарын 3 |
| **Үнэт цаас гаргагчийн тухай** | Үнэт цаас гаргагч нь 2022 оны 5 сарын 3 -нд үүсгэн байгуулагдсан бөгөөд хөрөнгийн багцыг өөрийн санхүүгийн тайлан, тэнцэлд шилжүүлэн авах замаар баталгаат үнэт цаасыг хөрөнгө оруулагч эзэмших эрхтэйг баталгаажуулах чиг үүргийг хүрээнд үйл ажиллагаа явуулна. |
| **Регистрийн дугаар** | 6862705 |
| **Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ** | 1,000,000 (нэг сая) төгрөг |
| **Улсын бүртгэлийн дугаар** | 9011839181 |
| **Үйл ажиллагааны үндсэн чиглэл** | Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах |
| **Хаяг** | Улаанбаатар, Баянгол, 2-р хороолол, Энхтайваны өргөн чөлөө, 46 байр 806 тоот |
| **Утас** | 75111133 |

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
Үнэт цаасны танилцуулга
2022 -09- 29
БҮРТГЭВ-03

2022 .09 .21
он сар өдөр

Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital



УЛААНБААТАР ХОТ
НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЗК ХХК
9022080593
6862705 СБТ19638

## 1.3 Үүсгэн байгуулагчийн тухай

| | |
|---|---|
| Үүсгэн байгуулагч | Нөмөр Кредит ББСБ ХХК |
| Үүсгэн байгуулагчийн эзэмшиж буй хувь хэмжээ | 100% (Нэг бүр нь 10,000 төгрөгийн үнэ бүхий 100 ширхэг хувьцаа) |
| Регистрийн дугаар | 5928907 |
| Улсын бүртгэлийн дугаар | 9015003064 |
| Үүсгэн байгуулагдсан огноо | 2015/02/05 |
| Санхүүгийн Зохицуулах Хорооноос тусгай зөвшөөрөл олгосон огноо, дугаар | 2015/04/10<br>ТЗ 101/464<br>Банк бус санхүүгийн үйл ажиллагаа |
| Хаяг байршил | Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2-р хороо, Гранд Плаза Цогцолбор, 801 тоот |
| Арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй эсэх | Үгүй |
| Үйл ажиллагааны чиглэл | ➢ Зээлийн үйл ажиллагаа<br>➢ Итгэлцлийн үйл ажиллагаа |

## 1.4 Мөнгөн урсгалын тооцоолол

Үнэт цаас гаргагчийн нь Хөрөнгийн багцын эргэн төлөлтийн орлого болон хөрөнгө оруулалтын орлого, улирал бүрийн хүүгийн зардал болон үйл ажиллагааны зардлыг улирал бүрээр тооцоолбол үнэт цаас гаргагч нь ХБҮЦ-ны төлбөрийг төлөх бүрэн чадамжтай гэж дүгнэлээ.

**График 1. ТЗК-ийн мөнгөн урсгалын үзүүлэлтүүд /сая төгрөг/**




*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн тооцоолол*

Түүнчлэн хөрөнгө оруулагч нь жилийн 17.5 хувийн хүүг ХБҮЦ-ийн үлдэгдэл дүнд тооцож авах бөгөөд 100,000 төгрөгийн ХБҮЦ худалдан авсан хөрөнгө оруулагчийн төлбөрийн задаргааг доор хүснэгтээр харууллаа:

**Хүснэгт 1. ХБҮЦ эзэмшигчдэд төлбөрийн хуваарь, сая төгрөг (хүү тооцох суурь 365 хоног)**

| | У1 | У2 | У3 | У4 | У5 | У6 | У7 | У8 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| ХБҮЦ | 10,000 | 10,000 | 10,000 | 10,000 | 5,000 | 5,000 | 5,000 | 5,000 |
| Төлөгдөх үндсэн дүн | - | - | - | 5,000 | - | - | | 5,000 |
| **ХБҮЦ үлдэгдэл** | **10,000** | **10,000** | **10,000** | **5,000** | **5,000** | **5,000** | **5,000** | **-** |
| Хүү | 436.3 | 431.5 | 441.1 | 441.1 | 218.2 | 218.2 | 220.5 | 220.5 |
| Татварын дараах хүү | 414.5 | 409.9 | 419 | 419 | 207.2 | 207.2 | 209.5 | 209.5 |
| **Төлөгдөх нийт дүн** | **414.5** | **409.9** | **419** | **5,419.0** | **207.2** | **207.2** | **209.5** | **5,209.5** |

*Эх сурвалж: Андеррайтерийн тооцоолол*

## 1.5 Хөрөнгийн багцын мэдээлэл

Нөмөр Кредит Ассет ХБҮЦ нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасан шаардлагыг бүрэн хангасан бөгөөд 100 хувь автомашины зээлээс бүрдсэн нийт 587 зээлийн гэрээнээс бүрдэх 11,022.2 сая төгрөгийн үнийн дүн бүхий зээлийг багцалсан. Хөрөнгийн багцын үлдэгдэл жигнэсэн дундаж хугацаа 44.55 сар, жигнэсэн дундаж хүү байна.

**Хүснэгт 2. Хөрөнгийн багцын үндсэн үзүүлэлт**

| Хөрөнгийн багцын үндсэн үзүүлэлт | |
|---|---|
| Зээлийн төрөл | Дүн /төгрөгөөр/ |
| Нийт автомашины зээлийн үлдэгдэл | 11,022,245,541 |
| Зээлийн хөрөнгийн барьцааны дүн | 16,927,217,164 |
| Зээлийн гэрээний тоо | 587 |
| Зээлийн дундаж үлдэгдэл | 18,777,250 |
| Барьцааны дүн | 16,927,217,164 |
| Жигнэсэн дундаж хүү /сар/ | 2.75% |
| Жигнэсэн дундаж хугацаа /сар/ | 44.55 |
| Жигнэсэн дундаж LTV% | 65.12% |
| **Багцын зээлийн чанар** | **100% хэвийн зээл** |

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл*



numur
2022 он 09 сар 1 өдөр
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-09-29
УЛААНБААТАР ХОТ
НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЗК
ХХК
9022080593
6862705 СБТ19638

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№

# ХБҮЦ-НЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧИН

# 2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧИН

## 2.1 Макро эдийн засгийн төлөв байдал

2021 онд Ковид-19 цар тахлаас үүдсэн БНХАУ-н экспортын хоригийн нөлөөгөөр эдийн засгийн үйл ажиллагаа удааширч 1.4 хувийн өсөлттэй гарлаа. Хэдийгээр эдийн засгийн эрэлт, нийлүүлэлт сэргэж өмнөх онтой харьцуулахад экспорт 22 хувиар, импорт 29 хувиар өссөн үр дүнтэй гарсан хэдий ч инфляци 13.4 хувь хүрч бодит өсөлт бага гарлаа. Мөн гадаад худалдааны тэнцэл урьдчилсан гүйцэтгэлээр 2.4 тэрбум ам.долларын ашигтай гарсан нь өмнөх оны мөн үеэс 121.1 сая ам. Доллароор өссөн үзүүлэлттэй байгаа ч төлбөрийн тэнцэл 221 сая ам.долларын алдагдалтай гарч валютын ханш чангарлаа. Харин 2022 онд Дэлхийн банк болон Монголбанкнаас Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг 2.0 хувиас 2.5 хувьд хүрнэ гэж таамаглаж байгаа бөгөөд эдийн засгийн өсөлтийг дэмжихийн тулд экспортын биет хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Цар тахлын үед эдийн засгийг дэмжих зорилгоор мөнгөний зөөлөн бодлогыг хэрэгжүүлсэн нь инфляцыг 13.4 хувьд хүргэсэн ба Олон улсын санхүүгийн байгууллагуудын таамгалс наар 2022 онд 13.4 хувьд хадгалагдах төлөвтэй байна. 2022 он гарснаар Монголбанк бодлогын хүүг 6 хувиас 9 хувь хүртэл нэмэгдүүлсэн нь M2 мөнгөний хэмжээ 27.5 их наяд төгрөгт тогтвортой байх үндэс боллоо. Түүнчлэн цар тахлын үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээний нөлөөллөөр үүссэн төсвийн алдагдлыг 2021 онд бууруулан төсвийн тогтвортой байдлыг хангаж, мөчлөг сөрсөн төсвийн бодлого хэрэгжүүлсний хүрээнд төсвийн алдагдал 2.9 их наяд төгрөг болж өмнөх оны мөн үеэс 1.5 их наяд төгрөгөөр буурсан үзүүлэлттэй гарсан байна.

2021 онд түүхий эд, бараарын бүтээгдэхүүний үнэ өндөр өсөлттэй байсан ч дотоод эдийн засгийн өсөлт 1.4 хувьтай гарсан. Тухайлбал 2021 онд коксжих нүүрсний үнэ 127.1 хувиар, зэсийн үнэ 50.9 хувиар өссөн байна. Гэвч Ковид-19 цар тахалтай холбоотойгоор улс орнууд хилийн хязгаарлалт тогтоож, гадаад худалдаа, нийлүүлэлтийн хангамж тасалдаж, улмаар тээвэр, боловсруулах, барилгын салбарт идэвхжил суларсан нь эдийн засгийн өсөлт буурахад нөлөөлжээ.

Монгол Улсын Засгийн газар 2022 онд төлөгдөх Чингис бонд, 2023 онд төлөгдөх Гэрэгэ бондын нийт 1 тэрбум ам.долларын төлөлтийг дахин санхүүжүүлснээр дунд хугацаанд валютын гадагшлах урсгал буурч, төгрөгийн ам.доллартой харьцах ханшийн тогтвортой байдал хангагдах суурь тавигдсан. Гэсэн хэдий ч 2022 онд түүхий эдийн экспортын гарцыг нэмэгдүүлээгүй тохиолдолд гадаад худалдааны тэнцлийг алдагдалтай гаргаж эргээд ханшинд дарамт үүсэх нөхцөл үүсэж байна.

**Хүснэгт 3. Эдийн засгийн голлох үзүүлэлтүүд**

| Үзүүлэлт | Нэгж | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022.1 |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Бодит сектор** | | | | | | | |
| ДНБ, оны үнээр | тэрбум төг. | 28,010 | 32,582 | 37,453 | 37,453 | 43,018 | |
| ДНБ, 2015 оны зэрэгцүүлэх үнээр | тэрбум төг. | 24,545 | 26,446 | 27,928 | 26,553 | 27,341 | |
| ДНБ-ний бодит өсөлт | Хувь | 5.60% | 7.70% | 5.60% | -4.60% | 1.40% | |
| Нэг хүнд ногдох ДНБ, оны үнээр | сая төг | 9 | 10.3 | 11.6 | 11.4 | 13.1 | |
| **Мөнгөний сектор** | | | | | | | |
| Мөнгө M1 | тэрбум төг. | 2,826 | 4,031 | 3,904 | 4,197 | 6,507 | 5,823 |
| Мөнгө M2 | тэрбум төг. | 15,861 | 19,475 | 20,834 | 24,220 | 27,863 | 26,780 |
| **Төсвийн сектор** | | | | | | | |
| Нэгдсэн төсвийн орлого | тэрбум төг. | 7,958 | 10,054 | 11,937 | 10,402 | 14,255 | 1,012 |
| Нэгдсэн төсвийн тэнцэл | тэрбум төг. | -1,059 | 831 | 508 | -4,539 | -2,908 | -358 |
| Гадаад валютын албан нөөц | сая ам.дол. | 3,008 | 3,549 | 4,349 | 4,534 | 4,366 | 3,945 |
| Засгийн газрын гадаад өр | сая ам.дол. | 7,321 | 7,184 | 7,702 | 8,653 | 8,449 | |
| **Гадаад сектор** | | | | | | | |
| Экспорт | сая ам.дол. | 6,201 | 7,012 | 7,620 | 7,576 | 9,247 | 540 |
| Импорт | сая ам.дол. | 4,337 | 5,875 | 6,127 | 5,293 | 6,848 | 557 |
| Төлбөрийн тэнцэл | сая ам.дол. | 1,460 | -142 | 453 | 786 | -221 | |
| Гадаадын шууд хөрөнгө оруулалт | сая ам.дол. | 2,086 | 2,729 | 2,900 | 2,620 | 2558 | |
| **Хүүний түвшин** | | | | | | | |
| Бодлогын хүү | % | 11.00% | 11.00% | 11.00% | 6.00% | 6.00% | 6.50% |
| Инфляцын түвшин | % | 6.40% | 8.10% | 5.20% | 2.30% | 13.40% | 14.70% |
| Хадгаламжийн хүү, жилээр | % | 13.00% | 11.20% | 10.60% | 8.30% | 7.24% | 7.44% |
| Зээлийн хүү, жилээр | % | 19.00% | 16.90% | 16.90% | 15.80% | 14.30% | 14.55% |
| Төгрөг ам.долларын албан ханш | төг. | 2,427 | 2,644 | 2,734 | 2,849 | 2,849 | 2,867 |

*Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо*

## Бодит сектор

Монгол Улсын эдийн засгийн өсөлт, бууралт нь экспортын гол нэрийн бүтээгдэхүүний үнийн өөрчлөлт, гадаадын шууд хөрөнгө оруулалт, стратегийн ач холбогдолтой төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтээс шууд хамааралтай байдаг. Монгол улс зах зээлийн эдийн засагт тогтолцоонд шилжсэнээс хойших буюу 1991 оноос хойш Монгол улсын нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн бодитоор 3 дахин өссөн байна. Улмаар 2015 онд Монгол улс

дэлхийн банкны ангиллаар дунджаас бага орлоготой орнуудын эгнээнд шилжсэн.

Харин 2017 онд Монгол Улс нь Олон Улсын Валютын Сан (ОУВС)-ийн санхүүжилтийн хөтөлбөрийг хэрэгжүүлж, олон улсын зах зээлд зэс, нүүрсний үнэ өссөнөөр эдийн засаг аажмаар сэргэж эхэлсэн. Гэвч 2020 онд Ковид-19 цар тахлын нөлөөгөөр эдийн засаг 4.6 хувиар агшсан нь 1992 оны шилжилтийн үеэс хойш тохиосон хамгийн том уналт болсон юм. Хэдийгээр 2021 онд эдийн засаг 1.4 хувиар өссөн нь таамаглалаас доогуур үр дүн ч салбаруудын өсөлтийн хувь ялгаатай байна. Тухайлбал бүтээгдэхүүний татвар өмнөх оноос 23.5 хувиар өссөн бол уул уурхайн салбар 1.7 хувиар, үйлчилгээний салбар 3.9 хувиар, тус тус өссөн болон хөдөө аж ахуйн салбар 5.5 хувиар, барилгын салбар 7.0 хувиар агшсан нь байна.

**График 2. Монгол Улсын нэрлэсэн ДНБ(их наяд төгрөг) болон бодит ДНБ-ний өсөлт**




*Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо*

Монгол Улсын 2022 оны эдийн засгийн төлөв байдал нь Ковид-19 цар тахлын нөхцөл байдал, Бүгд Найрамдах Хятад Ард Улс (БНХАУ)-ын эрэлтийг дагасан уул уурхайн бүтээгдэхүүний экспорт, хөрөнгө оруулалтын орчин, хувийн секторын зээлийн өсөлт, цаашлаад олон улсад тулгамдсан асуудал болоод буй инфляц түүнтэй холбоотой мөнгөний хатуу бодлого зэргээс хамаарч үр дүнтэй байх эсэх нь шалтгаална.

Дэлхийн банк, ОУВС, АХБ-ны шинжээчид Монгол Улсын эдийн засгийг 2022 онд дунджаар 2.3 хувь, 2023 онд 6.3 хувиар сэргэнэ гэж таамаглаж байна.

**Хүснэгт 4. Бодит ДНБ-ийн өсөлтийн төсөөлөл, хувиар**

| | 2022Т | 2023Т | 2024Т | 2025Т | 2026Т |
|---|---|---|---|---|---|
| Дэлхийн банк | 2.5% | 6.2% | | | |
| АХБ | 2.3% | 5.6% | | | |
| ОУВС | 2.0% | 7.0% | 6.5% | 6.0% | 5.5% |
| **Дундаж** | **2.3%** | **6.3%** | **6.5%** | **6.0%** | **5.5%** |

*Эх сурвалж: Дэлхийн банк, АХБ, ОУВС, Монголбанк*



numur САХ он сар өдөр БҮРТГЭВ
Үнэт цаасны танилцуулга MONGOLIAN STOCK EXCHANGE БҮРТГЭВ-03
Голомт Капитал ҮЦК ХХК Golomt Capital Delivering diversity 1119289111 5481589 Улаанбаатар хот
НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЗК ХХК 9022080593 6862705 СБТ19638

**Инфляц**

2020 онд Ковид-19 цар тахлын нөлөөгөөр Монгол Улсын дотоодын эрэлт буурч, импорт агшсан, нефтийн үнэ олон улсын зах зээлд буусантай холбоотойгоор инфляцын түвшин 2.3 хувьд хүрч буурсан.

Харин 2021 оны 3 сараас нийлүүлэлтийн шинжтэй хүчин зүйлсээс хамаарч инфляцын түвшин өссөнөөр 2021 оны эцэст улсын хэмжээнд 13.4 хувь, Улаанбаатар хотын хэмжээнд 14.8 хувьд хүрсэн.

**График 3. Инфляцийн түвшин хувиар**




*Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо*

2021 оны байдлаар Монгол улсын хэмжээнд дараах шалтгааны улмаас инфляцын түвшин 13.4 хувьтай гарч, богино хугацааны нийлүүлэлтийн гаралтай инфляц үүссэн байна. Үүнд: 1-рт эдийн засаг хямралын хүнд үеэс сэргэж байгаа нь инфляцыг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлж байна, 2-рт дэлхийн зах зээл дээрх нефтийн үнэ өссөнөөс үүдсэн бензиний үнийн огцом өсөлт, 3-рт өргөн хэрэглээний бараа, хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт (цар тахлын нөхцөлөөс шалтгаалан дэлхийн хүнсний индекс өссөн).

Тодруулбал, 2020 оны 12 сард газрын тосны үнэ олон улсын зах зээлд 1 баррель нь 48 ам.доллар байсан бол 2021 оны эцэст дунджаар 75 ам.долларт хүрч 56 хувиар өссөн нь импортын голлох бүтээгдэхүүн болох шатахууны үнийг өсгөх суурь нөхцөл болсон.

Цаашид цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах чиглэлээр Засгийн газар болон Монголбанкнаас хэрэгжүүлж буй эрэлтийг дэмжих бодлогын арга хэмжээнүүд нь богино хугацаанд эрэлтийн шинжтэй инфляцыг өсгөх хандлагатай байна.

Монголбанк нь 2021-2023 онд мөнгөний бодлогыг зах зээлийн зарчимд тулгуурлан хэрэгжүүлж, инфляцын түвшнийг 6 хувийн зорилтод түвшинд тогтвортой барих бодлоготой байна. Монголбанк, ОУВС, АХБ-ны шинжээчид

инфляцын түвшнийг 2022 онд дунджаар 13.4 хувь, 2023 онд дунджаар 10.2 хувьд хүрнэ гэж таамаглаж байна.

**Хүснэгт 5. Инфляцын төсөөлөл, хувиар**

| | 2022Т | 2023Т | 2024Т | 2025Т | 2026Т |
|---|---|---|---|---|---|
| Монголбанк | 12.3% | 6.5% | 7.0% | 7.0% | 7.0% |
| АХБ | 12.4% | 9.5% | | | |
| ОУВС | 15.5% | 14.5% | 10.8% | 9.0% | 7.5% |
| Дундаж | 13.4% | 10.2% | 8.9% | 8.0% | 7.3% |

*Эх сурвалж: Дэлхийн банк, АХБ, ОУВС, Монголбанк*

**Төсвийн сектор**

Монгол Улсын Засгийн газраас Ковид-19 цар тахлын улмаас үүссэн эдийн засгийн хямралаас иргэд, аж ахуйн нэгжийг хамгаалах зорилгоор татварын чөлөөлөлт, зорилтод бүлэгт чиглэсэн тэтгэмжийг нэмэгдүүлснээр 2020 онд Монгол Улсын төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 4.5 их наяд төгрөгийн алдагдалтай гарсан.

2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр Монгол Улсын төсвийн орлого 14.3 их наяд төгрөгт, төсвийн зарлага 15.6 их наяд төгрөгт тус тус хүрч, төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2.9 их наяд төгрөгийн алдагдалтай гарч өмнөх оны мөн үеэс 1.5 их наяд төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

**График 4. Төсвийн тэнцэл (тэрбум төгрөг)**




*Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо*

2021 оны 11 сарын 12-ны өдрийн Улсын Их Хурлаар 2022 оны төсвийг баталсан. Тус хурлаар Монгол Улсын төсвийн нэгдсэн орлогыг 16.4 их наяд төгрөг, төсвийн нэгдсэн зарлагыг 18.2 их наяд төгрөг, төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 2.4 их наяд төгрөг буюу ДНБ-ий 5.1 хувьтай тэнцэх хэмжээний алдагдалтай байхаар тусгасан.

## Гадаад сектор

Монгол Улсын эдийн засаг уул уурхайн бүтээгдэхүүний экспортын орлого, хөрш орнуудын эдийн засгийн нөхцөл байдлаас өндөр хамааралтай буюу гадаад хүчин зүйлийн шокт мэдрэг шинж чанартай.

2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр Монгол Улсын экспорт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 22.4 хувиар өсөж 9.2 тэрбум ам.долларт, импорт 28.3 хувиар өсөж 6.8 тэрбум ам.долларт, улмаар гадаад худалдааны тэнцэл 2.4 тэрбум ам.долларын ашигтай гарсан. Үүнд олон улсын зах зээл дэх уул уурхайн түүхий эдийн үнэ нэмэгдсэн болон экспортын гарц нэмэгдсэн нь голчлон нөлөөлсөн.

Харин төлбөрийн тэнцэл 436.4 сая ам.долларын алдагдалтай гарсан ба үүнд урсгал дансны алдагдал өмнөх оноос 512.2 сая доллароор өссөн нь нөлөөлсөн байна.

**График 5. Гадаад худалдааны тэнцэл (сая ам.доллар)**




*Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо*

БНХАУ-ын эдийн засаг эрчимтэй сэргэж, олон улсын зах зээл дэх уул уурхайн түүхий эдийн үнэ өсөж байгаа нь Монгол Улсын экспортод дунд хугацаанд эергээр нөлөөлөхөөр байна. Монгол улсын хувьд түүхий эдийн үнэ өсөж буйтай холбоотойгоор экспортын дүн өсөж байгаа хэдий ч бодит гарцын хэмжээ бууралттай байна. 2022 оны эхний сарын байдлаар гадаад худалдааны тэнцэл 17 сая ам. Долларын алдагдалтай байна.

## Мөнгөний сектор

Дэлхийн улс орнууд мөнгөний зөөлөн бодлого хэрэгжүүлж АНУ-ын инфляц 8.3 хувь давж сүүлийн 40 жилийн дээд түвшинд хүрээд байгаа энэ үед Монголбанк мөн адил инфляцыг барих зорилгоор бодлогын хүүг 6 хувиас 9 хувь хүргэж нэмэгдүүллээ.

2021 онд М2 мөнгөний нийлүүлэлт 27.9 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 15 хувиар өссөн. Үүнд өсөлтийн 9.1 нэгж хувийг төгрөгийн харилцах, 6.8 нэгж хувийг төгрөгийн хадгаламж, 1.5 нэгж хувийг гадаад валютын харилцах, -2.8 нэгж хувийг гадаад валютын хадгаламж тус тус бүрдүүлж байна.

Харин 2022 он гарснаар бодлогын хүүг 3.5 хувиар нэмэгдүүлж цаашдаа тогтмол 0.5 хувиар чангатгах төлөвтэй байна. Ингэснээр мөнгөний нийлүүлэлт 2022 оны 4 сард 27.3 их наяд төгрөгт тогтвортой байна. Мөн гадаад валютын татан төвлөрүүлсэн хөрөнгөнд тооцох заавал байлгах нөөцийн хувийг 3 нэгж хувиар нэмэгдүүлж 18 хувьд хүргэх багц шийдвэрийг гаргаад байна.

**График 6. М2 мөнгөний нийлүүлэлт (их наяд төгрөг)**




*Эх сурвалж: Монголбанк, Үндэсний Статистикийн Хороо*

Ковид-19 цар тахлаас үүдэлтэй эдийн засгийн хямрал, худалдаа тээвэрлэлтийн зогсонги байдал, дотоодод хөл хорио тогтоосон зэрэг шалтгаанаас болж иргэд, аж ахуйн нэгжийн хэвийн үйл ажиллагаа тасалдаж, хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдсэн.

2021 оны 2-р улирлаас эдийн засаг аажмаар сэргэж эхэлснээр банкнуудын зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 21.7 хувиар өсөж, 19.2 их наяд төгрөгт хүрсэн.

**Валютын ханш**

Төгрөгийн ам.доллартой харьцах ханш сүүлийн жилийн хугацаанд 2,850 төгрөгийн орчимд тогтвортой байсан бол 2022 он гарснаар 3,100 төгрөгт хүрсэн. Монгол банкны зүгээс тогтмол интервенц хийж байгаа хэдий ч төлбөрийн тэнцэл 221 сая ам.долларын алдагдалтай гарсан нь валют чангарах эрсдэл бий болгож байна. Цаашдаа экспортын бүтээгдэхүүн тасалдвал ханш 3,300 төгрөгт хүрч өсөх магадлалтай байна.

Монгол Улсын гадаад валютын нөөц оны сүүлээр 589 саяар буурч 2022 оны 1 сарын байдлаар 3.9 тэрбум ам.долларт хүрлээ. Түүнчлэн 2021 оны 6 сард

Монгол Улсын Засгийн газар 2022 онд төлөгдөх Чингис бонд, 2023 онд төлөгдөх Гэрэгэ бондын нийт 1 тэрбум ам.долларын төлөлтийг бага түвшний хүүтэйгээр дахин санхүүжүүлснээр дунд хугацаанд валютын гадагшлах урсгалыг бууруулж, төгрөгийн ам. Доллартой харьцах ханшийн дарамтын багасгасан хэдий ч гадаад худалдааны тэнцэл алдагдалтай гарч эхэлсэн нь ханшийн өсөлтөд нөлөөлж байна.

**График 7. ГВАН (сая ам.доллар) vs. төгрөгийн эсрэг ам.долларын ханш**




*Эх сурвалж: Монголбанк*

## 2.2. Хөрөнгийн зах зээлийн нөхцөл байдал

Монгол Улс нь 1990 онд зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжсэн он жилүүд буюу 1991 оны 1-р сарын 18-ны өдөр Монголын Хөрөнгийн Бирж (МХБ)-ийг үүсгэн байгуулснаар хөрөнгийн зах зээл хөгжих суурийг тавьсан. Тус хугацаанд 8.2 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 475 компанийн 96.1 сая ширхэг хувьцааг 1.3 сая иргэдэд цэнхэр, ягаан тасалбараар тарааж анхны өмч хувьчлалыг хийсэн түүхтэй. Харин 2021 оны байдлаар МХБ-д албан ёсоор идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг 54 гишүүн үнэт цаасны компани, 179 хувьцаат компани бүртгэлтэй байна.

**Хүснэгт 6. Хөрөнгийн зах зээлийн голлох үзүүлэлтүүд**

| Үзүүлэлт | Нэгж | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021 |
|---|---|---|---|---|---|---|
| Зах зээлийн үнэлгээ | Их наяд төг | 1.47 | 2.43 | 2.5 | 2.7 | 6.0 |
| ҮЦК-иудын нийт хөрөнгө | Тэр.төг | 92.8 | 81.2 | 86.2 | 86.6 | 114.4 |
| Арилжааны тоо ширхэг | Сая ширхэг | 114.3 | 667.2 | 450.4 | 403.0 | 406.8 |
| Арилжааны дүн | Тэр.төг | 859.2 | 244.1 | 143.2 | 65.3 | 1,414.2 |
| Хувьцаа | Тэр.төг | 76.4 | 210.0 | 133.5 | 53.9 | 304.9 |
| Бонд | Тэр.төг | 782.7 | 34.1 | 9.7 | 6.4 | 1,048.2 |
| ХБҮЦ | Тэр.төг | | | | | 4.2 |
| Хамтын сан | Тэр.төг | - | - | - | 5.1 | 56.8 |

*Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж*

Өнгөрсөн он жилүүдэд Монгол Улсын санхүүгийн зах зээл нь банк төвтэй, хөгжлийн ганц тулгууртай байсан. Тодруулбал, 2020 оны байдлаар банкны салбар санхүүгийн салбарын нийт хөрөнгийн 86.6 хувийг бүрдүүлж байсан.

2021 оны байдлаар банкны хөрөнгийн хэмжээ өмнөх оны эцэстэй харьцуулахад 4.3 их наяд төгрөгөөр өссөн ч банкны салбарын санхүүгийн салбарт эзлэх хувь 81.3 болж буурсан. Нөгөө талаас хөрөнгийн зах зээлийн санхүүгийн салбарт эзлэх хувь 11.8 хувьд хүрч, 5 хувиар өссөн нь хөрөнгийн зах зээл идэвхжиж байгааг илэрхийлж байна.

Уул уурхайн салбарын өсөлт, эдийн засгийн идэвхжил болон гадаадын шууд хөрөнгө оруулалтын нөлөөгөөр 2011 онд Монголын хөрөнгийн зах зээл ДНБ-ний 16.5 хувьтай тэнцэж байсан ч тасралтгүй буурсан юм. 2017 онд хөрөнгийн зах зээлд шинэ бүтээгдэхүүнүүд гарч, хөрөнгө оруулагчдын эрэлт нэмэгдсэнээр хөрөнгийн зах зээл эргэн идэвхэжсэн.

2017 оноос хойш Монголын хөрөнгийн зах зээл дээр олон нийтэд хувьцаагаа санал болгож бүртгүүлэх компанийн тоо эрс нэмэгдэж, нийт 13 компани болон хамтын хөрөнгө оруулалтын сан 130.2 тэрбум төгрөгийг хөрөнгийн зах зээлд татан төвлөрүүлсэн. Үүнээс 79 хувийг санхүүгийн салбарын компаниуд бүрдүүлж байна.

2020 оны байдлаар Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ ДНБ-ий 8.2 хувь буюу 3.0 их наяд төгрөгөөр хэмжигдэж байсан бол 2021 оны байдлаар 5.8 их наяд төгрөгт хүрч, 2021 оны ДНБ-тэй харьцуулахад 13.5 хувийг бүрдүүлж байна.

Энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад харьцуулахад 93.3 хувиар өссөн үзүүлэлт юм. Хөрөнгийн зах зээлийн үнэлгээний 50 хувийг бүрдүүлэгч томоохон хувьцаат компаниудын үнэлгээ 2021 оны эцсийн байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1-7 дахин өссөн нь голлох нөлөө үзүүлсэн байна.

2021 оны байдлаар МХБ-д арилжаалагддаг хөрвөх чадвар болон зах зээлийн үнэлгээгээр тэргүүлэгч 20 хувьцааны хөдөлгөөнийг харуулдаг ТОП-20 индекс өмнөх оны эцэстэй харьцуулахад 130 хувиар өссөн.

Түүнчлэн хувьцааны бүртгэлийн II дугаар ангиллын хувьцаануудыг илэрхийлдэг MSE-B индекс 61 хувь, хувьцааны бүртгэлийн I дүгээр ангиллын хувьцаануудыг илэрхийлдэг MSE-A индекс 70 хувийн өсөлтийг тус тус үзүүлсэн.

**График 8: МХБ-ийн индексүүд, оны эхэн үетэй харьцуулахад**




*Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж*

2021 онд хөрөнгийн зах зээлийн арилжаа идэвхжиж, 4-р сард арилжааны хэмжээ түүхэн дээд хэмжээ болох 34 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 14 дахин өссөн үзүүлэлт юм.

Түүнчлэн 2021 онд хамгийн анхны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас болох "Инвескор Актив ТЗК" ХХК-ийн ХБҮЦ нийтэд санал болгон амжилттай арилжаалагдсан. Бондын анхдагч зах зээлд нийт 3 компанийн 720.1 тэрбум төгрөгийн бонд амжилттай арилжаалагдсан бол хоёрдогч зах зээл дээр 328.1 тэрбум төгрөгийн бонд арилжаалагдсан байна.

**Хүснэгт 7. Бондын анхдагч зах зээлийн арилжаа**

| БОНД | ҮНИЙН ДҮН |
|---|---|
| Эрдэнэс таван толгой ХК – ЭТТ бонд /төг/ | 236,551,700,000.00 |
| Эрдэнэс таван толгой ХК – ЭТТ бонд /ам.дол/ | 111,184,770,000.00 |
| Инвескор ББСБ – Инвескор бонд | 8,000,000,000.00 |
| ЛэндМн ББСБ – Лэнд бонд | 5,000,000,000.00 |
| Инвескор ББСБ – Инвескор бонд транч 2 | 6,000,000,000.00 |
| Эрдэнэс таван толгой ХК – ЭТТ бонд транч 2 /төг/ | 164,471,100,000.00 |
| Эрдэнэс таван толгой ХК – ЭТТ бонд транч 2 /ам.дол/ | 37,942,667,543.00 |
| Инвескор ББСБ – Инвескор бонд транч 3 | 6,000,000,000.00 |
| Эрдэнэс таван толгой ХК – ЭТТ бонд транч 3 | 142,404,600,000.00 |
| ЛэндМн ББСБ – Лэнд бонд | 2,500,000,000.00 |
| **НИЙТ** | **720,054,837,543.00** |

*Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж*

2021 онд Ковид-19 цар тахлын нөлөөгөөр мөнгөний зөөлөн бодлого хэрэгжиж, Монголбанк бодлогын хүүг түүхэн доод хэмжээ болох 6 хувьд хүргэсэн, нийлүүлэлтийн шинж чанартай инфляц бий болсон зэргээс үүдэн хадгаламжийн бодит өгөөж буурсан нь хөрөнгийн зах зээлийн эрэлтийг нэмэгдүүлсэн. 2022 он гарснаар Олон улсын эдийн засгийн нөхцөл байдал, ОХУ Украйны дайн, хил гаалийн нөхцөл байдлаас үүдэн инфляцын түвшин 14 хувьд хүрсэн нь хөрөнгийн зах зээлийн эрэлтийг цаашид улам идэвхжүүлэх төлөвтэй байна. Тодруулбал, хадгаламжийн бодит өгөөж сөрөг утгатай

болсноор хөрөнгө оруулагчид илүү өндөр өгөөжтэй хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүнийг эрэлхийлж хөрөнгийн зах зээлийн идэвхийг нэмэгдүүлж байна. Сүүлийн жилүүдэд үндэсний томоохон үйлдвэрлэгч компаниуд олон нийтэд нээлттэй хувьцаа болон бонд, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас зэрэг олон төрлийн хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн санал болгож, хөрөнгө оруулалтын сангууд болон мэргэжлийн хөрөнгө оруулагчдын тоо эрчимтэй нэмэгдэж байна. Үнэт цаас гаргагчийн санал болгож буй Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас нь тодорхой өгөөжийн түвшинд эрсдэлийн түвшинг бууруулж хөрөнгө оруулагчийн хөрөнгийн багцыг төрөлжүүлдгээрээ онцлог юм. 2022 он гарснаар 2 дах Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас болох Омни актив ХБҮЦ зах зээлд амжилттай арилжаалагдсан нь зах зээлд тус бүтээгдэхүүний хэрэгцээ шаардлага байгааг илтгэж байна.

## 2.3. ХБҮЦ-ны тухай, давуу болон сул талууд

**Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны зураглал**

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас нь Монгол улсын "Хөрөнгөөр Баталгаажсан Үнэт Цаасны тухай" хуульд зааснаар санхүүгийн мөнгөн урсгал бий болгох хөрөнгөөр баталгаждаг ба хөрөнгө оруулагч нь уг хөрөнгийн орлогоос тэргүүн ээлжид төлбөрөө гаргуулах эрхийг баталгаажуулсан үнэт цаас байна. Тухайлбал, олон улсад хамгийн түгээмэл бүтээгдэхүүн болох АНУ-ын моргейжийн гэрээг багцалсан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас юм. Энгийнээр тайлбарлавал тухайн компанийн ирээдүйд орж ирэх гэрээгээр баталгаажсан мөнгөн урсгалыг багцлан, бүтээгдэхүүн гаргаж ирээдүйн төлбөрийн урсгалын тухайн гэрээгээр баталгаажсан мөнгөн урсгалаар төлөх үйл явц юм.

Схем 1. ХБҮЦ-ны зураглал




**ХБҮЦ гаргах болон үйл ажиллагаа хэвийн явагдахад оролцогч талууд**

**Анхны үүрэг гүйцэтгүүлэгч** – Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т заасанчлан анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь өөрийн санхүүгийн тайлан, тэнцэлд туссан хөрөнгийг тусгай зориулалтын компанид шилжүүлсэн, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд байна.

**Тусгай Зориулалтын компани** – Тус хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т заасанчлан Тусгай Зориулалтын Компани нь Компанийн тухай хууль болон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасан журмын дагуу байгуулагдсан, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрөл авсан хязгаарлагдмал хариуцлагатай компани байна.

**Хөрөнгө Итгэмжлэн удирдагч** – Тус хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-т заасанчлан Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь тусгай зориулалтын компанитай гэрээ байгуулсан, хөрөнгө оруулагчид барьцаалуулсан хөрөнгийн түүний эрх ашигт нийцүүлэн эзэмшиж, удирдах эрх үүрэг бүхий этгээд байна.

**Үйлчилгээ үзүүлэгч** – Тус хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-т заасанчлан Үйлчилгээ үзүүлэгч нь Үнэт цаас гаргагчтай байгуулсан Үйлчилгээ үзүүлэх гэрээний хүрээнд Хөрөнгөтэй холбоотой төлбөр цуглуулан шилжүүлэх, бүртгэх, тайлагнах болон үйлчилгээ үзүүлэх гэрээнд заасан хөрөнгөтэй холбоотой бусад үйлчилгээ, үйл ажиллагаа эрхлэхээр тусгай зориулалтын компанитай гэрээ байгуулсан хуулийн этгээд байна.

**Хуулийн фирм** – Тусгай Зориулалтын компанид шилжин ирэх зээлийн багцад хууль стандартын дагуу шинжилгээ дүгнэлт хийн магадлан шалгаж, хэлцлийн явцад хуулийн зөвлөгөө үзүүлэхээс гадна процесс, батлагдах журмуудад хууль ёсны дагуу дүгнэлт гаргах хуулийн этгээд;

**Аудитийн байгууллага** – Үнэт цаас гаргагчийн зээлийн багц болон санхүү аудитын дүгнэлт гаргах, ТЗК-тай холбоотой аудитын дүгнэлт гаргах этгээд.

**Зээлийн шинжилгээ гаргагч –** Хөрөнгийн багц дахь зээлүүд нь шалгуур үзүүлэлтэд нийцэж буй эсэхэд санхүүгийн дүн шинжилгээ хийх, дүгнэлт гаргах этгээд.

**Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны онцлог**

***Тодорхой байдал***

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас нь Зээлийн багцын ирээдүйн мөнгөн урсгалаар баталгаажсан байдаг. Цаашлаад зээлийн үндсэн хүү, төлөгдөх хугацаа, үе шатлал зэрэг нь хуваарийн дагуу явагддаг учир мөнгөн хөрөнгө эргэн төлөгдөх баталгаат урсгалтай.

***Найдвартай байдал***

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн тайлан балансаас зээлийн багцыг хасаж ТЗК-д шилжүүлснээр тусдаа хяналтын бүтцэд оруулдаг.

***Эрсдэлийг бууруулна***

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн тайлан балансаас зээлийн багцыг хасаж бүртгэсний хүрээнд компанийн аливаа эрсдэл, мөнгөн хөрөнгө тасалдал, дампуурал зэрэг нь хөрөнгөөр баталгаажсан зээлийн багцад нөлөө үзүүлэхгүй.

***Өндөр өгөөж***

ХБҮЦ-ны өгөөжийн түвшин өндөр тогтох боломжтой байдаг ба эрсдэлээр жигнэсэн өгөөжийн хувьд харьцангуй өндөр.

***Менежмент***

Зээлийн багцыг шаардах эрхийг Тусгай Зориулалтын Компанид шилжүүлэхээс гадна хөрөнгө итгэмжлэн удирдагч нь зээлийн багцад хяналт тавьснаар олон талт менежментийн системийг бий болгоно.

***Үнэт цаасжуулаалт***

Тусгай зориулалтын компани нь ирээдүйн орлогоо барьцаалан шинээр санхүүжилт татах боломжтой байдаг. Мөн ББСБ-ын хувьд бусад санхүүжилтийн хэрэгсэл болох бонд, өр төлбөр, итгэлцэл зэрэг нь хуулийн хүрээнд хязгаарлагдмал байдаг бол ХБҮЦ гаргах нь тодорхой хязгаарлалт дүн байдаггүй.

numur
2022 09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
Эрсдэл

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2022-09-21
БҮРТГЭВ-03

Компанийн зээлийн багцыг салгаж дампуурах эрсдэлийг хязгаарлаж өгдөг хэдий ч багц зээл нь тасалдах эрсдэлтэй. Мөн харилцаанд орж буй талуудын уялдаа холбоог нарийн тодорхойлж өгөөгүйгээс үүдэн үүргийн гүйцэтгэл хангагдахгүй байх, ХБҮЦ-ын эргэн төлөлтийн үйл ажиллагаа тасалдах магадлалтай. Түүнчлэн ТЗК-ийн баталсан журмуудыг баримталж ажиллахгүй байх эрсдэл гарах магадлалтай.

Дотоодын Хөрөнгийн зах зээлд “Монголын Ипотекийн Корпораци ОССК” ХХК 2013 оноос эхлэн ХБҮЦ гаргах үйл ажиллагаа явуулж байна. Үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш 28 удаагийн хэлцлээр нийт 4.6 их наяд төгрөгийн орон сууцны ипотекийн зээлийн арилжаалсан байна.

2021 онд “Инвескор ББСБ” ХК, 2022 онд “Омни Актив ББСБ” ХХК нь Монголын Хөрөнгийн бирж ХБҮЦ гарган амжилтай арилжаалсан байна.

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас нь дараах хоёр төрлөөс бүрдэнэ. 1) Баталгаат үнэт цаас, 2) Барьцаат үнэт цаас.

| | 1) Баталгаат үнэт цаас | 2) Барьцаат үнэт цаас |
|---|---|---|
| Үнэт цаас гаргагч | Тусгай зориулалтын компани | Орон сууцны санхүүжилтийн компани, Банк |

1) **Баталгаат үнэт цаас нь**
   Хөрөнгийг анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үнэт цаас гаргагчийг үүсгэн байгуулагч, худалдагчийн санхүүгийн тайлан, тэнцлээс хасаж, хөрөнгөтэй холбоотой шаардах эрх болон олох орлогыг тусгай зориулалтын компанийн санхүүгийн тайлан, тэнцэлд шилжүүлэн анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үүсгэн байгуулагч, худалдагчийг хөрөнгөтэй холбоотой үүргээс бүрэн чөлөөлснийг гэрчилсэн үнэт цаас байна.

2) **Барьцаат үнэт цаас нь**
   Үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайлан, тэнцэлд тусгаарлан бүртгэгдсэн, орон сууцны зээлийн болон хуулиар зөвшөөрсөн бусад үл хөдлөх эд хөрөнгийн барьцаатай холбоотой шаардах эрхээр баталгаажсан, үнэт цаасны танилцуулгад заасан хугацаанд үндсэн төлбөр, түүний хүүг хөрөнгө оруулагчид төлөх үүргийг гэрчилсэн үнэт цаас байна.

Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Delivering diversity
1119289111 5481589
Улаанбаатар хот



УЛААНБААТАР ХОТ
НӨМӨР КРЕДИТ АССЕТ ҮЦК ХХК
9022080593
6862705 СБТ19638

numur
2022.09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 1

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-09-29
БҮРТГЭВ-03

**Схем 2. ХБҮЦ хөгжил**




**Хүснэгт 8. Үнэт цаас худалдан авагчид үүсэх давуу тал**

| Давуу тал | Сул тал |
|---|---|
| • Аюулгүй байдал/ Компанийн эрсдэлийг хааж өгсөн/<br>• Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн үйл ажиллагаа тасалдах, дампуурсан тохиолдолд ч ХБҮЦ хэвийн төлөгдөнө.<br>• Худалдан авагчдын мөнгөн урсгал орж ирэх хугацаа, төлбөр төлөх дараалал тодорхой<br>• Гэрээлэгдсэн учир эргэн төлөлтийн мөнгөн урсгал орж ирэх эх үүсвэр тодорхой.<br>• Биржээр дамжуулж хугацааны өмнө борлуулах боломжтой өндөр | • Эргэн дуудах нөхцөл<br>Зээлийн багцын төлөлт хугацаанаас өмнө орж ирсэн тохиолдолд ХБҮЦ-ыг эргэн дуудах нөхцөлтэй гаргадаг. Ингэснээр худалдан авсан хөрөнгө оруулагчид хугацаанаас өмнө эргэн төлөлтөө авах магадлалтай. "Нөмөр Кредит Ассет ТЗК" ХХК-ийн гаргаж буй ХБҮЦ-ны хувьд ХБҮЦ-ны тухай хуульд заасныг бусад тохиолдолд эргэн дуудаж төлөлт хийх нөхцөлгүй тул энэхүү эрсдэлийг хаасан байна.<br>• Бүтцийн эрсдэл<br>ХБҮЦ-тай холбоотой оролцогч талуудын уялдаа холбоог журам бүтцээр зохицуулаагүй тохиолдолд үүргийн гүйцэтгэл хангагдахгүй мөнгөн урсгалд эрсдэл үүсэх |

Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Delivering diversity
1119289111 5481589
Улаанбаатар хот



УЛААНБААТАР ХОТ
НӨМӨР КРЕДИТ ХХК
9022080593
6862705 СБТ19638

**Схем 3. Санхүүгийн бүтээгдэхүүнүүдийн эрсдэл өгөөжийн түвшин**




Аливаа Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний эрсдэл болон өгөөжийн түвшин шууд хамааралтай байдаг бөгөөд өгөөжийн түвшин өсөхийн хэрээр хөрөнгө оруулалтын эрсдэлийн түвшин нэмэгддэг. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас нь тогтмол өгөөжтэй, эрсдэлийн түвшин харьцангуй бага бүлэгт харьяалагдана. Тодруулбал, Нөмөр Кредит Ассет ТЗК ХХК-ийн гаргаж буй бүтээгдэхүүний хувьд эрсдэлийн түвшин нээлттэй бондтой ижил түвшинд хэдий ч хаалттай бондын өгөөжийн хэмжээтэй дүйцэхүйц хэмжээний хүүг санал болгож байна.

**График 9. ХБҮЦ-ны зах зээлийн өсөлт**




*Эх сурвалж: SIFMA*

Моргейжийн зээлээр баталгаажсан үнэт цаасыг (MBS) хөрөнгөөр баталгаажсан үнэт цааснаас (ABS) салган авч үздэг. Хамгийн анх 1968 онд Моргейжийн зээлээр баталгаажсан үнэт цаас зах зээлд түгээмэл байсан бол

1985 оноос хойш хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас бий болж тус зах зээлийн хэмжээ жилд дунджаар 38 хувийн өсөлтийг үзүүлсэн. 2021 оны байдлаар Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны зах зээлийн үнэлгээ 1.6 триллион ам.долларт хүрсэн. Зах зээлийн дийлэнх хэсэг болох 51.7 хувийг барьцаалсан өрийн хэрэгсэл (CDO) буюу олон төрлийн өрийн хэрэгслийг багцалсан бүтээгдэхүүнүүд болон барьцаалсан зээлийн хэрэгсэл (CLO) буюу олон төрлийн компанийн зээлийг багцалсан бүтээгдэхүүн эзэлдэг байна. Тэр дундаа кредит картын зээлээр баталгаажсан багцын өрийн хэрэгсэл жилд дунджаар 17 хувиар буюу ойролцоогоор 37 тэрбум ам.доллароор жил бүр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

**График 10. ХБҮЦ-ны бүтээгдэхүүний 2021 оны зах зээлд эзлэх хувь**




*Эх сурвалж: SIFMA*

**ХБҮЦ-ны түгээмэл бүтээгдэхүүн**

Олон улсад түгээмэл хэрэглэгддэг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хэлбэрүүдэд: Моргейжийн зээлээр баталгаажсан үнэт цаас (5.5 триллион ам.долларын зах зээл), **RMBS** буюу орон сууцны моргейжийн зээлээр баталгаажсан, **CMBS** буюу худалдааны төв томоохон орон сууцны зээлээр баталгаажсан, **CDOs** буюу олон төрлийн бүтээгдэхүүний холимог зэрэг бүтээгдэхүүнүүд багтана. Мөн түүнчлэн автомашины зээлээр баталгаажсан үнэт цаас (220.6 тэрбум ам.долларын зах зээл), Кредит картны зээлээр баталгаажсан үнэт цаас (146.0 тэрбум ам долларын зах зээл) зэрэг бүтээгдэхүүнүүд түгээмэл байна.

**Схем 4. ХБҮЦ төрлүүд**



# ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ

# 3 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ

## 3.1 Үнэт цаас гаргагчийн ерөнхий мэдээлэл

Үнэт цаас гаргагч "Нөмөр Кредит Ассет ТЗК" ХХК нь 2022 оны 05 сарын 03 -ны өдөр санхүүгийн тайлан баланс бэлтгэх гаргах түүнтэй холбоотой зөвлөгөө өгөх үндсэн чиглэлийн хүрээнд үүсгэн байгуулагдсан.

| Үнэт цаас гаргагч | Нөмөр Кредит Ассет ТЗК ХХК |
|---|---|
| Улсын бүртгэлд бүртгүүлсэн огноо | 2022 оны 05 сарын 03 |
| Регистрийн дугаар | 6862705 |
| Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ | 1,000,000 (нэг сая) төгрөг |
| Гаргасан болон зарласан хувьцааны тоо | Нэг бүр нь 10,000 төгрөгийн үнэ бүхий 100 хувьцаа |
| Улсын бүртгэлийн дугаар | 9011839181 |
| Үйл ажиллагааны үндсэн чиглэл | Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах |
| Хаяг | Улаанбаатар, Баянгол, 2-р хороолол, Энхтайваны өргөн чөлөө, 46 байр 806 тоот |
| Утас | 75111133 |

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн улсын бүртгэлийн гэрчилгээ*

## 3.2 Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагчийн тухай

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу Тусгай зориулалтын компанийг банк, банк бус санхүүгийн байгууллага, орон сууцны санхүүжилтийн компани болон Хорооноос зөвшөөрсөн санхүүгийн бусад байгууллага байгуулж болно гэж заасан тул Үнэт цаас гаргагчийг хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдсан банк бус санхүүгийн байгууллага болох Нөмөр Кредит ББСБ ХХК нь 2022 оны 05 сарын 03-ны өдөр үүсгэн байгуулсан.

Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагч болох Нөмөр Кредит ББСБ ХХК нь 2015 оны 02 сард үүсгэн байгуулагдсан бөгөөд Санхүүгийн Зохицуулах Хорооны зээл болон итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа явуулж байна.

Үүсгэн байгуулагч нь Үнэт цаас гаргагчийн энгийн хувьцаа эзэмшлийн 100 хувь болох нэг бүр нь 10,000 төгрөгийн 100 ширхэг нийт 1,000,000 төгрөгийн үнийн дүн бүхий энгийн хувьцааг эзэмшиж байна.

**Хүснэгт 9. Хувьцаа эзэмшлийн бүтэц**

| № | Хувьцаа эзэмшигч | Тоо ширхэг | Нэгж үнэ /төгрөг/ | Нийт /төгрөг/ | Дүрмийн санд эзлэх хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | Нөмөр Кредит ББСБ ХХК | 100 | 10,000 | 1,000,000 | 100% |

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн улсын бүртгэлийн гэрчилгээ*

### 3.3 Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн мэдээлэл

Үнэт цаас гаргагчийн дүрмийн 6-р зүйлийн 6.2. дахь хэсэгт зааснаар ТУЗ нь компанийн үйл ажиллагааг удирдаж хяналт тавина. ТУЗ нь Компанийн дүрмээр ХЭХ бусад буюу дараах бүрэн эрхийн хүрээнд үйл ажиллагаа явуулна. Үүнд:

- ТУЗ нь компанийн үйл ажиллагааг удирдаж, хяналт тавина.
- ТУЗ нь 3 гишүүний бүрэлдэхүүнтэй байх ба гишүүд нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон Хорооны журамд заасан шаардлагыг хангасан этгээд байна.
- ТУЗ-ийн гишүүдийн олонхи нь хараат бус гишүүн байх ба ТУЗ-ийн дарга нь хараат бус гишүүн байна.
- ТУЗ-ийн гишүүдэд тавих шаардлага болон ТУЗ-ийн гишүүдийг сонгох, чөлөөлөх болон үйл ажиллагааг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар нарийвчлан зохицуулна.
- ТУЗ-ийн ажил үүргээ хэрэгжүүлэх үндсэн хэлбэр нь ТУЗ-ийн хурал байна. ТУЗ ийн ирц 100 хувийн бүрэлдэхүүнтэй оролцсон тохиолдолд хурлыг хүчинтэйд тооцно.
- ТУЗ нь эчнээ санал хураалтаар шийдвэр гаргаж болно. ТУЗ нь эчнээ санал хураалтаар шийдвэрлэх асуудлаар телеконференци, видеоконференци хийх замаар саналаа солилцон, хэлэлцэж, болно. Эчнээ санал хураалтаар шийдвэр гаргах үед саналаа саналын хуудсаар өгнө. Саналын хуудсыг цахим хэлбэрээр хүргүүлж болох ба энэ тохиололд саналын хуудсанд ТУЗ-ийн гишүүд нь тоон гарын үсэг зурсан байна.
- ТУЗ-ийн хурлаар хэлэлцэх асуудлыг гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ. Шийдвэрлэсэн асуудлаар ТУЗ-ийн хурлын тогтоол гаргаж ТУЗ-ийн дарга гарын үсэг зурж, компанийн тамга тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.
- ТУЗ нь холбогдох хуульд тогтоомж болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан эрх хэмжээг хэрэгжүүлнэ.
- ТУЗ-ийн ээлжит хурлыг улиралд нэгээс доошгүй удаа хуралдуулна.
- ТУЗ-ийн ээлжит бус хурлыг ТУЗ-ийн дарга, түүнийг гишүүд, анхны үүрэг гүйцэтгүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагч, хэлцэл эрхлэн гүйцэтгэгч, үүсгэн байгуулагчийн хүсэлтээр хэдийд ч зарлан хуралдуулж болно.
- ТУЗ-ийн даргын эзгүйд түүний үүргийг ТУЗ-ийн даргын томилсон эсхүл хурлаас шийдвэрлэсэн аль нэг гишүүн гүйцэтгэнэ.
- ТУЗ-ийн дарга ТУЗ-ийн үйл ажиллагааг зохион байгуулж, ТУЗ-ийн хурал хуралдуулах, даргалах, хурлын тэмдэглэл хөтлүүлэх, гаргасан шийдвэрт хяналт тавих үүргийг хүлээнэ.

Үнэт цаас гаргагчийн 2022 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь 3 гишүүнтэй байхаар шийдвэрлэсэн.

Голомт Капитал ҮЦК ХХК

УЛААНБААТАР ХОТ
НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЗК

### 3.1.1. ТУЗ-ийн гишүүдийн мэдээлэл

**❖ ТУЗ-ийн хараат бус гишүүн Н.Баасанхүү**

Н.Баасанхүү нь Мандах бүртгэл их сургуулийг нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр бакалаврын зэрэг хамгаалсан. Тэрээр Монтермо ХХК-д санхүүгийн шинжээчийн албыг хашиж байна .

**❖ ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Рэнцэнханд**

Б.Рэнцэнханд нь БНХАУ-ын Газрын тосны Их Сургуулийг санхүүгийн удирдлагын бакалавр, Санхүү Эдийн Засгийн Их Сургуулийг бизнесийн удирдлагын чиглэлээр магистрын зэрэг тус тус хамгаалсан. Тэрээр Доншен ХХК-д захиргааны менежерээр ажилласан туршлагатай. Одоогоор Голомт банкинд корпорэйт менежерээр ажиллаж байна.

**❖ ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Эрдэнэжаргал**

Б.Эрдэнэжаргал нь Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийг эрх зүйч мэргэжлээр бакалаврын зэргийг дүүргэсэн. Тэрээр Моннис Интернэшнл ХХК-д хуулийн зөвлөх, Өмгөөллийн ёс ХХН хуульч өмгөөлөгчөөр ажилласан туршлагатай. Одоогоор Апу Дэйри ХХК-ийн хуулийн зөвлөхөөр ажиллаж байна.

### 3.1.2. ТУЗ-ийн эрх үүрэг

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2022 оны 05 сарын 04 -ний өдрийн 05 /04-1 тоот шийдвэрээр ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг баталсан. Тус журамд ТУЗ-ийн эрх үүргийн талаар дараах байдлаар заасан байна.

ТУЗ нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

- Компанийн дүрмийн хэрэгжилтийг хангах, хангуулах;
- Компанийн дүрэм, үнэт цаасны танилцуулга, үнэт цаас гаргах, Компани байгуулагдсан гэдэгт баталгаа гаргах;
- Компанийн хөрөнгийг хадгалж хамгаалах;
- Хөрөнгө оруулагч болон бусад эрх бүхий этгээдэд мэдээллийг тогтмол цаг тухайд нь хүргэх;
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны танилцуулгад тусгагдсан шаардлагын биелэлтийг хангах;
- Компанийн нэр дээр данс нээх, аудит, тайлан бүртгэлийг хянах, хөрөнгө оруулагчдад төлөх төлбөр болон бусад төлбөр, зардлын төсвийг батлах;
- Хууль, журам болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бусад үүрэг.

ТУЗ-ийн гишүүн дараах эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ. Үүнд:

- Аливаа шийдвэр гаргахаас өмнө шаардлагатай мэдээлэлтэй танилцах;
- ТУЗ-ийн хурлын үйл ажиллагаанд тогтмол, идэвхтэй оролцох;



numur САХ он сар өдөр БҮРТГЭВ
Монголын Хөрөнгийн бирж 2022-09-20
Голомт Капитал ҮЦК ХХК Golomt Capital 1119289111 5481589 Улаанбаатар хот
УЛААНБААТАР ХОТ НӨМӨР КРЕДИТ ХХК 9022080593 6862705 СБТ19638

ТУЗ-ийн хурлаар хэлэлцэх асуудлаар өөрийн авсан мэдээлэл, мэдлэг боловсрол, ажлын туршлагад тулгуурлан үндэслэл бүхий санал өгөх;
- ТУЗ-ийн хуралд биечлэн оролцох бөгөөд хүндэтгэн үзэх шалтгааны улмаас биечлэн оролцох боломжгүй, эсхүл хоцорч оролцох тохиолдолд энэ талаар ТУЗ-ийн дарга болон нарийн бичгийн даргад урьдчилан мэдэгдэх;
- Ашиг сонирхлын зөрчил илэрсэн тохиолдолд энэ талаараа нэн даруй мэдэгдэх;
- ТУЗ-ийн дарга болон гишүүд нь нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг Компанид гаргаж өгөх;
- ТУЗ-ийн гишүүд нь хурлын тогтоол болон тэмдэглэлд Компанийн байранд хүрэлцэн ирж гарын үсэг зурж, баталгаажуулах үүрэгтэй;
- ТУЗ-ийн гишүүд хурлаар хэлэлцэх асуудлаар шийдвэр гаргахад шаардагдах бүх мэдээллийг авах эрхтэй бөгөөд шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн мэргэжилтэн, шинжээчийн дүгнэлт, зөвлөмж, саналыг Компанийн зардлаар гаргуулан авч болно.

ТУЗ-ийн хараат бус гишүүн нь дээр дурдсанаас гадна дараах эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ. Үүнд:
- Компанийн дүрэм, журамд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хяналт тавьж, ТУЗ-ийн зарим үйл ажиллагааг хараат бусаар баталгаажуулах;
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хүсэлт гаргах замаар биечлэн оролцож, ТУЗ-ийн зарим шийдвэрийн талаар зарчмын зөрүүтэй байр суурьтай байсан тухайгаа мэдээлэх, Хувьцаа эзэмшигчдээс асуусан асуултад хариу өгөх, тайлбар хийх.
- Компанийн үйл ажиллагаанд ТУЗ-ийн зүгээс тавих хяналтыг үр ашигтай байлгах, гарч болзошгүй сонирхлын зөрчлийг зөв зохистой шударга шийдвэрлэх, хувьцаа эзэмшигчдээс хараат бус байж, шаардлагатай тохиолдолд тэдэнд зөвлөмж, зөвлөгөө өгөх.

## 3.4 Үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайлан

Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагч, анхны үүрэг гүйцэтгүүлэгч болох Нөмөр Кредит ББСБ ХХК нь 1,000,000 төгрөгийн хөрөнгө оруулалттайгаар Нөмөр Кредит Ассет ТЗК ХХК-ийг үүсгэн байгуулсан бөгөөд эхлэлтийн тайлан баланс дараах байдалтай байна.

**Хүснэгт 10. Үнэт цаас гаргагчийн эхлэлтийн тайлан баланс**

| Дансны нэр | Хөрөнгө | Эх үүсвэр |
|---|---|---|
| Мөнгөн хөрөнгө | 1,000,000 | |
| Хувь нийлүүлсэн хөрөнгө | | 1,000,000 |
| **Нийт** | **1,000,000** | **1,000,000** |

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн дүрэм*

СЭХ numur өдөр БҮРТГЭВ №



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ 2022-09-29 БҮРТГЭВ-03

## 3.5 Үнэт цаас гаргагчийн Санхүүгийн төсөөлөл

**Хүснэгт 11. Үнэт цаас гаргагчийн мөнгөн урсгалын төсөөлөл /сая төгрөг/**

| | У1 | У2 | У3 | У4 | У5 | У6 | У7 | У8 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Үндсэн төлбөр | 1,740.2 | 1,735.5 | 1,744.6 | 1,740.3 | 1,723.0 | 1,693.4 | 1,647.7 | 1,490.6 |
| Хүүгийн төлбөр | 914.7 | 856.3 | 775.3 | 683.3 | 582.0 | 473.1 | 358.4 | 242.0 |
| ЗХО-ийн орлого | 15.7 | 50.0 | 87.3 | 127.5 | 18.1 | 63.2 | 108.7 | 153.2 |
| **Нийт орох урсгал** | **2,670.6** | **2,641.8** | **2,607.2** | **2,551.1** | **2,323.1** | **2,229.7** | **2,114.9** | **2,054.1** |
| ЗХО - Нэмж ХА багц | 654.1 | 870.1 | 731.2 | 602.2 | 482.4 | 371.2 | 268.0 | 172.4 |
| ХБҮЦ үндсэн төлбөр | 0.0 | 0.0 | 0.0 | 5,000.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 5,000.0 |
| ХБҮЦ хүүгийн төлбөр | 441.1 | 431.5 | 436.3 | 441.1 | 220.5 | 218.2 | 218.2 | 220.5 |
| ХБҮЦ гаргалтын зардал | 439.2 | 137.3 | 125.1 | 122.2 | 126.9 | 124.5 | 109.7 | 101.5 |
| **Нийт гарах урсгал** | **1,534.4** | **1,438.9** | **1,292.6** | **6,165.5** | **829.9** | **713.8** | **595.8** | **5,494.4** |
| **Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл** | **1,136.2** | **2,339.1** | **3,653.7** | **39.3** | **1,532.5** | **3,048.3** | **4,567.4** | **958.8** |
| Эрсдлийн сан | 24.4 | 19.9 | 16.6 | 13.4 | 10.5 | 7.8 | 5.3 | 3.0 |

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн тооцоолол*

Үнэт цаас гаргагч нь Хөрөнгийн багцын эргэн төлөлтийн орлого болон улирал бүрийн хүүгийн зардал, бусад үйл ажиллагаа хэвийн явуулахтай холбогдох зардлуудыг тооцоолон орлогын тайлангийн төсөөллийг боловсруулсан.

Үнэт цаас гаргагчийн орж ирэх орлого нь үндсэн Хөрөнгийн багцын эргэн төлөлт болон бусад зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалтын орлогоос бүрдэнэ. Орлогын төсөөлөл нь төлөвлөж буй Хөрөнгийн багцын эргэн төлөлтийн хуваарь болон ирээдүйд шинээр орж ирэх Хөрөнгийн багцын төсөөлөл, зах зээлийн дундаж хүүд суурилан тооцоолсон үр дүн юм. Уг үр дүн нь Үнэт цаас гаргагч болон бусад холбогдох хуулийн этгээдүүдийн магадлан шинжилгээний үндсэн дээр хийгдсэн бөгөөд ирээдүйн төсөөллийн талаар ямарваа нэгэн амлалт өгөөгүй болно.

Үнэт цаас гаргагчийн голлох зардал нь Үнэт цаасны хүүгийн зардал байна. Үнэт цаасны хүүгийн зардал урьдчилсан тохирсон хүүгийн түвшин дэх улирал бүрийн хүү төлөлт байна. Түүнчлэн, үйл ажиллагааг хэвийн явуулахтай холбоотой компанийн үндсэн үйл ажиллагааны зардлууд төсөвлөгдсөн. Үүнд, Үйлчилгээ үзүүлэгчдийн сар бүрийн шимтгэл, бусад зохицуулагч байгууллагуудын шимтгэл хураамжууд багтана.

**Хүснэгт 12. Үйл ажиллагааны голлох зардал**

| Голлох үйл ажиллагааны зардал | Тооцоолол | Давтамжит |
|---|---|---|
| Үйлчилгээ үзүүлэгчийн шимтгэл | ХБҮЦ-ны хөрөнгийн багцаас тухайн сард төлөгдсөн нийт төлбөрийн дүнгээс 3 хувь | Сар бүр |



УЛААНБААТАР ХОТ Н. Баасанхүү НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЗК ХХК 9022080593 6862705 СБТ19638

| | | |
|---|---|---|
| Захиргааны үйлчилгээ үзүүлэгчийн ажлын хөлс | 3 сая төгрөг | Сар бүр |
| Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн шимтгэл | ХБҮЦ-ний үлдэгдлээс 0.135 хувь | Сар бүр |

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахтай холбоотой үйл ажиллагаа нь тусгай хуулиар зохицуулагддаг Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа нь хуульд заасны дагуу холбогдох хуулийн этгээдүүдийн үйлчилгээний хөлс, шимтгэл нь голлох зардал болж байна. Түүнчлэн, Үнэт цаас гаргах үйл ажиллагаатай холбогдон Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн бирж, Үнэт Цаасны төвлөрсөн Хадгаламжийн төв, Хуулийн фирм, Аудитын байгууллага, Андеррайтерийн компанид нэг удаагийн болон давтамжит зардлуудыг төлдөг.

**Хөрөнгө оруулагчдад үнэт цаасны төлбөрийг төлсний дараах үлдэгдлийн мэдээлэл**

Үнэт цаасны төлбөрийг бүрэн төлж дууссанаар Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 22.1.1.-д заасан нөхцөл биелэн ТЗК-ийг татан буулгах бөгөөд санхүүгийн төсөөлөлд тусгагдсанаар татан буулгах үед ТЗК нь 2,654.0 сая төгрөгийн хөрөнгөтэй үүнээс 1,695.2 сая төгрөгийн зээлийн хөрөнгийн багц, 958.8 сая төгрөгийн бэлэн мөнгөтэй байна. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 23-д заасны дагуу ТЗК нь татан буугдаж, үүсгэн байгуулагч "Нөмөр Кредит ББСБ" ХХК-д ТЗК-ийн үлдэгдэл хөрөнгийг шилжүүлнэ.

## 3.6 Зөвшөөрөгдсөн данснуудын мэдээлэл

**Төлбөр цуглуулах данс**

ТЗК нь Төлбөр цуглуулах дансыг банканд тусгайлан нээлгэнэ. Төлбөр цуглуулах данс нь Үйлчилгээ үзүүлэгчийн нээсэн Зээлийн эргэн төлөлтийн дансанд цугларсан мөнгийг хүлээн авах, үнэт цаасны төлбөр төлөх зорилгоор ашиглах бөгөөд төлбөр хүлээн авах бэлэн байдлыг хангана.

Хөрөнгө итгэмжлэн удирдагч болон захиргааны үйлчилгээ үзүүлэгч нар нь ТЗК-ийн ТУЗ-өөс баталсан төсвийн дагуу төлбөр цуглуулах данснаас зардал гаргах эрхтэй байна.

**Зээлийн эргэн төлөлтийн данс**

Үйлчилгээ үзүүлэгч нь Зээлийн эргэн төлөлтийг өөрийн харилцах данс буюу зээлийн эргэн төлөлтийн дансанд цуглуулах ба ТЗК-ийн хөрөнгийн багцад буй Зээлийн үндсэн болон хүүгийн төлөлтийг бусад хөрөнгөөс ангид бүртгэнэ. Зээлийн эргэн төлөлтийн дансыг зарцуулах эрхтэй этгээд нь үйлчилгээ үзүүлэгч байна.



УЛААНБААТАР ХОТ
НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЗК ХХК
9022080593
6862705 СБТ19638

**Хадгаламжийн данс**

ТЗК-ийн мөнгөн хөрөнгийг ашиглагдахгүй хугацаанд үр ашигтай байлгах үүднээс тодорхой хэмжээг хадгаламжийн дансанд байршуулна. Тус хадгаламжийн данснаас зөвхөн ТЗК-ийн байгуулсан төлбөр цуглуулах данс руу зарлага гаргах боломжтой байна.

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь шаардлагатай тохиолдолд хадгаламжийг цуцлан, мөнгөн үлдэгдлийг төлбөр цуглуулах данс руу татан шаардлагатай зарцуулалтыг хийх эрхтэй байна.

**Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв дахь данс**

ТЗК-ийн хүүгийн болон үндсэн төлбөрийн төлөлтийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан төлбөрийн хуваарийн дагуу өөрийн брокерийн компанид нээлгэсэн Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн дансанд шилжүүлнэ. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь шаардлагатай тохиолдолд уг дансан дахь мөнгөн үлдэгдлийг төлбөр цуглуулах данс руу татан шаардлагатай зарцуулалтыг хийх эрхтэй байна. Тус үнэт цаасны данснаас зөвхөн ТЗК-ийн байгуулсан төлбөр цуглуулах данс руу зарлага гаргах боломжтой байна.

## 3.7 Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг буцаан дуудах нөхцөл

Үнэт цаас гаргагч нь хөрөнгийн багцыг хуульд заасан дараах үндэслэлээр анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдсан тохиолдолд ХБҮЦ-ыг буцаан дуудна. Үүнд:

- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 18.2.3-д заасны дагуу Хөрөнгийн багцад байгаа хөрөнгийн 20 ба түүнээс дээш хувь нь 90 хоногоос дээш хугацаа хэтэрсэн тохиолдолд;
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.11.5-д заасан нөхцөл байдал үүссэн бөгөөд талууд харилцан тохиролцсон тохиолдолд;

Голомт Капитал ҮЦК ХХК

УЛААНБААТАР ХОТ
НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЗК ХХК

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ

# ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

# 4 ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ

## 4.1 Үнэт цаасжуулах хэлцлийн зураглал

**Схем 5. Үнэт цаасжуулах процесс зураглал**




СЗХ 2022 он 09 сар 21 өдөр БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2022-09-21 БҮРТГЭВ-03
УЛААНБААТАР ХОТ НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЗК ХХК 9022080553 6852705 СВТ19638
Golomt Capital 1119289111 5481589 Улаанбаатар хот

**Тусгай зориулалтын компани үүсгэн байгуулах**

ТЗК нь СЗХ-ноос зөвшөөрөл авсны үндсэн дээр, баталгаат үнэт цаас гаргах бүрд байгуулагддаг тусгай зориулалттай хуулийн этгээд юм. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.4-т заасны дагуу Нөмөр Кредит ББСБ ХХК нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зорилгоор хууль журмын дагуу Нөмөр Кредит Ассет ТЗК ХХК-ийг үүсгэн байгуулсан.

**Хууль, журмын хүрээнд шаардлага хангаж буй зээлийг багцлан бүрдүүлэх**

Шинээр байгуулагдсан "Нөмөр Кредит Ассет ТЗК" ХХК-ийн ТУЗ-өөс үйл ажиллагаа, санхүү, хөрөнгийн удирдлага зэрэг үйл ажиллагаа явуулахтай холбоотой дотоод журмууд батлан гаргасан бөгөөд эдгээр журамд үндэслэн "Нөмөр Кредит ББСБ" ХХК-аас шаардлага хангаж буй зээлийн багцыг тодорхойлно. Шалгаруулах зээлийн багцын үнийн дүн 10,000,000,000 /арван тэрбум/ төгрөг байна.

**Зээлийн багцын хөндлөнгийн дүгнэлт**

Тодорхойлогдсон зээлийн багцад үндэслэн хуулийн болон санхүүгийн шалгуурыг хангаж буй эсэхэд хөндлөнгийн хуулийн дүгнэлтийг Өмгөөллийн ХаанЛекс Партнерс ХХН, зээлийн шинжилгээг олон улсын аудитын эрхтэй Мүүрь Аудит ХХК боловсруулсан. Ингэхдээ ХБҮЦ-н тухай хууль, СЗХ, Монголын Хөрөнгийн Биржийн журмуудад үндэслэн шалгалт хийсэн.

**Шинээр байгуулагдсан ТЗК-д зээлийн багцыг шилжүүлэх**

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эзэмшилд буй зээлийн багцыг ТЗК-тай гэрээ байгуулсны үндсэн дээр шилжүүлнэ. Хөрөнгө итгэмжлэн удирдагч Юнайтед Айр Файненс ХХК нь ТЗК-тай байгуулсан гэрээний үндсэн дээр хөрөнгө оруулагчид барьцаалуулсан тус хөрөнгийг түүний эрх ашигт нийцүүлэн эзэмшиж удирдана. Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн гэрээ үнэт цаасны хугацааны эцэст дуусгавар болно. Шилжүүлэх зээлийн багцын үнийн дүн 10,000,000,000 /арван тэрбум/ төгрөг байна.

**Эрх бүхий байгууллагуудад бүртгүүлэх**

Андеррайтер нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Компанийн тухай хууль, СЗХ-ны "Хөрөнгөөр Баталгаажсан Үнэт Цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам", МХБ-ийн "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам"-ийн дагуу үнэт цаасны танилцуулга, хүсэлтийг боловсруулж, үнэт цаасыг бүртгүүлнэ. ҮЦТХТ-өөр дамжуулж Үнэт цаасыг бүртгүүлж хадгалуулах, хүүгийн төлбөр тооцоо, эрхийг шилжүүлэх зэрэг үүргийг гүйцэтгүүлнэ.

**МХБ-ээр дамжуулан олон нийтэд анх удаа санал болгох**

МХБ болон СЗХ-оос зөвшөөрөл авсны үндсэн дээр Андеррайтер нь эрх бүхий байгууллагуудаас гаргасан үнэт цаасыг танилцуулах хууль, дүрэм журмын хүрээнд тогтоосон хугацаанд анхдагч зах зээлд олон нийтэд

сурталчилж, санал болгон борлуулалт хийж, захиалгыг хүлээн авна. Худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагчид МХБ-ээр дамжуулж Үнэт цаас олон нийтэд санал болгох анхдагч зах зээлийн арилжааны хугацаанд өөрийн ҮЦТХТ-д бүртгэлтэй дансанд захиалгын мөнгийг шилжүүлж, арилжаанд оролцоно. Арилжаа амжилттай явагдсаны дараа Үнэт цаасыг хөрөнгө оруулагчдын дансанд байршуулна. Ингэснээр ХБҮЦ-ны үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрийг үнэт цаасны танилцуулгад заасан хугацаанд авах эрх үүснэ. Үнэт цаас гарган татан төвлөрүүлсэн хөрөнгийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид шилжүүлнэ.

**Хөрөнгө Итгэмжлэн удирдах**

"Нөмөр Кредит Ассет ТЗК" ХХК-с гаргасан Хөрөнгө итгэмжлэн удирдах багц журмын хүрээнд Юнайтед Айр Файнэнс ХХК-аар дамжуулж хөрөнгийг итгэмжлэн удирдуулна. Ингэхдээ ХБҮЦ-ны багцтай холбоотой хөрөнгийг бүртгэх, тайлагнах зэрэг үйлчилгээг хамтран ажиллах гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэнэ.

**Тусгай зориулалтын компанийг татан буулгах**

Тусгай зориулалтын компанийг дараах нөхцлүүдэд татан буулгана. Үүнд:

1. Үнэт цаасны танилцуулгад заагдсан үүрэг дуусгавар болсон,
2. Компани үүсгэн байгуулагдсан зорилгоо бүрэн биелүүлж Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны төлбөрийг бүрэн төлж дууссан,
3. Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны хөрөнгийн багцын үлдэгдлийн дүн түүний анхны үнийн 20 хувьд хүрсэн тохиолдолд анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үүсгэн байгуулагч, худалдагчтай тохиролцон багцыг буцаан худалдсан,
4. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан нөхцлүүдийн дагуу.

Тусгай зориулалтын компанийг өөрчлөн байгуулах, дахин үүсгэн байгуулах үйл ажиллагаа хийгдэхгүй.

## 4.2 Санал болгож буй хүүгийн түвшин болон хүү тогтоосон үндэслэл

Инфляцын хэт өсөлт, гадаад зах зээл дээрх хүүний өсөлт, валютын ханшийн тогтворгүй байдлын улмаас Монголбанк нь бодлогын хүүг 2022 оны 6 сард 9.0 хувиас 10.0 хувь болгож өсгөсөн. Үүний дараагаар 2022 он гарснаар Монголбанкны бодлогын хүүний түвшин нь арилжааны банкны хадгаламжийн хүү өсөх үндсэн шалтгаан болсон бөгөөд 2022 оны 8 сарын байдлаар топ 5 арилжааны банкнуудын 24 сарын хугацаатай хадгаламжийн дундаж хүү нь 10.24 хувьтай байна. Иймд хөрөнгө оруулагчид Нөмөр Кредит Ассет ХБҮЦ-нд хөрөнгө оруулснаар хөрөнгө оруулалтын өгөөж хадгаламжийн хүүнээс 1.7 дахин өндөр байна.

Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Delivering diversity
1119289111 5481589
Улаанбаатар хот



УЛААНБААТАР ХОТ
НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЗК ХХК
9022080593
6862705 СБТ19638

**График 11. Төгрөгийн хадгаламжийн хүү (2022 оны 8 сарын байдлаар)**




*Эх сурвалж: Банкнуудын веб сайт*

"Нөмөр Кредит Ассет ТЗК" ХХК-ийн хөрөнгө оруулагчдад санал болгож буй жилийн хүү 17.5 хувь байна. Хөрөнгө оруулагч нь жилийн 17.5 хувийн хүүг ХБҮЦ-ны үлдэгдэл дүнд тооцож авах бөгөөд 100,000 төгрөгийн ХБҮЦ худалдан авсан хөрөнгө оруулагчийн өгөөжийн задаргааг доор хүснэгтээр харууллаа:

**Хүснэгт 13. ХБҮЦ-д хөрөнгө оруулсан хөрөнгө оруулагчийн жилийн өгөөж**

| | |
|---|---|
| Анхны хөрөнгө оруулалт | 100,000 |
| Хүүгийн орлого | 4,375 |
| Хүүгийн татварын зардал 5% | 875 |
| Бодит өгөөжийн хувь | **16.625%** |

**Нээлттэй зах зээл дээр арилжигдах үнэт цаасны хүүгийн орлогын татвар нь 5% байна*

## 4.3 Үнэт цаас эзэмшигчдэд төлөх төлбөрийн эх үүсвэр, төлбөрийн хуваарь

Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны төлбөрийн үндсэн төлбөр болон хүүний төлбөрийг ТЗК-д шилжүүлсэн 10 тэрбум төгрөгийн дүн бүхий зээлийн багц ын эргэн төлөлтийн мөнгөн урсгалаар төлнө. Тус багц нь одоогоор зээлүүдийн гэрээгээр хүлээсэн үүргийг харуулах боловч хугацааны дундуур зээл урьдчилан төлөгдөх, хугацаа дууссан тохиолдолд анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс шалгуур хангахгүй болсон зээлүүдийг солин шалгуур хангасан зээлээр солих, худалдан авах зэргээр мөнгөн урсгалын тооцоололд өөрчлөлт орох боломжтой. Хэрэв зээлийн багцын мөнгөн урсгалаас тухайн улиралд төлөх боломжгүй болсон тохиолдолд Үүссэн төлөлтийн мөнгөн урсалын эрсдэлийн сангийн эх үүсвэрээр төлбөрийг төлж барагдуулна.

Хөрөнгө оруулагч нь жилийн 17.5 хувийн хүүг ХБҮЦ-ны үлдэгдэл дүнд тооцож авах бөгөөд 100,000 төгрөгийн ХБҮЦ худалдан авсан хөрөнгө оруулагчийн төлбөрийн задаргааг доор хүснэгтээр харууллаа:

Хүснэгт 14. Хүснэгт 14. ХБҮЦ эзэмшигчдийн төлбөрийн хуваарь, сая.төг (хүүгийн тооцоолол хийсэн жилийн суурь хоног 365/А)

| | У1 | У2 | У3 | У4 | У5 | У6 | У7 | У8 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| ХБҮЦ | 10,000 | 10,000 | 10,000 | 10,000 | 5,000 | 5,000 | 5,000 | 5,000 |
| Төлөгдөх үндсэн дүн | - | - | - | 5,000 | - | - | | 5,000 |
| **ХБҮЦ үлдэгдэл** | **10,000** | **10,000** | **10,000** | **5,000** | **5,000** | **5,000** | **5,000** | **-** |
| Хүү | 436.3 | 431.5 | 441.1 | 441.1 | 218.2 | 218.2 | 220.5 | 220.5 |
| Татварын дараах | 414.5 | 409.9 | 419.0 | 419.0 | 207.2 | 207.2 | 209.5 | 209.5 |
| **Төлөгдөх нийт дүн** | **414.5** | **409.9** | **419.0** | **5,419.0** | **207.2** | **207.2** | **209.5** | **5,209.5** |

*Эх сурвалж: Андеррайтерийн тооцоолол*

**Хөрөнгийн багцын төлбөрийн зарцуулалт, төлбөр хуваарилах дэс дараалал**

Үнэт цаас эзэмшигчдэд төлөгдөх төлбөрийг зориулалтын бусаар захиран зарцуулахаас сэргийлж, төлбөр цуглуулах данснаас зөвхөн "Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх журам"-д заасан дараах зарцуулалтыг хийнэ.

- Үнэт цаас эзэмшигчдэд төлөгдөх төлбөрийг ҮЦТХТ-ийн данс руу шилжүүлэх;
- Үнэт цаасны хүүгийн орлогын татвар;
- Хөрөнгийн багцад хөрөнгө нэмж худалдан авах, солих, нэмэгдүүлэх;
- Банк санхүүгийн байгууллагад хадгаламж байршуулах;
- ТЗК-ийн төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан төсвийн дагуу ТЗК-ийн үйл ажиллагаатай холбоотой ерөнхий ба удирдлагын зардал.

## 4.4 Хөрөнгийн багц, багцад тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтүүд

**Хөрөнгийн багцад тавигдах санхүүгийн шалгуур үзүүлэлтүүд:**

| № | Шалгуур үзүүлэлтүүд |
|---|---|
| | Автомашины зээлд тавигдах шалгуур үзүүлэлт |
| 1 | СЗХ-нд хүргүүлэх хөрөнгийн мэдээлэл нь зээлийн хувийн хэрэг дэх үндсэн баримттай нийцэж байх |
| 2 | Зээл нь Монгол төгрөгөөр олгогдсон бөгөөд Монгол төгрөгөөр эргэн төлөгдөх зээл байх |
| 3 | Зээлийн эргэн төлөлтийн хуваарьт зээлдэгчийн сар бүрийн төлөх дүнг (төлж дуусгах хугацаа) тусгасан байх, зээлийн хугацааны эцэст бүрэн төлөгдөж дуусахаар байх |
| 4 | Автомашины зээлийн хувьд фидуцийн гэрээний зүйл нь даатгалд даатгагдсан байх, даатгал нь хүчин төгөлдөр байх |
| 5 | Тасалбар болгосон өдрийн байдлаар зээл нь хэвийн төлөлттэй байх |



ПӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЗК ХХК
9022080593
6862705 СБТ19638

| | |
|---|---|
| | Зээлийг холбогдох журмын дагуу үүсгэсэн байх бөгөөд зээлийн стандарт нь |
| 6 | Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн дотооддоо хэрэгжүүлдэг ерөнхий стандартаас дутуугүй шалгуур хангасан байх: |
| 6.1 | Тасалбар болгосон өдрөөрх зээл үнэлгээний харьцаа (ЗҮХ) 85%-с хэтрэхгүй байх.<br>ЗҮХ = (Зээлийн үлдэгдэл)/(Үндсэн барьцаа хөрөнгийн худалдаж авч буй үнэ) |
| 6.2 | Зээл олгосон өдрийн байдлаар зээлдэгч нь Банк, санхүүгийн байгууллагад хугацаа хэтэрсэн, чанаргүй зээлийн өрийн үлдэгдэлгүй байх |

**Хөрөнгийн багцад тавигдах хуулийн шалгуур үзүүлэлтүүд:**

| № | Шалгуур үзүүлэлтүүд |
|---|---|
| | **Автомашины зээлд тавигдах шалгуур үзүүлэлт** |
| 1 | Автомашины зээлийн гэрээ нь хуульд заасан шаардлагад нийцсэн, хүчин төгөлдөр, гэрээнд заасан үүрэг нь заавал биелэгдэх шинжтэй байх; |
| 2 | Фидуцийн гэрээ нь хуульд заасан шаардлагад нийцсэн, хүчин төгөлдөр, гэрээнд заасан үүрэг нь заавал биелэгдэх шинжтэй байх; |
| 3 | Фидуцийн гэрээний дагуу автомашиныг анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд шилжүүлсэн байх, холбогдох бүртгэлийг хийлгэсэн байх; |
| 4 | Тасалбар болгох өдрийн байдлаар зээлийн гэрээ, фидуцийн гэрээ нь Үүрэг гүйцэтгэгчийн хувьд үүргэ хугацаанаас өмнө дуусгавар болгох/урьдчилан төлөх нөхцөл, хэлцлээс татгалзах, харилцан суутгал хийх замаар үүргийг дуусгавар болгох, сөрөг нэхэмжлэл гаргах, эсхүл үүргээс татгалзах (илт хохиролтой хэлцлийн улмаас үүргээс татгалзах нөхцөлийг хамааруулан) эрх үүсээгүй, эсхүл эрхээ хэрэгжүүлэх хүсэл зориг илэрхийлээгүй байх; |
| 5 | Зээлийн гэрээ, Фидуцийн гэрээний шаардах эрх гуравдагч этгээдэд шилжих боломжтой, ийнхүү шаардах эрхээ шилжүүлэх нь хууль, гэрээнд харшлаагүй байх |

**Хөрөнгийн багцын дахин үнэлэх эсэх талаарх мэдээлэл**

ТЗК-ийн хөрөнгийг дахин үнэлэхгүй. Учир нь "Хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах журам"-ын 2.3.1, 2.3.3, 2.3.4-т заасны дагуу хөрөнгийн багц дахь зээл нь "Хөрөнгө худалдах худалдан авах гэрээ"-нд заасан аль нэг мэдэгдэл, баталгаа зөрчигдсөн буюу шалгуур үзүүлэлт хангахгүй болсон эсхүл зээлийн эргэн төлөлтийн хугацаа нь 90-ээс дээш хоног хугацаа хэтэрсэн тохиолдолд шаардлага хангахгүй хөрөнгөд тооцож, тус зээлийн хөрөнгийг багцаас хасаж, шаардлага хангах хөрөнгөөр сольж бүртгэх юм. Мөн журмын 2.5.1-д заасны шаардлага хангахгүй хөрөнгийг шаардлага хангах хөрөнгөөр солих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд тус хөрөнгийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдахаар зохицуулсан. Энэхүү үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой талуудын эрх, үүргийг "Хөрөнгө худалдах худалдан авах гэрээ" болон "Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ"-нд журмын заалттай нийцүүлэн тусгасан болно.

Түүнчлэн хөрөнгийн багц нь 100 хувь хэвийн зээлээс бүрдэх бөгөөд хөрөнгийн багц нь бүхэлдээ автомашины фидуци бүхий зээл байа. ТЗК нь Хорооноос баталсан "Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулах, зарцуулах журам"-ын дагуу эрсдэлийн сан байгуулж зээлтэй холбоотой эрсдэлийг бууруулах юм. Тус эрсдэлийн сангийн эх үүсвэрээр чанаргүй болсон, төлбөрийн чадваргүй болсон зээлийн хөрөнгийн төлбөрийг Хөрөнгө оруулагчдад хуваарилан ажиллана.

Иймд ХБҮЦ-ны хугацаанд ТЗК-ийн хөрөнгийн багц нь хэвийн ангилалтай, шалгуур хангах зээлүүдээс бүрдэх бөгөөд эрсдэлийн сантай байх тул ТЗК-ийн хөрөнгийг дахин үнэлэх шаардлага үүсэхгүй юм.

## 4.5 Хөрөнгийн багцын мэдээлэл

Нөмөр Кредит Ассет ХБҮЦ нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасан шаардлагыг бүрэн хангасан бөгөөд автомашины зээлээс бүрдсэн нийт 587 зээлийн гэрээнээс бүрдэх 11,022.2 сая төгрөгийн үнийн дүн бүхий зээлийг багцалсан. Хөрөнгийн багцын үлдэгдэл жигнэсэн дундаж хугацаа 44.55 сар, жигнэсэн дундаж хүү 2.75 хувь байна. Үнэт цаасыг олон нийтэд санал болгох тусгай зөвшөөрөл авснаас хойш Бирж дээр арилжаалж гүйлгээг хийх хүртэл хугацаанд үнэт цаасны хөрөнгийн багцаас зээлүүд төлөгдөх, хаагдах, хугацаа хэтрэх тохиолдол үүсэж болох бөгөөд энэ тохиолдолд хөрөнгийн багцын хэмжээг үнэт цаасны хэмжээнээс багагүй буюу 10.0 тэрбум төгрөг хүртэл буурах боломжтой.

Үнэт цаасыг олон нийтэд санал болгон арилжаалах үед анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс үнэт ХБҮЦ-ны үнийн дүнтэй дүйцэхүйц хэмжээний хөрөнгийг худалдан авна.



УЛААНБААТАР ХОТ
НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЗК ХХК
9022080593
6862705 СБТ19638

Хүснэгт 15. Хөрөнгийн багцын үндсэн үзүүлэлт

| Хөрөнгийн багцын үндсэн үзүүлэлт | |
|---|---|
| Зээлийн төрөл | Дүн /төгрөгөөр/ |
| Нийт автомашины зээлийн үлдэгдэл | 11,022,245,541 |
| Зээлийн хөрөнгийн барьцааны дүн | 16,927,217,164 |
| Зээлийн гэрээний тоо | 587 |
| Зээлийн дундаж үлдэгдэл | 18,777,250 |
| Барьцааны дүн | 16,927,217,164 |
| Жигнэсэн дундаж хүү /сар/ | 2.75% |
| Жигнэсэн дундаж хугацаа /сар/ | 44.55 |
| Жигнэсэн дундаж LTV% | 65.12% |
| **Багцын зээлийн чанар** | **100% хэвийн зээл** |

Автомашины зээл нь барьцаат зээлийн ангилалд багтах бөгөөд худалдан авч буй хөрөнгө болох авто машинаар барьцаалагдсан зээл юм. Автомашины зээл нь нийт хөрөнгийн багцын 100 хувийг бүрдүүлж байна.

График 12. Автомашины зээлийн задаргаа /үнийн дүнгээр/




Автомашины 587 зээлийн багцын үлдэгдлийг үнийн дүнгээр задалж харвал 405 нь 10-50 сая хүртэлх үнийн дүн бүхий зээл, 158 нь 0-10 сая хүртэлх үнийн дүн бүхий зээл, 21 нь 50-100 сая төгрөг хүртэлх үнийн дүн бүхий зээл, үлдсэн 3 зээлийг 100-с дээш сая төгрөгийн үнийн дүн бүхий зээлийн үлдэгдэлтэй зээлүүд бүрдүүлж байна.

Хүснэгт 16. Автомашины зээлийн багц анх олгосон хугацаагаар /сая төгрөг/

| Анх олгосон хугацаа | Тоо | Үнийн дүн /сая төгрөг/ | Багцад эзлэх хувь |
|---|---|---|---|
| 0-12 сар | 2 | 32.8 | 0.30% |
| 12-24 сар | 20 | 215.2 | 1.95% |
| 24-36 сар | 78 | 840.8 | 7.63% |
| 36 сараас дээш | 487 | 9,933.5 | 90.12% |



УЛААНБААТАР ХОТ
НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЗК ХХК
9022080593
6862705 СБТ19638

| | | | |
|---|---|---|---|
| **Нийт** | **587** | **11,022.2** | **100.00%** |

Автомашины зээлийн багцыг хугацаагаар ангилан харуулбал нийт автомашины зээлийн багцын 1.95 хувийг 12-24 сарын хугацаатай зээлүүд, 0.30 хувийг 0-12 сарын хугацаатай зээлүүд, 7.63 хувийг 24-36 сарын хугацаатай зээлүүд, үлдсэн 90.12 хувийг 36-аас дээш сарын хугацаатай зээлүүд эзэлж байгаа бол **үлдэгдэл хугацаанд ногдох жигнэсэн дундаж хугацаа нь 44.55 сар байна.**

**График 13. Зээлийн багцын тархалт**




Нийт зээлийн багцын 9.70 хувийг 10 сая хүртэлх үнийн дүн бүхий зээлүүд, 72.41 хувийг 10-50 сая хүртэлх үнийн дүн бүхий зээл, 12.03 хувийг 50-аас 100 сая төгрөг хүртэлх зээл, үлдсэн 5.86 хувийг 100 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зээлүүд бүрдүүлж байна. **Түүнчлэн нэг гэрээнд ногдох зээлийн дундаж үлдэгдэл 18.8 сая төгрөг байна.**

**Зээлийн төвлөрөл**

Нийт хөрөнгийн багцын 72.41 хувийг 10-50 сая төгрөгийн үнийн дүн бүхий 405 зээл, 9.70 хувийг 0-10 сая төгрөгийн үнийн дүн бүхий 158 зээл, үлдсэн 17.89 хувийг 50-с дээш сая төгрөгийн үнийн дүн бүхий 24 зээл бүрдүүлж байна.

**Хүснэгт 17. Зээлийн төвлөрөл /үнийн дүнгээр/**

| Зээлийн үлдэгдэл | Зээлийн тоо | Зээлийн дүн | Багцад эзлэх хувь |
|---|---|---|---|
| 0-10 сая | 158 | 1,068.8 | 9.70% |
| 10-50 сая | 405 | 7,981.6 | 72.41% |
| 50-100 сая | 21 | 1,326.0 | 12.03% |
| 100 сая+ | 3 | 645.9 | 5.86% |
| | **587** | **11,022.2** | **100.0%** |

Хөрөнгийн багцын барьцаа хөрөнгө нь хөрөнгийн багцын үнийн дүнгээс 53.6 хувиар өндөр буюу зээлийн багцын LTV харьцаа 65.1 хувьтай тэнцэж байна. **Хөрөнгийн багцын барьцааны мэдээллийг доор харуууллаа.**

**Хүснэгт 18. Зээлийн барьцаа хөрөнгийн мэдээлэл**

| LTV харьцаа | Тоо | Үнийн дүн /сая төгрөг/ | Багцад эзлэх хувь |
|---|---|---|---|
| 0-30% | 5 | 50.9 | 0.46% |
| 30-50% | 23 | 310.8 | 2.82% |
| 50-100% | 381 | 8,232.2 | 74.69% |
| 100% | 178 | 2,428.4 | 22.03% |
| **Нийт** | **587** | **11,022.2** | **100.00%** |

## 4.6 Үнэт цаасанд нөлөөлөх эрсдэлийн шинжилгээ

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаастай холбогдох дараах эрсдэлийн хүчин зүйлс байгаа бөгөөд Үнэт цаас гаргагч нь эрсдэлийн удирдлагын бодлого, Дотоод хяналтын тогтолцооны журмаар үйл ажиллагааг хэвийн явуулах учирч болох эрсдэлийг бууруулахаар зорин ажиллаж байна.

| ЭРСДЭЛИЙН ХҮЧИН ЗҮЙЛС | |
|---|---|
| **Зээлийн эрсдэл** | Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас нь багцалж буй суурь хөрөнгийн эрсдэлийг шууд хүлээж байдаг. Тодруулбал, Нөмөр Кредит Ассет ХБҮЦ нь хөрөнгийн багцыг бүрдүүлж буй автомашины зээл түүний эргэн төлөлттэй холбоотой бүхий л зээлийн эрсдэлийг шууд хүлээх юм. |
| **Үйл ажиллагааны эрсдэл** | Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа нь тусгай хуулиар зохицуулагддаг бөгөөд бусад хуулийн этгээдийн хамтын үйл ажиллагаанаас хамаардаг тул үйл ажиллагааг хэвийн явуулах, хөрөнгийн багцыг зөв зохистой удирдахтай холбоотой хүний нөөц, технологи, дотоод зохион байгуулалт зэрэг Үнэт цаас гаргагчийн үндсэн үйл ажиллагаа доголд охоос бий болох эрсдэлүүд багтдаг. |
| **Зах зээлийн эрсдэл** | Эдийн засгийн нөхцөл байдал, зах зээл дээрх хүүгийн түвшин, хөрөнгийн зах зээлийн нөхцөл байдал зэрэг Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанаас хамаарахгүйгээр бий болох зах зээлийн эрсдэлүүд нь ХБҮЦ-ны үнэ болон хөрвөх чадварт нөлөөлөх эрсдэлтэй. |
| **Хууль эрх зүйн эрсдэл** | ХБҮЦ-нь Монгол Улсын Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулагддаг. ХБҮЦ-тай холбоотой голлох хууль эрх зүйн эрсдэл нь Хөрөнгийн багцыг шилжүүлснээр үүсгэн байгуулагчийн хүлээх олон төрлийн эрсдэлийг Үнэт цаас гаргагчид шилжихгүйгээр хааж чадаж байгаа эсэх юм. |

| | |
|---|---|
| **Дахин хөрөнгө оруулалтын эрсдэл** | Хөрөнгийн багц дах зээлүүд нь шинэчлэгдсэнээр багцын хөрөнгийн чанар муудах, тараан байршуулалт буурах эрсдэл нэмэгдэх магадлалтай. |
| **Хөрвөх чадварын эрсдэл** | Хөрөнгийн багцаас бий болох мөнгөн хөрөнгийн урсгал нь ХБҮЦ-ны төлбөр төлөгдөх мөнгөн урсгалтай таарахгүй нөхцөл байдал үүсэх эрсдэлтэй. Энэ нь үнэт цаасны хүү болон үндсэн төлөлтийн төлбөрүүд хөрөнгийн багцаас орж ирэх мөнгөн урсгалуудын цаг хугацааны зөрүүтэй байдлаас үүдэн эргэн төлөлтөд тасалдал үүсгэх эрсдэлийг бий болгоно. |
| **Урьдчилан төлөх эрсдэл** | Хөрөнгийн багц дах зээлүүд нь төлөвлөсөн хугацаанаас өмнө төлөгдөх боломжтой бөгөөд энэ тохиолдолд багцын төлөвлөсөн мөнгөн урсгалыг тасалдуулахгүйн тулд дахин хөрөнгө оруулалт хийх шаардлага гарна. Энэ үед багцын чанар болон зээлийн эрсдэл дахин үүсэх эрсдэлтэй. |
| **Оролцогч талуудын эрсдэл** | Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааг амжилттай зохион байгуулахад бусад хуулийн этгээдүүд үүрэг оролцоо чухал нөлөөтэй. Жишээлбэл, Үйлчилгээ үзүүлэгч нь хөрөнгөтэй холбоотой төлбөрийг цуглуулж Үнэт цаас гаргагчид шилжүүлэх үүрэгтэй байдаг ба Үйлчилгээ үзүүлэгчийн төлбөр цуглуулах үйл ажиллагааг хэвийн зохион байгуулах чадвар алдагдсанаар эрсдэл үүсэх магадлалтай. |

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2022 оны 8 сарын 17 өдрийн 7 дугаар тоот тогтоолын хавсралт №8-аар баталсан Эрсдэлийн Удирдлагын, Дотоод хяналтын журамд ХБҮЦ-тай холбоотой эрсдэлийн түвшинг үндсэн 3 хэсэгт ангилан авч үзсэн. Үүнд:

| Зээлтэй холбоотой эрсдэл | Үнэт цаас гаргах үйл ажиллагаанд оролцогч талуудтай холбоотой эрсдэл | Бусад гадны хүчин зүйлстэй холбоотой эрсдэл |
|---|---|---|
| •Зээлдэгч зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэгүйтэй холбоотой эрсдэл | oАнхны үүрэг гүйцэтгүүлэгч;<br>oҮйлчилгээ үзүүлэгч;<br>oХөрөнгө итгэмжлэн удирдагч; | oХууль, журам, зохицуулалт;<br>oДавагдашгүй хүчин зүйлс |

***Зээлтэй холбоотой эрсдэл***

Үнэт цаас гаргагч нь зээлтэй холбоотой үүсэж болох эрсдэлийг дараах байдлаар удирдахаар Эрсдэлийн удирдлагын бодлогод заасан болно. Үүнд:

| | |
|---|---|
| 1 | Үнэт цаас гаргагч нь зээлтэй холбоотой эрсдэлийг Хорооноос баталсан Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулах, зарцуулах журмыг мөрдөж, зээлийг ангилж, эрсдэлийн сан байгуулж ажиллана.Эрсдэлийн сан байгуулах ТЗК нь хагас жил тутамд зээлийн эрсдэлийн санг Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Активыг ангилах, эрсдлийн сан байгуулах, зарцуулах журам”-ын дагуу тооцож, холбогдох эрсдэлийн сангийн тохируулгыг хийнэ. |
| 2 | Үнэт цаас гаргагч нь хугацаа хэтэрсэн зээл дээр үйлчилгээ үзүүлэгч талаас зээлийг эргэн төлүүлэхтэй холбоотой үйлчилгээ үзүүлэгчийн дотооддоо мөрдөж буй холбогдох заавар журмын хүрээнд үйлчилгээг авч, хяналт тавьж ажиллана. |
| 3 | Үнэт цаас гаргагч нь зээл хугацаанаас өмнө эргэн төлөгдөх эрсдэл үүссэн тохиолдолд Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны (цаашид “ХБҮЦ” гэх) тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэг болон ТЗК-ийн Хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах тухай журамд заасны дагуу хөрөнгийн багцад шалгуур үзүүлэлт хангасан хөрөнгө нэмэх, солих, буцаан худалдах замаар зээлтэй холбоотой эрсдэлийг удирдах арга хэмжээ авна. |

Үнэт цаас гаргагч нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсэгт заасны дагуу эргэн төлөлтийг сай жруулах дараах арга хэмжээг авна.

- Багцын хөрөнгийг сайжруулах, солих;
- Багцын хөрөнгийг нэмэгдүүлэх;
- Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдах;
- Багцын хөрөнгийн дүнг үнэт цаасны төлбөрийн төлөгдөөгүй дүнгийн 110 хувиас багагүй байлгах;
- Эрсдэлийн сан байгуулах;
    - o Хөрөнгийн багц дахь зээлийн төлбөрүүдийг Үйлчилгээ үзүүлэгчийн бусад хөрөнгөөс тусад нь ангид байлгах.
    - o ТЗК-ийн эргэн төлөлтийг сайжруулах арга хэмжээг ТЗК татан

буургдах хүртэл хэрэгжүүлнэ.
- ТЗК нь татан буугдах үед зээл, зээлийн эрсдэлийн сан нь Анхны үүрэг гүйцэтгэгчид шилжинэ.

***Оролцогч талуудтай холбоотой эрсдэлийн удирдлага***

ХБҮЦ гаргахтай холбоотой оролцогч байгууллагууд нь тодорхой чиг үүргийн хүрээнд Үнэт цаас гаргагчтай гэрээгээр хамтарч ажилладаг.

Үнэт цаас гаргагч нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй холбоотой үүсэх бүхий л төрлийн эрсдэлийг бууруулах зорилгоор холбогдох журам, гэрээ бүрт эрсдэл бууруулах, мэдээллийг цаг тухай бүрт хүргэх, хяналт тавих, мэдээлэл солилцох зохицуулалтуудыг тусгасан байна.

Үйлчилгээ үзүүлэгч : Үйлчилгээ үзүүлэгчийн үндсэн зорилго нь хөрөнгийн багцын төлбөрийг цуглуулан үнэт цаас гаргагчид шилжүүлж мөнгөн урсгалыг тасалдуулахгүй байх юм. Үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаа тасалдах төлбөрийн чадваргүй болох зэргээс үүдэн Үнэт цаас гаргагчид бий болох эрсдэлийг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасны дагуу хохирлыг үйлчилгээ үзүүлэгч хариуцахаар заасан байна. Мөн Үйлчилгээ үзүүлэх гэрээгээр боломжит эрсдэлийг бууруулахаар зүйл заалтууд тусгасан байна.

Хөрөнгө итгэмжлэн удирдагч: Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Үнэт цаас гаргагчийн хөрөнгийн багцыг гэрээнд заасны дагуу оролцогч талуудын эрх ашигт нийцүүлэн удирдах үүрэгтэй болно. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь багцын удирдлагатай холбоотой тайлан мэдээллийг үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээний дагуу үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагч, холбогдох эрх бүхий байгууллагад тогтмол хүргэх бөгөөд хууль болон гэрээнд заасанаас гадуур, зүй бусаар удирдаж, ашиглах тохиолдолд Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь хөрөнгө итгэмжлэн удирдагчийг нэн даруй солих шийдвэр гаргах, эсхүл үйл ажиллагааг залруулах, хохирлыг барагдуулах тодорхой хугацаа тогтоох эрхтэй. Мөн зүй бусаар хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор аливаа хохирол учирсан тохиолдолд Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь өөрийн хөрөнгөөр бүрэн төлж барагдуулах талаар гэрээнд тодорхой тусгаж баталгаажуулсан байна.

**Гадаад хүчин зүйлстэй холбоотой эрсдэл**

Үнэт цаас гаргагч нь гадаад хүчин зүйлстэй холбоотой эрсдэлд хууль журам зохицуулалтын өөрчлөлт болон давагдашгүй хүчин зүйлстэй холбоотой эрсдэлийг авч үзсэн. Үнэт цаас гаргагч нь ТУЗ-ийн хурал хуралдуулж, шаардлагатай гэж үзсэн тохиолдолд эрсдэлийн үнэлгээ, үр нөлөөтэй холбоотой хөндлөнгийн байгууллага, хуулийн фирмийг хөлслөн ажиллуулах, зохицуулагч эрх бүхий байгууллагуудтай тогтмол мэдээлэл солилцох, шийдвэр гаргах замаар эрсдэлийг бууруулж ажиллана.

### 4.7 Хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах, багцаас хөрөнгө хасах журам

Үнэт цаас гаргагчийн 2022 оны 8 сарын 17 өдрийн 7 дугаар тоот ТУЗ-ийн тогтоолын хавсралт №7-оор Хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах журмыг баталсан. Тус журмаар Нөмөр Кредит Ассет ХБҮЦ-ны баталгаа болох зээлийн хөрөнгийн багцад буй хөрөнгийг солих, нэмэх, хасах замаар багцад өөрчлөлт оруулахтай холбоотой харилцааг зохицуулахаар заасан. Уг журамд шаардлага хангахгүй хөрөнгийн тооцож, хөрөнгийн багцад байгаа хөрөнгийн багцаас хасаж солих, багцын хөрөнгийн нэмэгдүүлэх, анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдах замаар хөрөнгө багцад өөрчлөлт оруулахаар заасан.

Дараах тохиолдолд хөрөнгийн багц дах хөрөнгийг шаардлага хангахгүй нөхцөлд хүрсэн гэж үзэн хөрөнгийн багцад байгаа хөрөнгийн багцаас хасаж соли но. Үүнд:

1. Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээнд заасан шалгуур үзүүлэлтүүдийг хангахгүй болсон.
2. Зээлдэгчийн хүсэлтээр зээлийн гэрээнд өөрчлөлт орсон тохиолдолд Үнэт цаас гаргагч нь тус өөрчлөлт үнэт цаасны төлбөр тооцоонд нөлөөлөхүйц гэж үзсэн тохиолдолд
3. Анх үүрэг гүйцэтгүүлэгчийн Хөрөнгө худалдах худалдан авах гэрээнд заасан аль нэг мэдэгдэл, баталгаа зөрчигдсөн
4. Зээлийн эргэн төлөлтийн хугацаа 90-ээс дээш хоногоор хэтэрсэн

Дараах тохиолдолд хөрөнгийн багц дах хөрөнгийг нэмэгдүүлнэ. Үүнд:

1. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 15.3.1-д заасны дагуу Баталгаат үнэт цаасны хөрөнгийн багцаас орох орлого нь үнэт цаасны төлбөрийн үүргийг гүйцэтгэж хүрэхгүй болсон;
2. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 15.3.2-д заасны дагуу Компани нь нээлттэй гаргах нөхцөлийн дагуу нэмэлт үнэт цаас гаргахаар болсон;
3. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь багцын өгөөжийг нэмэгдүүлэх, төлбөрийн тасалдал үүсэхээс урьдчилсан сэргийлэх зорилгоор хөрөнгө оруулагчийн ашиг сонирхолд нийцүүлэн үнэт цаас эзэмшигчдэд төлөх үнэт цаасны төлбөр болон хүүгийн төлбөрөөс бусад сул мөнгөн дүнгээр багц худалдан авах боломжтой гэж үзсэн, зээлийн багц худалдан авах талаар анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй харилцан тохиролцсон.

Дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд Үнэт цаас гаргагч нь хөрөнгийн багцыг анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдана. Үүнд:

1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Хөрөнгийн багцыг өөрчлөх журамд заасны дагуу шаардлага хангахгүй хөрөнгийг бүхэлд нь солих хөрөнгийн жагсаалтыг Үнэт цаас гаргагчид гарган өгөх боломжгүй, эсхүл гарган өгсөн жагсаалт нь шаардлага хангахгүй тохиолдолд солих

боломжгүй хөрөнгийн багцын хэмжээгээр;
2. Хөрөнгийн багцад байгаа хөрөнгийн 20 ба түүнээс дээш хувь нь 90 хоногоос дээш хугацаа хэтэрсэн тохиолдолд;
3. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.11.5-д заасан нөхцөл байдал үүссэн бөгөөд талууд харилцан тохиролцсон тохиолдолд.

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1 болон 20.2.5-д тус тус заасны дагуу Үнэт цаас гаргагчтай байгуулсан Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд заасны дагуу хөрөнгийн багцад хяналт тавин дээр дурдсан нөхцөл байдал үүсэн тохиолдолд хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах арга хэмжээг авч ажиллана.

# АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧ ББСБ-ЫН ТУХАЙ

# 5 АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧ ББСБ-ЫН ТУХАЙ

## 5.1 Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн ерөнхий мэдээлэл

Нөмөр Кредит ББСБ ХХК нь Санхүүгийн Зохицуулах Хорооны зээлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэйгөөр 2015 оны 2 сард үүсгэн байгуулагдсан үндэсний хөрөнгө оруулалттай компани юм. Тус компани нь өөрчлөгдөн буй бизнесийн орчинд хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн олон төрлийн зээлийн үйлчилгээг хурдан, хялбар, уян хатан нөхцөлтэйгөөр хүргэхээр зорин ажилладаг.

| | |
|---|---|
| Үүсгэн байгуулагч | Нөмөр Кредит ББСБ ХХК |
| Регистрийн дугаар | 5928907 |
| Улсын бүртгэлийн дугаар | 9015003064 |
| Үүсгэн байгуулагдсан огноо | 2015/02/05 |
| Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ | Нэг бүр нь 10,000 төгрөгийн үнэтэй 1,050,000 ширхэг хувьцаа |
| Санхүүгийн Зохицуулах Хорооноос тусгай зөвшөөрөл олгосон огноо, дугаар | 2015/04/10<br>ТЗ 101/464<br>Банк бус санхүүгийн үйл ажиллагаа |
| Хаяг байршил | Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2-р хороо, Гранд Плаза Цогцолбор, 801 тоот |
| Арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй эсэх | Үгүй |
| Үйл ажиллагааны чиглэл | • Зээлийн үйл ажиллагаа<br>• Итгэлцлийн үйл ажиллагаа |

## 5.2 Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хувьцаа эзэмшигч, холбоотой этгээдийн мэдээлэл

Нөмөр Кредит ББСБ нь нийт 8 хувьцаа эзэмшигчтэй. Үүнд 4 хуулийн этгээд болон 4 хувь хүн багтаж байна.

**Хүснэгт 19. Хувьцаа эзэмшигчдийн бүтэц**

| Хувьцаа эзэмшигч | УБ дугаар | Эзэмшиж буй хувьцааны too | Эзэмшлийн хувь |
|---|---|---|---|
| Кемекс ХХК | 2659352 | 400,000 | 38.09% |
| Юнайтедпартс ХХК | 5619106 | 356,500 | 33.95% |
| Новатек Интернэшнл ХХК | 2715376 | 145,000 | 13.81% |
| Б.Гантулга | | 110,000 | 10.48% |
| Эрчим Электрик ХХК | 5254841 | 25,000 | 2.38% |
| Б.Болортуяа | | 4,500 | 0.43% |
| Б.Эрдэнэбилэг | | 4,500 | 0.43% |

| | | |
|---|---|---|
| А.Энхжин | 4,500 | 0.43% |
| Нийт | | 100% |

**Кемекс ХХК**
Нөмөр Кредитийн 38.09 хувийг эзэмшдэг хамгийн том хувьцаа эзэмшигч Кемекс ХХК нь 2000 онд үүсгэн байгуулагдсан цагаас хойш уул уурхайн салбарын бүтээн байгуулалт, гүний уурхайн үйл ажиллагаанд шаардагдах бүтээгдэхүүн үйлчилгээ, химийн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлж байна. Кемекс ХХК нь үнэ цэнэ бүтээх бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгосноор уул уурхайн салбарын компаниудын хэрэгцээ шаардлагыг хангахыг зорин ажилладаг Оюутолгойн ханган нийлүүлэгч компани юм.

**Юнайтэдпартс ХХК**
Нөмөр Кредитийн 33.95 хувийг эзэмшдэг хувьцаа эзэмшигч Юнайтедпартс ХХК нь уул уурхай, барилга угсралт, эрчим хүч үйлдвэрлэх, цемент, эрдэс боловсруулах үйлдвэрийн үйлчилгээнд чиглэсэн төрөл бүрийн бүтээгдэхүүнийг нийлүүлдэг. Тус компани нь борлуулалтын дараах дэмжлэг, гүйцэтгэл, техникийн сургалт, чанар сайтай бүтээгдэхүүний нийлүүлэлт зэрэг гинжин холбоо бүхий үйлчилгээний шийдлийг харилцагчдад хүргэдэг.

**Новатек Интернэшнл ХХК**
Нөмөр Кредитийн 13.81 хувийг эзэмшиж буй хөрөнгө оруулагч компани юм. Тус компани нь 2002 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд Монгол Улсын эрчим хүчний салбарт төрөл бүрийн техник, тоног төхөөрөмж, өргөх механизм, холбогдох сэлбэг материалыг нийлүүлж, борлуулалтын дараах үйлчилгээ үзүүлдэг. Үйлдвэрлэгчдийн мэдээллийн баазад үндэслэн, дэлхийд тэргүүлэгч бүтээгдэхүүн, тоног төхөөрөмжийг албан ёсны эрхтэйгээр нийлүүлж буй компани юм. Тус компани нь 2015 онд Монгол Улсын ТОП-100 аж ахуйн нэгжээр тодорсон. Нөмөр Кредит нь үйлчлүүлэгчдийн итгэлийг олсон тэргүүлэгч байгууллагуудын нэг төдийгүй нийгмийн хариуцлагыг бүрэн ухамсарлаж, үйл ажиллагаанд бүрэн тусгаж ажиллаж ирсэн.

**Б. Гантулга** нь Нөмөр Кредитийн 10.48 хувийг эзэмшдэг бөгөөд ИБУИНВУ-ын Ланкастерийн Их Сургуульд санхүү, эдийн засагч мэргэжлээр бакалавр, Кэмбрижийн Их Сургуульд философийн чиглэлээр магистрын зэрэг тус тус хамгаалсан. Тэрээр Намир Группийн Гүйцэтгэх захирлын албыг хашдаг.

**Эрчим Электрик ХХК**
Нөмөр Кредитийн 2.38 хувийг эзэмшдэг инженеринг, худалдан авалт, олон нийт болон хувийн хэвшлийн харилцагчдад зориулсан барилгын менежментийн (EPCM) шийдэл санал болгодог. Тус компани нь цахилгаан,

дулааны эрчим хүчний тоног төхөөрөмж, сэлбэг материалуудын хангаң нийлүүлэлт, угсралт суурилуулалт, засвар үйлчилгээ үзүүлдэг.

**Б.Болортуяа** нь Нөмөр Кредитийн 0.43 хувийг эзэмшдэг бөгөөд СЭЗИС-ийг санхүүгийн удирдлагын бакалаврын зэрэгтэйгээр төгссөн. Тэрээр Нөмөр Кредитийн үндсэн үйл ажиллагааг хариуцан ажилладаг ерөнхий менежерийн албан тушаалыг хашдаг.

**Б.Эрдэнэбилэг** нь Нөмөр Кредитийн 0.43 хувийг эзэмшдэг бөгөөд ШУТИС-ийн Компьютерын шинжлэх ухааны бакалавр, АНУ-ын Небраскийн Их Сургуулийн Мэдээллийн системийн менежментийн магистр зэрэгтэйгээр төгссөн. Тэрээр Нөмөр Кредит ББСБ-ийн программ хангамж хөгжүүлэлтийг хариуцсан ерөнхий менежерээр ажиллаж байна.

**А.Энхжин** нь Нөмөр Кредитийн 0.43 хувийг эзэмшдэг бөгөөд Монгол улсын их сургуулийг компьютерийн програм хангамжийн мэргэжлээр төгөссөн. Тэрээр Нөмөр Кредит ББСБ-д програм хангамжийн инженерийн албан тушаалийг хашдаг.

## 5.3 Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн удирдлагын баг

Нөмөр Кредит ББСБ ХХК нь компанийн засаглалын зарчмын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурал, түүнийг төлөөлөх Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ), гүйцэтгэх удирдлага, тэдгээрийн эрх үүргийг тодорхойлон олон улсын стандартын дагуу санхүүгийн тайлагналыг бэлтгэн, дотоод болон хөндлөнгийн аудитын хяналт шалгалт, дотоод хяналт, зохицуулагч байгууллагаас шаардах эрсдэлийн удирдлагын зохистой хэм хэмжээг мөрдлөгө болгон ажилладаг.

### 5.3.1 Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн ТУЗ-ийн гишүүдийн мэдээлэл

**❖ Б.Гантулга, Нөмөр Кредит ББСБ ХХК-ийн ТУЗ-ийн дарга**

Б.Гантулга нь ИБУИНВУ-ын Ланкастерийн Их Сургуульд санхүү, эдийн засагч мэргэжлээр бакалавр, Кэмбрижийн Их Сургуульд философийн чиглэлээр магистрын зэрэг тус тус хамгаалсан. Тэрээр Намир Группийн Гүйцэтгэх захирлын албыг хашдаг. Нөмөр Кредит ББСБ ХХК-ийн ТУЗ-ийн даргын албыг хашиж байна.

**❖ Ж.Баатарсүрэн, Нөмөр Кредит ББСБ ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн**

Намир Группийг үүсгэн байгуулагч Ж.Баатарсүрэн нь ОХУ-ийн Урал Мужийн Техникийн Их Сургуульд дулааны инженер чиглэлээр бакалавр, Олон Улсын Худалдааны Академид худалдаа болон эдийн засгийн чиглэлээр магистрын зэрэг хамгаалсан. 2015 он хүртэл Намир Группийн захирлаар ажилласан бөгөөд эдүгээ тус компанийн ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байна.

**❖ Э.Сувд, Нөмөр Кредит ББСБ ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн**

Э.Сувд нь Санхүү Эдийн Засгийн их сургуульд санхүү менежментийн чиглэлээр бакалаврын зэрэг хамгаалсан. Банк санхүүгийн салбарт 10 гаруй жил ажилласан туршлагатай. 2018 оноос хойш Намир Групп ХХК-д ахлах санхүүгийн менежерээр ажиллаж байна.

**❖ Б. Анар, Нөмөр Кредит ББСБ ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн**

Б.Анар нь Санхүү Эдийн Засгийн их сургуульд санхүү, бизнесийн удирлдагын чиглэлээр бакалавар, Венийн Хэрэглээний Шинжилэх Ухааны их сургуульд олон улсын банк санхүүгийн чиглэлээр магистерийн зэрэг хамгаалсан. Голомт Банканд санхүүгийн шинжээч, Намир Групп ХХК-д хөрөнгө оруулалтын менежерээр ажилж байсан туршлагатай.

**❖ О.Лхагвадорж , Нөмөр Кредит ББСБ ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн**

СЗХ 2022 он 09 сар 21 өдөр БҮРТГЭВ № 01
Голомт Капитал ҮЦК ХХК Golomt Capital
УЛААНБААТАР ХОТ НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЗК 9022080393 6862705 СБТ19638

О.Лхагвадорж нь Хүмүүнлэгийн Ухааны Их сургуулийг санхүүгийн удирдлага, нягтлан бодох бүртгэлээр дүүргэсэн. Тооцооны нягтлан болон ахлах нягтлангаар ажиллаж байсан туршлагатай.

### 5.3.2 Компанийн бүтэц

Нөмөр Кредит ББСБ ХХК нь нийт 4 алба нэгж хэлтэстэй 33 ажилтантай үйл ажиллагаа явуулдаг. Удирдлагын баг нь салбартаа олон жилийн туршлагатай мэргэжилтнүүдээс бүрдсэн.

**❖ Ж.Баатарсүрэн, Гүйцэтгэх захирал**

Ж.Баатарсүрэн нь ОХУ-ийн Урал Мужийн Техникийн Их Сургуульд дулааны инженер чиглэлээр бакалавр, Олон Улсын Худалдааны Академид худалдаа болон эдийн засгийн чиглэлээр магистрын зэрэг хамгаалсан. 2015 оноос Нөмөр Кредит ББСБ ХХК-ийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.

**❖ Б.Болортуяа, Зээл болон үйл ажиллагаа хариуцсан Ерөнхий менежер**

Б.Болортуяа нь Нөмөр Кредитийн үндсэн үйл ажиллагааг хариуцдаг. Б.Болортуяа нь СЭЗИС-ийг санхүүгийн удирдлагын бакалаврын зэрэгтэйгээр төгссөн.

**❖ Б.Эрдэнэбилэг, Технологи хариуцсан ерөнхий менежер**

Б.Эрдэнэбилэг нь Нөмөр Кредитийн программ хангамж хөгжүүлэлтийг хариуцдаг. Тэрээр 2012-2016 онд Болорсофт ХХК-д Скрам мастер ба программ хангамжийн инженер, Монгол Ай Ди ХХК-д Системийн инженерээр ажиллаж байсан туршлагатай. ШУТИС-ийн Компьютерын шинжлэх ухааны бакалавр, АНУ-ын Небраскийн Их Сургуулийн Мэдээллийн системийн менежментийн магистр зэрэгтэйгээр төгссөн.

## 5.4ББСБ салбарын судалгаа, хэтийн төлөв

2021 оны байдлаар Монгол улсын ДНБ-ий 4.8 хувийг санхүү, даатгалын салбар бүрдүүлж байна. Санхүүгийн салбарын нийт хөрөнгийн хэмжээ 2021 оны эцэст 49.2 их наяд төгрөгт хүрсэн. Үүнээс банкны салбарын хөрөнгө 40 их наяд төгрөг буюу 81 хувийг, хөрөнгийн зах зээл 5.8 их наяд төгрөг буюу 12 хувийг, ББСБ салбар 2.7 их наяд төгрөг буюу нийт зах зээлийн 6 хувийг, даатгалын салбар 425 тэрбум төгрөг буюу 1 хувийг, үлдсэн 291 тэрбум төгрөг буюу 0.6 хувийг хадгаламж зээлийн хоршооны салбар бүрдүүлж байна.

numur
БҮРТГЭВ

График 14. Санхүүгийн салбарын бүтэц




*Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо*

Монгол улсын санхүүгийн салбарын дийлэнх хувийг банкны салбар эзэлж байгаа ч сүүлийн жилүүдэд бусад салбарууд хурдацтай өсөж байна. Сүүлийн 3 жилийн хугацаанд ББСБ-ын салбар жилд дунджаар 28 хувиар, хөрөнгийн зах зээл 33 хувиар, хадгаламж зээлийн хоршоо 13 хувиар, даатгалын салбар 9 хувиар, банкны салбар 11 хувиар тус тус өссөн байна. ББСБ-ын салбар болон хөрөнгийн зах зээл өсөлтөөрөө санхүүгийн зах зээлийг тэргүүлж байна.

**График 15. Санхүүгийн салбарын өсөлт /дэд салбар/**




*Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо*

ББСБ-ын салбар нь 2013 оноос эхлэн хурдацтай хөгжиж байна. Тухайлбал 2012 онд нийт 229 ББСБ үйл ажиллагаа явуулж байсан бол 2021 оны байдлаар 534-т хүрч 2.3 дахин өссөн байна. Үүнээс 85 хувь нь Улаанбаатар хотод үйл ажиллагаагаа явуулдаг бол 15 хувь нь хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж байна. Эдийн засгийн нөхцөл байдал, хүн амын

Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Delivering diversity
Улаанбаатар хот



УЛААНБААТАР ХОТ
НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЗК ХХК
9022080593

амьжиргааны түвшингээс хамаарч ББСБ-ын харилцагчдын тоо 2015 оноос хойш 8 дахин өсөж давхардсан тоогоор 4.8 саяд хүрсэн байна.

**График 16. ББСБ-ын үйл ажиллагааны үзүүлэлтүүд**




*Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо*

ББСБ-ын нийт хөрөнгө сүүлийн 5 жилийн хугацаанд жилд дунджаар 28.0 хувиар өсөж 2021 оны байдлаар 2.7 их наяд төгрөгт хүрснээс 70 хувийг нь зээл, 16 хувийг мөнгөн хөрөнгө, 14 хувийг бусад актив бүрдүүлж байна.

**График 17. ББСБ салбарын хөрөнгийн бүтэц (тэрбум төгрөг)**




*Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо*

ББСБ-ын салбарын нийт зээлийн багцын үлдэгдэл 2013 оноос хойш 8.7 дахин өсөж, 2021 оны байдлаар 1.9 их наяд төгрөгт хүрч нийт хөрөнгийн 70 хувийг бүрдүүлж байна. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хэмжээ эдийн засгийн уналттай он жилүүд болох 2015-2016 онуудад өсөж хамгийн өндөр түвшин буюу 15 хувьд хүрч байсан бол 2017-2018 онуудын эдийн засгийн сэргэлтийн үеүдэд буурч, 2019 онд 9 хувьд хүрсэн. 2020 онд Ковид-19 цар тахлын байдлаас үүдэлтэй эдийн засгийн хүндрэл, иргэдийн зээл төлөх, худалдан авах чадвар буурснаар чанаргүй зээлийн хувь эрген өсөж 11 хувьд хүрсэн

байна. 2021 оны байдлаар ББСБ салбар нь нийт 1.9 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй, 7.0 хувийн чанаргүй зээлийн үзүүлэлттэй байна.

Санхүүгийн Зохицуулах Хорооноос “Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-д өөрчлөлт оруулж, 2021 оны 7 сарын 1-ийг хүртэл зээлийн ангилал бууруулах хоногийг уртасгаж, мөн зээлийн хугацаанд 2 дээш удаа өөрчлөлт оруулсан тохиолдолд ангилал бууруулах заалтыг түр зогсоосон байна.

**График 18. ББСБ салбарын зээлийн бүтэц (тэрбум төгрөг)**




*Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо*

ББСБ-ын салбарын өөрийн хөрөнгийн хэмжээ сүүлийн 5 жилийн хооронд жилд дунджаар 25.5 хувийн өсөлтийг үзүүлж, 2021 оны байдлаар 1.8 их наяд төгрөгт хүрсэн байна. 2021 оны эцсийн байдлаар ББСБ-ын салбарын эх үүсвэрийн 66.4 хувийг эздийн өмч, 33.6 хувийг өр төлбөр бүрдүүлж байна.

**График 19. ББСБ салбарын эх үүсвэрийн бүтэц (тэрбум төгрөг)**




*Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо*

Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Delivering diversity
1119289111 5481589
Улаанбаатар хот



УЛААНБААТАР ХОТ
НӨМӨР КРЕДИТ ББСБ
ХХК
9022080593
6852705 СБТ19638

## Финтек зээл

Монголбанкны зүгээс 2014 оноос эхлэн төлбөрийн системийг боловсронгуй болгох, финтекийн хөгжлийг дэмжих тал дээр эрх зүйн орчныг бүрдүүлэх, холбогдох дүрэм, журмыг шинэчлэх ажлыг хийсэн. 2019 онд Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд нийцүүлэн төлбөрийн системийн эрх зүйн нарийвчилсан зохицуулалтыг хийх зорилгоор Автомат клиринг хаус системийн дүрэм, Төлбөрийн системийн тайлан гаргах зааврыг шинээр боловсруулж, Төлбөрийн картын журам, Хөдөлгөөнт банкны үйлчилгээний журам, Цахим мөнгөний журмыг тус тус шинэчлэн баталсан. Эрх зүйн зохицуулалт сайжирсантай холбоотой ББСБ-ууд финтек хэлбэр лүү шилжих хандлага нэмэгдэж байна.

2021 оны байдлаар Монгол Улсад финтек зээлийн үйлчилгээг ухаалаг утасны аппликэйшнээр дамжуулан нийт 28 ББСБ 1,378,494 зээлдэгчдийн 655.1 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй үйл ажиллагаа явуулж байна. ББСБ-ууд финтек хэлбэр лүү шилжсэнээр ББСБ нь Монголбанкны зээлийн мэдээллийн сан болон төрийн мэдээлэл солилцооны ХУР мэдээллийн системээр дамжуулан өөрсдийн зээлийн скоринг үнэлгээг гаргаснаар хүний оролцоогүй зээл олгож эрсдэлийг бууруулж байна.

**График 20. Монгол улсын финтек ББСБ-уудын өсөлт**




*Эх сурвалж: СЗХ*

2021 оны эцсийн байдлаар нийт 28 финтек ББСБ үйл ажиллагаа явуулж байна. 2021 он гарснаас хойш Хас хаан, Солонго капитал, Нэт капитал финанс корпораци, Бизнес-Инвест Девелопмент, Гялс Кредит, Энт кредит Инвестмент, Омни капитал, Очир Ундраа ОМЗ, Сэндли, Эм Пи Эс Си, Зээл Эм Эн платформ, Грийн Финтек, Тус Финтек, Нанокапитал, Өсөх ундарга финанс, Гурван зуун жар файнанс, Эс ай си эй финанс зэрэг финтек ББСБ-ууд шинээр нэмэгдсэн байна.

## 5.5 Банк бус санхүүгийн байгууллагын салбарын цаашдын чиг хандлага

**Олон улсад ББСБ-ын зээлийн үйлчилгээ уламжлалтаас финтек руу шилжиж байна**

Дэлхийн финтек өгөгдлийн томоохон компаниудын нэг болох Findexable компаниас жил бүр дэлхийн улс орнуудын финтек скорингийг улс орнуудын финтек экосистемийн хүчирхэг байдал, финтек мэдээлэл, давуу талууд болон гадаад дотоод хүчин зүйлүүдийг авч үзэн эрэмбэлэх алгоритмын тусламжтайгаар гаргадаг. Доорх үр дүнгээс үзвэл улс орнуудын финтекийн хөгжил нь зээлийн хүртээмжтэй байдалтай нягт хамааралтай байна. Зээл их олгогддог буюу санхүүгийн салбар илүү хөгжсөн улс орнуудад финтек компаниуд зах зээлд илүү эрчээ авч хөгжих боломж нь нээгддэг (Financial Stability Board, 2019) ба зохицуулалтын таатай байдал нь финтекийн экосистемийг сайжруулдаг байна. Финтек 3.0 нь хөгжиж буй зах зээлтэй орнуудад зонхилон мэдрэгдсэн бөгөөд үүний үр нөлөөнд санхүүгийн салбар хөгжсөн орнуудад финтек илүүтэйгээр хөгжжээ. Харин финтек 3.5 болон зарим судлаачдын үзэж буйгаар финтек 4.0 нь 2015 оноос хойш хөгжиж буй орнуудад мэдрэгдэж байгаа билээ (Douglas W.Arner et al, 2017). Энэ нь хөгжиж буй оронд харьяалагддаг Монгол Улсын хувьд финтекийн салбар өсөх магадлал өндөр байгааг илтгэж байна.

**График 21. Улс орнуудын зээлийн хүрэлцээ ба финтек хөгжлийн хамаарал**




*Эх сурвалж: Bank for International Settlements*

2020 оноос эхлэн хэрэглэгчид финтек шийдлийг ашиглан, Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх үүднээс ямар ч контактгүй төлбөр тооцоо, санхүүгийн үйлчилгээг бүрэн цахимаар авахыг илүүд үзэж эхэлсэн. Үүнийг дагаад дэлхийн хэмжээнд финтек компаниуд цар хүрээгээ тэлэх шаардлага үүсэж, 2021 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 22.8 тэрбум ам.долларыг

татан төвлөрүүлж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 126 хувиар өссөн байна (The Financial Brand, 2021). Үүнээс 12.8 тэрбум ам.долларыг Хойд Америкийн орнууд, 5 тэрбум ам.долларыг Европын орнууд, 3.7 тэрбум ам.долларыг Азийн орнууд бүрдүүлж байна. Үүнээс цахим зээлийн санхүүжилт өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 3 дахин нэмэгдэж, 4 тэрбум ам.долларт хүржээ.

**График 22. Дэлхийн финтекийн салбарын хөрөнгө оруулалт**




*Эх сурвалж: Financial Brand*

Финтекийн салбар нийт зах зээлийн хувьд өндөр эрэлттэй байгаа бөгөөд финтек зээлийн салбарыг онцолж үзвэл 2020 оны байдлаар 401.3 тэрбум ам доллароор хэмжигдэж, үүнээс 45 хувийг Номхон Азийн орнууд бүрдүүлж байна. Тодруулбал, зээл олгох процессыг цахим хэлбэрт шилжүүлснээр санхүүгийн байгууллагуудад илүү оновчтой зээл олголтын шийдвэрийг богино хугацаанд гаргах, зээлийн эргэлтийг нэмэгдүүлэх, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, зардал хэмнэх зэрэг олон давуу талуудыг компанид авчирдаг. Дэлхийн томоохон технологийн компаниуд энэхүү зах зээлд хөл тавиад эхэлсэн бөгөөд Apple компани өөрсдийн дижитал кредит картаар дамжуулан 2019 оноос бичил хэрэглээний зээлийг олгож эхэлсэн байна. Мөн 2020 онд Google компани Gpay аппликейшнаар дамжуулан өөрсдийн цогц финтек үйлчилгээг нэвтрүүлж эхэлсэн байна. Цаашид энэ мэтчилэн дэлхийн хэмжээнд финтек салбарт оролцогчид нэмэгдсэнээр зах зээл тэлэх хандлагатай байна. Олон улсын судалгааны байгууллагуудын ш инжээчдийн таамгаар цахим зээлийн салбар жилд дунджаар 32.3 хувийн өсөлтийг үзүүлж, 2027 он гэхэд 3.1 их наяд долларт хүрэхээр тооцоолсон байна .

**Монгол Улсад ББСБ-ын дижитал шилжилт эрчимжих төлөвтэй байна**

Монгол Улсын хэмжээнд ухаалаг гар утас хэрэглэгчид буюу финтек салбарын зорилтот хэрэглэгчдийн тоо 3.4 сая байна. Финтек шилжилт санхүүгийн салбарт маш хурдацтай өрнөж байгаа бөгөөд сүүлийн 5 жилийн хугацаанд интернэт банкны идэвхтэй хэрэглэгчдийн тоо жилд дунджаар 58 хувиар

өссөн. Нөгөө талаас идэвхтэй карт хэрэглэгчдийн тоо сүүлийн 5 жилийн хугацаанд жилд дунджаар 4 хувиар буурсан байна. Зорилтод хэрэглэгчид шинэ технологид хурдан дасан зохицож, санхүүгийн байгууллагууд дижитал шилжилтийг түлхүү анхаарч ажилласнаар Монгол Улсад финтек салбар цаашид өргөжин тэлэх бүрэн боломжтой байна.

**График 23. Хөдөлгөөнт банкны тоон үзүүлэлтүүд**




*Эх сурвалж: Монголбанк*

**Эдийн засгийн өсөлт нь ББСБ-ын тэлэлтийн суурь үндэс болж байна**

ББСБ-ын салбар нь эдийн засгийн нөхцөл байдалтай шууд хамааралтай оршдог. Тодруулбал, 2012-2022 оны ББСБ салбарын нийт зээлийн өсөлт болон ДНБ-ний өсөлтийн хамаарлын коэффициент 0.84 байгаа нь эдийн засаг болон зээлийн харилцан хамаарал өндөр байгааг илтгэж байна. 2015-2021 онуудад Монгол Улсын эдийн засаг жилд дунджаар 2.49 хувийн өсөлт үзүүлсэн бол ББСБ салбарын нийт зээл жилд дунджаар 31.71 өсчөсөж бодит эдийн засгаас өндөр өсөлт үзүүлсэн байна.

**График 24. ББСБ салбарын нийт зээлийн өсөлт ба эдийн засгийн өсөлт**




*Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо, Голомт Капитал ҮЦК тооцоолол*

2011-2020 оны эдийн засгийн өсөлт болон ББСБ салбарын чанаргүй зээл нь хүчтэй сөрөг хамааралтай байна. Тодруулбал, эдийн засгийн өсөлттэй жилүүдэд чанаргүй зээлийн хэмжээ буурсан бол эдийн засаг сулрах хугацаанд зээлийн чанаргүйдэл өссөн байна. Үүнээс үзэхэд, олон улсын шинжээчдийн таамаглалаар Монгол Улсын эдийн засаг 2022 онд дунджаар 2.3 хувиар өсөхөөр хүлээгдэж байна. Энэ нь иргэдийн худалдан авах чадвар сайжирч, өрхийн орлого нэмэгдэх, бизнесийн үйл ажиллагаа сэргэснээр зээлийн эрэлтийг нэмэгдүүлж, чанарыг сайжруулах боломжтойг харуулж байна.

**График 25. ББСБ салбарын чанаргүй зээлийн хувь ба эдийн засгийн өсөлт**




*Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо, Голомт Капитал ҮЦК тооцоолол*

## 5.6 Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн санхүүгийн байдал

**Санхүүгийн байдлын тайлангийн шинжилгээ**

**Хүснэгт 20. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдлын тайлан**

| Санхүүгийн байдлын тайлан (сая төгрөгөөр) | 2018 | 2019 | 2020 | 2021 |
|---|---|---|---|---|
| **ХӨРӨНГӨ** | | | | |
| Мөнгөн хөрөнгө | 86.1 | 574.1 | 354.6 | 1,707.2 |
| Зээл /цэврээр/ | 867.2 | 2,246.8 | 5,242.1 | 21,193.0 |
| Бусад авлагууд | 201.0 | 1,382.2 | 1,842.3 | 2,758.5 |
| Бусад хөрөнгө | 76.0 | 82.5 | 94.3 | 139.8 |
| **Эргэлтийн хөрөнгийн нийт дүн** | **1,230.2** | **4,285.6** | **7,533.3** | **25,798.5** |
| Үндсэн хөрөнгө | 10.4 | 61.5 | 147.8 | 490.2 |
| Биет бус хөрөнгө | - | - | 2.3 | - |
| **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **10.4** | **61.5** | **150.0** | **490.2** |
| **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,240.5** | **4,347.1** | **7,683.4** | **26,288.6** |
| **ӨР ТӨЛБӨР** | | | | |
| Банк, санхүүгийн байгууллагаас авсан богино хугацаат зээл | - | - | - | 1,800.0 |
| Өрийн бичгээрх өглөг | - | 1,000.0 | 1,000.0 | 2,000.0 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Итгэлцлийн үйлчилгээний өглөг | - | - | - | 6,795.0 |
| Төслийн зээлийн богино хугацаат санхүүжилт | - | - | - | 4,300.0 |
| Бусад өр төлбөр | 75.5 | 434.9 | 980.9 | 2,118.2 |
| **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | **75.5** | **1,434.9** | **1,980.9** | **17,013.2** |
| **Нийт өр төлбөрийн дүн** | **75.5** | **1,434.9** | **1,980.9** | **17,013.2** |
| **ЭЗДИЙН ӨМЧ** | | | | |
| Хувьцаат капиталын дүн | 1,000.0 | 2,500.0 | 4,500.0 | 6,500.0 |
| Хуримтлагдсан ашиг /алдагдал/ | 165.1 | 412.1 | 1,202.5 | 2,775.4 |
| **Эздийн өмчийн дүн** | **1,165.1** | **2,912.1** | **5,702.5** | **9,275.4** |
| **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН** | **1,240.5** | **4,347.1** | **7,683.4** | **26,288.6** |

*Эх сурвалж: Компанийн аудитлагдсан жилийн тайлан*

Нөмөр Кредит ББСБ ХХК-ийн нийт хөрөнгө 2018 оноос хойш 21.2 дахин өсөж 2021 оны байдлаар 26.3 тэрбум төгрөгт хүрчээ. Нийт хөрөнгийн 81 хувийг цэвэр зээл, 10 хувийг бусад авлага, 6 хувийг мөнгөн хөрөнгө, 2 хувийг үндсэн хөрөнгө болон биет бус хөрөнгө, үлдсэн 1 хувийг бусад хөрөнгө бүрдүүлж байна.

**График 26. Нийт хөрөнгө (сая төгрөг)**




**График 27. Нийт хөрөнгийн бүтэц**




*Эх сурвалж: Компанийн аудитлагдсан жилийн тайлан*

Нөмөр Кредитийн зээлийн багц 2018 оноос хойш 24 дахин өсөж 21.2 тэрбум төгрөгт хүрсэн. 2022 оны хагас жилийн байдлаар нийт зээлийн багц 36.7 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд үүний 90.4 хувийг хэвийн зээл, 4.2 хувийг анхаарал хандуулах зээл, үлдсэн 5.4 хувийг чанаргүй зээл эзэлж байна. Түүнчлэн тус тайлант хугацаанд автомашины болон финтек зээл ба бусад зээлийн үзүүлэлтүүд доорх байдалтай байна.

| Зээлийн үзүүлэлт | Зээлийн үлдэгдэл (сая төгрөг) | Хэвийн | Анхаарал хандуулах | Чанаргүй |
|---|---|---|---|---|
| Хэрэглээнд зориулсан зээл | 21,681.4 | 86.0% | 5.4% | 8.6% |
| Бизнесийн үйл ажиллагаанд зориулсан зээл | 533.8 | 99.7% | 0.3% | 0.0% |
| Автомашин худалдан авахад зориулсан зээл | 14,466.3 | 96.7% | 2.6% | 0.7% |
| **НИЙТ** | **36,681.5** | **90.4%** | **4.2%** | **5.4%** |
| Үүнээс: Аппликэйшнээр олгосон зээл | 21,604.3 | 86.0% | 5.4% | 8.6% |

**График 28. Цэвэр зээл (сая төгрөг)**




**График 29. Бусад авлага, хөрөнгө (сая төгрөг)**




*Эх сурвалж: Компанийн аудитлагдсан жилийн тайлан*

2018 оны байдлаар Нөмөр Кредит ББСБ ХК-ийн нийт эх үүсвэрийн 6.1 хувийг өр төлбөр эзэлж байсан. Харин 2021 оны байдлаар Үнэт цаас өрийн санхүүжилт 65 хувийг эзэлж 17.0 тэрбум төгрөгт хүрсэн байна. Өсөлтийн гол шалтгаан нь үйл ажиллагаа тэлэх, хэрэглэгчдийн зээлийн эрэлт өндөр байгаагаас үүдэн нэмэлт зээл олгох зорилгоор бондын санхүүжилтээр хөрөнгө босгосон, мөн банк санхүүгийн байгууллагаас авсан зээлийн санхүүжилттэй холбоотой. Мөн Нөмөр Кредит нь 2020 оны 11 сард итгэлцлийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрлийг Санхүүгийн зохицуулах хорооноос авснаар харилцагчдын мөнгөн хөрөнгийг татаж удирдах боломжтой болсноор итгэлцлийн үйлчилгээний өглөг бий болсон. 2021 оны байдлаар нийт богино хугацаат өр төлбөрийн 40 хувийг итгэлцлийн үйлчилгээ, 12 хувийг бонд, 25 хувийг төслийн зээл, 11 хувийг банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл, үлдсэн 13 хувийг бусад өр төлбөр эзэлж байна.

Нөмөр Кредит ББСБ ХХК-ийн эздийн өмч 2018 оноос хойш 7.5 дахин өсөж 2021 оны байдлаар 9.3 тэрбум төгрөгт хүрч, нийт эх үүсвэрийн 35 хувийг эзэлж байгаагаас 70 хувийг хувь нийлүүлсэн хөрөнгө үлдсэн 30 хувийг хуримтлагдсан ашиг бүрдүүлж байна.

**График 30. Нийт өр төлбөр (сая төгрөг)**




**График 31. Эздийн өмч (сая төгрөг)**




*Эх сурвалж: Компанийн аудитлагдсан жилийн тайлан*

### Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн шинжилгээ

**Хүснэгт 21. Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд**

| | 2018 | 2019 | 2020 | 2021 |
|---|---|---|---|---|
| Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 30% < | 99% | 75% | 77% | 37% |
| Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 20% < | 99% | 75% | 77% | 37% |
| Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө нийт активын харьцаа 30% < | 94% | 67% | 74% | 36% |
| Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 8% < | 114% | 40% | 18% | 14% |
| Итгэлцлийн үйлчилгээний өглөгийн зохистой харьцаа 80% > | - | - | - | 73% |
| Өрийн бичгийн зохистой харьцаа 50% > | - | 34% | 18% | 22% |

*Эх сурвалж: Компанийн аудитлагдсан жилийн тайлан*

Нөмөр Кредит ББСБ ХХК нь Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон ББСБ-ын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг амжилттай биелүүлж ирсэн. 2021 оны байдлаар зээлийн өсөлтөөс үүдэлтэй өөрийн хөрөнгийн харьцаа буурсан ч зохистой түвшинд байна. Мөн 2021 оноос эхлэн итгэлцлийн үйлчилгээг явуулж эхэлсэн бөгөөд итгэлцлийн үйлчилгээний өглөгийн зохистой харьцааны түвшинд үйл ажиллагаагаа явуулж байна.

### Нөмөр Кредит ББСБ ХХК-ийн орлогын тайлангийн шинжилгээ

**Хүснэгт 22. Орлого үр дүнгийн тайлан**

| Орлогын тайлан (сая төгрөгөөр) | 2018 | 2019 | 2020 | 2021 |
|---|---|---|---|---|
| Хүүгийн орлого | 281.3 | 977.0 | 1887.5 | 4,409.3 |
| Хүүгийн зардал | - | 107.8 | 285.9 | 537.7 |
| **Цэвэр хүүгийн орлого** | **281.3** | **869.2** | **1,601.6** | **3,871.6** |
| Хүүгийн бус орлого | 13.0 | 138.2 | 346.5 | 745.0 |
| Хүүгийн бус зардал | 172.1 | 560.6 | 1,120.1 | 2,426.2 |
| **Сан байгуулахаас өмнөх үйл ажиллагааны ашиг/алдагдал** | **122.3** | **446.8** | **828.1** | **2,190.4** |
| Болзошгүй эрсдэлийн зардал | 1.1 | 149.5 | 229.1 | 219.7 |
| **Үндсэн үйл ажиллагааны ашиг** | **121.2** | **297.3** | **598.9** | **1,970.7** |
| Үндсэн бус үйл ажиллагааны орлого | 12.9 | 22.8 | 292.9 | 20.4 |
| Үндсэн бус үйл ажиллагааны зардал | 20.0 | 41.3 | 74.9 | 11.2 |
| **Ердийн үйл ажиллагааны ашиг** | **114.0** | **278.8** | **817.0** | **1,979.9** |
| Ердийн бус орлого | 12.2 | 0.3 | 34.7 | - |
| **Татварын өмнөх ашиг** | **126.2** | **279.1** | **851.6** | **1,979.9** |
| Орлогын татварын зардал | 11.9 | 32.0 | 61.3 | 199.1 |
| **Цэвэр ашиг** | **114.3** | **247.1** | **790.3** | **1,780.8** |

*Эх сурвалж: Компанийн аудитлагдсан жилийн тайлан*

numur сэх
Зөвшөөрсөн Төв сар 21 өдөр
БҮРТГЭВ
Үнэт цаасны танилцуулга
2022-09-20
БҮРТГЭВ
Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Delivering diversity
1119289111 5481589
Улаанбаатар хот
УЛААНБААТАР ХОТ
НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЭК ХХК
9022080593
6862705 СБТ19638

Нөмөр Кредит ББСБ ХХК нь 2017 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд үүссэн цагаасаа хойш хурдацтай өсөж буй компани юм. Үнэт цаас гаргагчийн хүүгийн орлого 2018 оноос хойш жилд дунджаар 150 хувиар өсөж 2021 оны байдлаар зээлийн хүүгийн орлого 4.4 тэрбум төгрөгт хүрсэн.

Үйл ажиллагаа тэлэх, зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилгоор Нөмөр Кредит ББСБ ХХК нь 2018 оноос эхлэн өрийн санхүүжилтийг ашиглаж эхэлсэн. 2020 онд Нөмөр Кредит ББСБ ХХК нь 1.5 тэрбум төгрөгийн бонд, 2021 онд 2 тэрбум төгрөгийн бонд гаргаснаар хүүгийн зардал 2021 онд 538 сая төгрөгт хүрсэн байна.

**График 32. Хүүгийн орлого (сая төгрөг)**




**График 33. Хүүгийн зардал (сая төгрөг)**




*Эх сурвалж: Компанийн аудитлагдсан жилийн тайлан*

**Ашигт ажиллагааны үзүүлэлтүүд**

2018 оноос хойш Нөмөр Кредит ББСБ ХХК-ийн цэвэр ашиг жилд дунджаар 150 хувиар өсөж, 2021 онд 1,781 сая төгрөгт хүрсэн байна. 2021 оны эцсийн байдлаар цэвэр ашгийн ахиц 34 хувь, үйл ажиллагааны ашгийн ахиц 38 хувь тус тус байна.

**График 34. Цэвэр ашиг (сая төгрөг)**




**График 35. Ашигт ажиллагааны харьцаа**




*Эх сурвалж: Компанийн аудитлагдсан жилийн тайлан*

## 5.7 Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эрсдэлийн удирдлага

**Зээлийн эрсдэл**

Эдийн засгийн нөхцөл байдал, инфляцын өсөлт, цар тахлын нөхцөл байдлаас үүдсэн орлогын тасалдал, зардлын өсөлт, бусад шалтгаануудын улмаас харилцагч зээлийн төлбөрөө хугацаанд эсвэл бүрэн төлж чадахгүй нөхцөл байдал үүсэх эрсдэлтэй.

**Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл**

Мэдээллийн системийн дутмаг байдал, техник хангамж, технологийн алдаа дутагдлаас үүдэн харилцагчийн хувийн мэдээлэл задрах, нууц мэдээлэл задрах мөнгө хөрөнгөө алдах зэрэг эрсдэлүүд үүсэх магадлалтай.

**Үйл ажиллагааны эрсдэл**

Нөмөр Кредит ББСБ ХХК-ийн дотоод зохион байгуулалт, хүний нөөц зэрэг нь өдөр тутмын үйл ажиллагаанд алдаа дутагдал гаргах үүнээс үүдэн компанийн үйл ажиллагаа тасалдах, үйл ажиллагааны төлөвлөгөө өөрчлөгдөх эрсдэлтэй.

**Нэр хүндийн эрсдэл**

Санхүүгийн салбар нь харилцагчийн итгэлцэл дээр тогтдог. Үйл ажиллагааны дутмаг байдал, ажилтны алдаа, системийн алдаа, удаашралтай байдлаас үүдэн харилцагч үнэт цаас гаргагчийн бүтээгдэхүүн үйлчилгээнд сэтгэл ханамжгүй байх, цаашлаад нийгэмд компанийн талаарх сөрөг сэтгэгдэл, мэдээ мэдээлэл гарснаар хэрэглэгчдийн тоо буурах, орлого буурах эрсдэлтэй.

**Хөрвөх чадварын эрсдэл**

Үйл ажиллагааны буруу төлөвлөлт, төлөвлөгөөндөө хүрч ажиллаж чадахгүй байх, зохистой харьцааг хэтрүүлсэн гэх зэрэг шалтгаануудаас үүдэлтэй итгэлцлийн үйлчилгээний төлбөр болон бусад холбогдох өр төлбөрөө хугацаанд төлөхгүй байх эсвэл төлбөрийн чадваргүй нөхцөл байдал үүсэх эрсдэлтэй.

**Хууль, зүйн эрсдэл**

Санхүүгийн зохицуулах хороо болон бусад зохицуулагч байгууллагаас гаргасан хууль, тогтоомж, дүрэм журмыг мөрдөж ажиллаагүйн улмаас үйл ажиллагаа тасалдах, тусгай зөвшөөрлөө хураалгах гэх зэрэг эрсдэл үүсэх магадлалтай.

Нөмөр Кредит ББСБ нь дээрх эрсдэлийг бууруулах зорилгоор тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлдэг бөгөөд эдгээр арга хэмжээг дор дурдлаа.

Бүртгэв

Хүснэгт 23. Үнэт цаас гаргагчийн бизнес төлөвлөгөөнд учирч болох эрсдэлүүд

| Эрсдэлийн төрлүүд | Үр нөлөө | Тохиолдох магадал | Эрсдэлийн хэмжээ | Авч хэрэгжүүлэх арга хэмжээ |
|---|---|---|---|---|
| Зээлийн эрсдэл | Их | Дунд | Эрсдэлийг зайлшгүй бууруулах | Чанаргүй зээлийн хэмжээг тодорхой түвшинд барих, зээлийн эрсдэлийн сан байгуулах |
| Хууль зүйн эрсдэл | Дунд | Бага | Маш бага эрсдэлтэй | Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг тогтмол мөрдөх, хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаагаа явуулах |
| Хөрвөх чадварын эрсдэл | Их | Бага | Бага эрсдэлтэй, анхаарах шаардлагатай | Мөнгөн хөрөнгийг үр ашигтай удирдах, үйл ажиллагааны төлөвлөгөөг тогтмол гаргах, өрийн түвшинг зохист хэмжээнд барих |
| Нэр хүндийн эрсдэл | Их | Бага | Бага эрсдэлтэй, анхаарах шаардлагатай | Системийн сайжруулалтыг тогтмол хийх, харилцагчийн үйлчилгээг сайжруулах |
| Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл | Их | Дунд | Эрсдэлийг зайлшгүй бууруулах | Системийн сайжруулалтыг үргэлж хийх, олон улсын хамгаалалтын системийг ашиглах |
| Үйл ажиллагааны эрсдэл | Их | Бага | Бага эрсдэлтэй, анхаарах шаардлагатай | Үйл ажиллагаа, системийн аюулгүй байдал, системийг алдаагүй хэвийн үйл ажиллагааг хангах |

Голомт Капитал ҮЦК ХХК
Улаанбаатар хот



УЛААНБААТАР ХОТ
НӨМӨР КРЕДИТ ХХК
9022080593
6862705 СБТ19638

СЭХ
ҮТГЭЭ

# ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ

# 6 ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ

## 6.1 Үйлчилгээ үзүүлэгчийн тухай мэдээлэл, үүрэг

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт зааснаар үйлчилгээ үзүүлэгч нь үүрэг гүйцэтгэгчтэй харилцаж, хөрөнгөтэй холбоотой төлбөрийг цуглуулан тусгай зориулалтын компанид шилжүүлэх, бүртгэх, тайлагнах болон үйлчилгээ үзүүлэх гэрээнд заасан хөрөнгөтэй холбоотой бусад үйлчилгээ, үйл ажиллагаа эрхлэхээр үнэт цаас гаргагчтай гэрээ байгуулсан хуулийн этгээд байна.

Үйлчилгээ үзүүлэгчийн эрх үүрэг:

- Үйлчилгээ үзүүлэгч нь үйлчилгээ үзүүлэх гэрээний нөхцөл болон Үнэт цаас гаргагч эсхүл түүний төлөөлөгчөөс бичгээр ирүүлсэн зааварчилгаанд дурдсан нөхцөлийн дагуу үйл ажиллагаа явуулна
- Үйлчилгээ үзүүлэгч нь хөрөнгөөс олох орлогыг баталгаат үнэт цаасны хөрөнгийн багц тус бүрээр, багцын тодорхой хэсгээр тусдаа дансанд хуримтлуулна.

## 6.2 Үйлчилгээ үзүүлэгчтэй байгуулсан гэрээ

Үнэт цаас гаргагч нь анхны үүрэг гүйцэтгүүлэгч болох “Нөмөр Кредит ББСБ” ХХК-тай Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээ болон Захиргааны үйлчилгээ үзүүлэх гэрээг байгуулсан болно. Төлбөр цуглуулах гэрээний хүрээнд Нөмөр Кредит ББСБ нь ХБҮЦ-ны төлбөрийг цаг хугацаанд нь цуглуулан, шилжүүлэх, бүртгэлийг хөтлөх, тайлагнах, Зээлийн эрсдэлийг удирдах журмын дагуу зээлийн хяналт тавьж, зээл төлүүлэх үйл ажиллагааг хариуцан ажиллана.

“Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээ”-ний дагуу Үйлчилгээ үзүүлэгч нь дараах чиг үүрэгтэй байна. Үүнд:

- Үйлчилгээ үзүүлэгч нь Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээний нөхцөл болон Үнэт цаас гаргагч, эсхүл Хөрөнгө итгэмжлэн удирдагчаас түүнд бичгээр өгсөн зааварчилгаанд дурдсан нөхцөлийн дагуу үйлчилгээг үзүүлнэ;
- Үйлчилгээ үзүүлэгч нь хөрөнгийн багцад багтсан зээлийн Зээлдэгч, үүрэг гүйцэтгэгч нартай харилцах, төлбөр цуглуулах, зээл төлүүлэх арга хэмжээг өөрийн холбогдох Зээлийн эрсдэлийг удирдах журамд заасны дагуу хэрэгжүүлэх, зээлдэгчийн өмнө Үнэт цаас гаргагчийг төлөөлж, зээлийн эргэн төлөлтийг гэрээнд заасан хугацаанд Үнэт цаас гаргагчид шилжүүлэх, бүртгэх, тайлагнах;
- Зээлдэгчийн хүсэлтийн дагуу Зээлийн гэрээнд өөрчлөлт оруулж, төлбөрийн хуваарьт өөрчлөлт оруулсан бол Үйлчилгээ үзүүлэгч нь энэ талаарх мэдээллийг Хөрөнгө итгэмжлэн удирдагчид Зээлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулсан сард багтааж мэдэгдэнэ. Зээлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт орсноор Хөрөнгөд багтсан Зээлийн багцын шалгуур үзүүлэлтийг хангахгүй болсон тохиолдолд ТЗК-ийн Багцын хөрөнгөд

өөрчлөлт оруулах журамд заасны дагуу арга хэмжээ авна;

- Үйлчилгээ үзүүлэгч нь хөрөнгийн багцад багтсан зээлийн мэдээллийг хадгалах, Үнэт цаас гаргагч, Хөрөнгө итгэмжлэгдэн удирдагчийн хууль ёсны шаардлагаар Үнэт цаас гаргагчтай холбоотой аливаа дүгнэлт гаргахад шаардагдах мэдээлэл, баримт бичгийг хүргүүлэх, мэдээллээр хангах, зохих журмын дагуу үйл ажиллагаа явуулж, өөрийн гаргасан дүгнэлт, үйл ажиллагаанысхаа хариуцлагыг бие даан хүлээнэ;
- Үйлчилгээ үзүүлэгч нь өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас Үнэт цаас гаргагч болон Үнэт цаас эзэмшигчдэд хохирол учруулсан тохиолдолд өөрийн хөрөнгөөр тэдний өмнө хариуцлага хүлээнэ;
- Үнэт цаас гаргагчийн нэрийн өмнөөс зээлийн хүүгийн төлбөрийн татварын цахим бүртгэлийн баримтыг зээлдэгчид хүргүүлнэ;

Захиргааны үйлчилгээ үзүүлэгч нь дараах үүрэгтэй

- ТЗК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын ажил үүргийг гүйцэтгэх;
- ТЗК-ийн бичиг хэргийн хөтлөлт буюу албан бичиг хүлээж авах, илгээх;
- ТЗК-ийн мөнгөн хөрөнгөөс шаардлагатай мөнгөн гүйлгээг ТУЗ-ийн зөвшөөрлийн дагуу Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай хамтран гүйцэтгэх;
- Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаанд шаардлагатай мэдээ, мэдээллийг Хөрөнгө итгэмжлэн удирдагчид тухай бүр хүргүүлэх;
- ТЗК-ийн олон нийтэд хандсан цахим хуудсын хөгжүүлэлт, хөтлөлтийн ажлыг хариуцах;
- ТЗК-ийн жилийн үйл ажиллагааны тайланд аудит хийх ажлын бэлтгэлийг хангах, холбогдох баримт бичиг цуглуулж, хөндлөнгийн аудитад хүлээлгэн өгөх, буцаан авах, хөндлөнгийн аудитын дүгнэлтийг хүлээн авч ТУЗ болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчид хүргүүлэх;
- ТЗК-ийн жил бүрийн үйл ажиллагааны төсвийн төслийг бэлтгэж, ТУЗ-ийн хурлаар хэлцүүлэн батлуулах;
- ХБҮЦ-ны хэлцлийн гэрээ болон журамд өөрчлөлт оруулах тохиолдолд тэдгээрийн төслийг бэлтгэх, ТУЗ-өөр баталгаажуулан, Хөрөнгө итгэмжлэн удирдагчид хүлээлгэн өгөх;
- ХБҮЦ-ны багц дахь зээлийн хөрөнгийн барьцааны бүртгэлийг хийж гүйцэтгэх;
- ТЗК-ийн хагас жилийн болон жилийн үйл ажиллагааны тайлангийн мэдээллийг нэгтгэж, Хөрөнгө итгэмжлэн удирдагчид хүргүүлэх;
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон холбогдох бусад журмаар ТЗК-ийн ТУЗ-ийн эрх хэмжээнд хамааруулсан, ТЗК-ийн байгуулсан гэрээ болон баталсан журмаар зохицуулагдаагүй захиргааны шинжтэй бусад ажлыг ТУЗ-өөс өгсөн даалгаврын дагуу гүйцэтгэх.

### 6.3 Үйлчилгээ үзүүлэгчтэй байгуулсан гэрээг цуцлах нөхцөл

Үйлчилгээ үзүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд ТЗК нь гэрээг цуцалж, шинэ үйлчилгээ үзүүлэгчийг томилно.

Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Delivering diversity
1119289111 5481589
Улаанбаатар хот



УЛААНБААТАР ХОТ
НӨМӨР КРЕДИТ
ХХК
9022080593
6862705 СБТ19638

# ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАГЧИЙН ТУХАЙ

# 7 ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАГЧИЙН ТУХАЙ

## 7.1 Ерөнхий танилцуулга

“Юнайтед Айр Файнэнс” ХХК нь 2005 оны 1 дүгээр сарын 27-нд үүсгэн байгуулагдаж, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2021 оны 10 дугаар сарын 28 өдрийн 473 тоот тогтоолоор Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг ХБҮЦ-ны хөрөнгө итгэмжлэн удирдах чиглэлээр авсан.

| | |
|---|---|
| Байгууллагын нэр | "Юнайтед Айр Файнэнс" ХХК |
| Компанийн регистрийн дугаар | 2870657 |
| Тусгай зөвшөөрлийн дугаар: | ТЗ 316/18 |
| Гүйцэтгэх захирал | Х.Маргад-Эрдэнэ |
| Үйл ажиллагааны чиглэл | Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа |
| Хаяг | Улаанбаатар, Сүхбаатар, 8-р хороо, СТӨ-ний 10 давхарт 1005 тоот |

“Юнайтед Айр Файнэнс” ХХК нь банк, банк бус санхүүгийн байгууллага, ОССК болон Санхүүгийн Зохицуулах хорооноос зөвшөөрсөн бусад байгууллагын ТЗК-ийн санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлийг хөтлөх, үнэт цаасны баталгаа болж буй хөрөнгийн эргэн төлөлтийг цуглуулж, үнэт цаасны хэлцэлтэй холбоотой төлбөрийг гүйцэтгэх, мөнгөн хөрөнгийг зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалтад байршуулах, хөрөнгө оруулагч болон зохицуулагч байгууллагад тайлан мэдээ гаргах, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах ажлыг гүйцэтгэнэ.

Компани нь Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан нээлттэй гаргасан “Омни Капитал ББСБ” ХХК-ийн зээлийн багц дээр түшиглэсэн “Омни Актив ТЗК” ХХК-ийн 5 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй 24 сарын хугацаатай зээлийн багц барьцаалсан ХБҮЦ болон “Ашид Капитал ББСБ” ХХК-ийн хэрэглээний зээлийн багц дээр түшиглэсэн “Симпл Ассет ТЗК”-ийн 50 тэрбум төгрөгийн дүнтэй 18 сарын хугацаатай ХБҮЦ-ыг амжилттай удирдан ажиллаж байна. Эдгээр нь нээлттэй хүрээнд Монголын Хөрөнгийн Биржээр дамжиж нийтэд санал болгосон, хугацааны дундуур борлуулах, дараагийн хөрөнгө оруулагчдад шилжүүлэх боломжтой хөрвөх чадвар бүхий бүтээгдэхүүнүүд юм.

Компанийн гүйцэтгэх удирдлагын баг нь бүтэцжүүлсэн санхүүжилтийн чиглэлээр 10-аас дээш жил ажилласан туршлагатай. Компанийн засаглалын олон улсын ISO 37000:2021 стандартыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүний хүрээнд санхүүгийн зах зээлд оролцогчдод компанийн засаглалын зөвлөх үйлчилгээг хүргэн ажилладаг. Компани нь компанийн засаглал, санхүүгийн удирдлагаар мэргэшсэн 100 хувь хараат бус төлөөлөн удирдах зөвлөлтэй.

### 7.2 Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний тухай

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь хөрөнгө оруулагчийн эрх ашигт нийцүүлэн хөрөнгийг эзэмших, удирдах үндсэн үүргийн хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Хөрөнгийн багцыг удирдах хяналт тавих;
- Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс ТЗК-д хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний дагуу шилжүүлсэн хөрөнгийн жагсаалтын дагуу компанийн нэрийн өмнөөс өөрийн программ хангамжаар хүлээн авч, багцын бүртгэлийг баталгаажуулах;
- ТЗК-ийн хөрөнгийн багц дахь зээлийн данс бүртгэлийг өөрийн компанийн данс бүртгэл, санхүүгийн тайлан тооцооноос тусад нь бүртгэх;
- Зээлийн данс бүртгэлийг хянаж, алдаа, зөрчил илэрсэн бол түүнийг залруулах арга хэмжээг тухай бүр авах шаардлагыг Үйлчилгээ үзүүлэгчид хүргүүлэх;
- Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний дагуу шилжүүлэн авах хөрөнгө нь ТЗК-ийн ТУЗ-өөс баталсан хуулийн болон санхүүгийн шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхэд хяналт тавих;
- ТЗК-ийн төлбөр цуглуулах дансанд цугларсан төлбөрөөр үнэт цаасны төлбөр болон ТЗК-ийн бусад төлбөрийн үүргийг гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд нэн даруй ТЗК-д мэдэгдэх;
- Хөрөнгийн ашиглалт, нөөц хөрөнгийн талаар зөрчил гарвал нэн даруй ТЗК-ийн ТУЗ-д мэдэгдэх.

### 7.3 Хөрөнгө итгэмжлэн удирдагчийг солих

Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд заасан зөрчил гаргасан эсхүл гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй, үүргээ биелүүлэх шаардлага хүргүүлсэн боловч гаргасан зөрчлөө арилгаагүй, үүргээ гүйцэтгэхгүй болох нь тогтоогдсон эсхүл гүйцэтгэх чадваргүй болсон, дампуурах байдалд хүрсэн зэргээр хөрөнгө итгэмжлэн удирдагчийг солих шаардлага үүссэн тохиолдолд ТУЗ-ийн шийдвэрээр гэрээг цуцлах тухай санал гаргана.

Үнэт цаас гаргагч нь Хөрөнгө итгэмжлэн удирдагчийг солих тохиолдолд Хөрөнгө итгэмжлэн удирдагчид ажлын 30 өдрийн өмнө мэдэгдэл хүргүүлнэ. Мэдэгдэл хүргүүлсэн өдрөөс хойш ажлын 30 өдөрт багтаан Хөрөнгө итгэмжлэн удирдагчид хадгалагдаж байсан Үнэт цаасны болон Хөрөнгийн багцтай холбоотой баримт бичгийг үнэт цаас гаргагчийн шинээр томилогдсон этгээдэд хүлээлгэн өгөх эрхтэй.

Үнэт цаас гаргагч нь шинэ хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгон, томилж амжаагүй тохиолдолд буюу шинээр хөрөнгө итгэмжлэн удирдагчтай гэрээ байгуулах хүртэл ТЗК-ийн ТУЗ өөрөө шийдвэрлээгүй бол Хөрөнгө итгэмжлэн

удирдагч нь хууль тогтоомж болон энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ хэвийн, урьдын адил гүйцэтгэх үүрэгтэй.

# ХБҮЦ-НЫ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

# 8 ХБҮЦ-НЫ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

## 8.1 Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааг зохицуулах хууль эрх зүйн орчин

Монгол Улсын Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэгт "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг гаргах, арилжихтай холбогдсон нийтлэг харилцааг энэ хуулиар, нарийвчилсан харилцааг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль тогтоомжийн дагуу зохицуулна" гэж заасны дагуу хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, түүнд хяналт тавих, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийг 2010 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр баталж, тус хууль нь 2011 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон байдаг.

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай, Компанийн тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэж байна.

Үнэт цаас гаргагч нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахтай холбоотой үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахаас гадна дараах хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулна. Үүнд:

- Иргэний хууль;
- Компанийн тухай хууль;
- Татварын ерөнхий хууль;
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль;
- Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль;
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль;
- Үнэт цаасны зах зээлийн тухай хууль;
- Компанийн засаглалын кодекс;
- СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам;
- МХБ-ын Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам.

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасны дагуу Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргагч нь тусгай зориулалтын компани байх ба тус хуульд тусгай зориулалтын компанийн үүсгэн байгуулагчид тавигдах шаардлага, дүрэмд тусгагдах асуудал, хориглох болон зөвшөөрөх үйл ажиллагаа, тэдгээрийг хэрэгжүүлэх субъектийн талаар тусгайлан зохицуулсан байна. Тухайлбал, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасны дагуу тусгай зориулалтын компанид хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр ажилтан авч ажиллуулахыг хориглодог бөгөөд хувьцаа эзэмшигчид нь Хорооны зөвшөөрөлгүйгээр үнэт цаас

гаргагчийн хувьцааг бусдад худалдах, шилжүүлэхгүй байх, Хорооны зөвшөөрөлгүйгээр компанийн дүрэмд өөрчлөлт оруулахгүй байх зэрэг зохицуулалтуудыг тусгасан байдаг. Түүнчлэн тус хуулиар хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагч болон оролцогч этгээдүүдэд тавигдах шаардлага, баталгаат болон барьцаат үнэт цаас гаргах оролцогчдын хоорондын эрх зүйн харилцаа, эрх үүрэг, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах асуудлуудыг тусгайлан зохицуулсан байдаг.

Мөн Хорооны "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам"-ын 3 дугаар зүйлд үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаатай холбоотойгоор түүний үүсгэн байгуулагчид тавигдах шаардлага, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд тавигдах шаардлага, төлөөлөн удирдах зөвлөлийн эрх хэмжээ, зарчим, үйл ажиллагааны тайлан мэдээ хүргүүлэх болон хөндлөнгийн аудит хийлгэх тухай нарийвчлан зохицуулсан байдаг.

## 8.2Үнэт цаас гаргах үйл ажиллагааг зохицуулах хууль эрх зүйн орчин

Монгол Улсын хэмжээнд үнэт цаасны зах зээлийн үйл ажиллагаа , зах зээлд оролцогчдод хяналт тавих, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалахтай холбоотой бүхий л харилцаа Үнэт цаасны зах зээлийн тухай хуулиар зохицуулагддаг.

Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон эдгээр хуультай нийцэн гаргасан бусад хууль тогтоомжоос бүрддэг болно. Үнэт цаас гаргах үйл ажиллагаа нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулиар зохицуулагдахаас гадна бусад зохицуулагч байгууллагууд буюу Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Бирж болон Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төвийн холбогдох дүрэм, журмаар зохицуулагддаг. Үүнд:

**Хүснэгт 24. Хууль, дүрэм журмууд**

| Зохицуулагч байгууллага | Хууль дүрэм, журам |
|---|---|
| **Санхүүгийн Зохицуулах Хороо** | • Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам<br>• Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгийн багцыг тусгай тэмдэглэл хийж бүртгэх тухай журам<br>• Үнэт цаасны бүртгэлийн журам<br>• Үнэт цаасанд нэгдсэн дугаар олгох |

| | |
|---|---|
| | журам |
| **Монголын Хөрөнгийн Бирж** | • Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам<br>• Үнэт цаасны бүртгэлийн журам<br>• Арилжааны журам<br>• Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам |
| **Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв** | • Үнэт цаасны хадгаламжийн журам<br>• Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг бүртгэх үйл ажиллагааны журам<br>• Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг хадгалах, биржийн бус арилжаагаар өмчлөх эрх бүртгэх журам |

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулиар үнэт цаасыг гаргах үйл ажиллагаатай холбоотойгоор хөрөнгийн багцад тавигдах шаардлага, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаанд зөвшөөрөл олгох, зохицуулах төрийн эрх бүхий байгууллага болон үнэт цаасны арилжаа эрхлэх үйл ажиллагаа явуулагч байгууллагын эрх хэмжээ, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэхтэй холбоотой үйл ажиллагааг тусгайлан зохицуулсан байдаг.

Хорооны "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам"-д үнэт цаас гаргах үйл ажиллагаатай холбоотойгоор хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэх, түүнд хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулдаг бөгөөд Хорооны "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 1.5 дахь хэсэгт "Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, хадгаламжийн бичиг гаргах болон бусад үүсмэл санхүүгийн хэрэгслийг бүртгэх харилцаа нь тус тусын үйл ажиллагааг тусгайлан зохицуулсан Хорооны журмаар зохицуулагдана" гэж заасны дагуу ийнхүү тусгайлсан журмаар зохицуулагдаж байна.

Биржийн "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам"-д үнэт цаас гаргах үйл ажиллагаатай холбоотойгоор хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг тус биржийн бүртгэлд бүртгэх, бүртгэлийн шалгуур, шаардлагыг тогтоох, бүртгэлтэй байх хугацаанд үнэт цаас гаргагчийн хүлээх үүрэг, түүнд хяналт тавих, бүртгэлээс хасахтай холбогдсон харилцааг зохицуулдаг бөгөөд Биржийн "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 1.4 дэх хэсэгт "Биржийн бусад

дүрэм журамд өөрөөр заагаагүй бол хувьцаа, өрийн хэрэгслээс бусад үнэт цаас, санхүүгийн хэрэгслийг бүртгэхтэй холбоотой харилцааг тусгайлсан журмаар зохицуулна" хэмээн заасны ийнхүү тусгайлсан журмаар зохицуулагдаж байна.

## 8.3 Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон хөрөнгийн багцтай холбоотой хууль эрх зүйн орчин

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болох банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа нь Хорооны журам болон бусад холбогдох хууль, дүрэм журмуудаар зохицуулагддаг.

Банк бус санхүүгийн үйл ажиллагааг зохицуулахтай холбогдох дараах хууль, дүрэм журмууд хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Үүнд:

- Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль;
- Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам;
- Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам;
- Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж зарцуулах журам;
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам;
- Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам;
- Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан хяналт шалгалт хийх журам;
- Үл хөдлөх хөрөнгө барьцаалуулагчид мэдээлэл өгөх журам;
- Банк бус санхүүгийн гадаад валютын арилжааны үйл ажиллагааг зохицуулах, түүнд хяналт тавих журам;
- Банк бус санхүүгийн байгууллагаас гаргах хаалттай өрийн бичгийг бүртгэх, түүнд хяналт тавих журам;
- Гүйлгээнээс илэрсэн хуурамч мөнгөн тэмдэгтийг хүргүүлэх, бүртгэх, хадгалах, устгах журам;
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам;

## 8.4 ТЗК-ийн ХБҮЦ-тай холбоотой үйл ажиллагааны зохицуулалт:

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахтай холбоотой үйл ажиллагаанд мөрдөх дараах журмуудыг Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь 2022 оны 8 дугаар сарын 17-ны өдөр 07 тоот тогтоолоор баталсан.

***Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам***

Тус журамд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх,

холбогдох хууль тогтоомж, зохицуулалтын байгууллагаас баталсан дүрэм, журам, стандартуудыг дагаж мөрдөх, үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх харилцааг зохицуулсан.

***Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журам***

Тус журамд хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчид Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны талаар болон хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг тогтмол хүргэх, уг мэдээллийн төрөл, хэлбэр, давтамж, мэдээллийн ил тод байдлыг хангах, нийтэд хүргэх, нэгдсэн нэг мэдээллийн урсгалтай байх, түүнийг хэрэгжүүлэх, хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулсан.

***Хөндлөнгийн аудитор, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих журам***

Тус журамд холбогдох этгээдүүдэд тавигдах шаардлага, шалгуур, гэрээ байгуулах, тэдгээрийг солих болон гэрээ цуцлахтай холбоотой харилцааг зохицуулсан.

***Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам***

Тус журамд хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргахтай холбоотойгоор үүсгэн байгуулагдсан төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг зохицуулсан.

***Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам***

Тус журамд ТЗК-аас гаргах хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны хөрөнгийн багц дахь зээлүүдийн төлбөрийг цуглуулах, үнэт цаас эзэмшигчдэд үнэт цаасны төлбөр төлөхтэй холбоотойгоор ТЗК, Үйлчилгээ үзүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагч болон бусад холбогдох этгээдийн хооронд үүсэх харилцааг зохицуулсан.

***Хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах журам***

Тус журамд компанийн гаргаж буй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны баталгаа болох зээлийн хөрөнгийн багцад буй хөрөнгийг солих, нэмэх, хасах замаар багцад өөрчлөлт оруулахтай холбоотойгоор Үнэт цаас гаргагчийн Анхны үүрэг гүйцэтгүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагч болон бусад оролцогчтой холбоотой харилцааг зохицуулсан.

***Эрсдэл удирдлага, дотоод хяналтын журам***

Тус журамд ТЗК-ийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, үнэт цаасны төлбөрийг хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчдэд төлөхтэй холбоотой үйл ажиллагааны эрсдэлийг удирдах, түүнтэй холбогдсон дотоод хяналтыг хэрэгжүүлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авахтай

холбоотой холбогдох хууль, журмын хүрээнд зохицуулагч байгууллагууд болон оролцогч талуудтай харилцах харилцааг зохицуулсан

# ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААГ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАХ ТУХАЙ

# 9 ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААГ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАХ

## 9.1 Үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах

Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа нь МХБ-ийн ТУЗ-ийн 2018 оны 1-р сарын 25-ны өдрийн 2018/01 дугаар тогтоолоор баталсан Үнэт цаасны бүртгэлийн журам, СЗХ-ны 2021 оны 6-р сарын 11-ны өдрийн 225 дугаар тогтоолоор батлагдсан Үнэт цаасны бүртгэлийн журам болон МХБ-ийн ТУЗ-ийн 2018 оны 10-р сарын 26-ны өдрийн 15 тоот тогтоолоор баталсан Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журмын дагуу явагдана.

Үнэт цаас гаргагчийн 2022 оны 8 сарын 17-ны өдрийн ТУЗ-ийн 08 тоот тогтоолын дагуу 100,000 ширхэг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг нийтэд санал болгохоор шийдвэрлэсэн.

Үнэт цаас гаргагчийн олон нийтэд санал болгож буй Нөмөр Кредит Ассет Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг олон нийтэд танилцуулах үйл ажиллагааг МХБ болон СЗХ үнэт цаасыг бүртгэсэн өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор, анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг ажлын 5 хоногийн дотор хүлээн авна.

**Схем 6. Анхдагч зах зээлийн арилжааны төлөвлөгөө**




### Үнэт цаасыг бүртгүүлж, холбогдох зөвшөөрөл авах

Үнэт цаас гаргагч нь нийтэд санал болгох үнэт цаасыг бүртгэлд бүртгүүлэх хүсэлтийг СЗХ болон МХБ-д гаргах бөгөөд эдгээр эрх бүхий байгууллагуудаас үнэт цаасыг бүртгэхийг зөвшөөрснөөр үнэт цаасыг нийтэд санал болгон арилжаалах боломжтой болно.

### Олон нийтэд танилцуулах

Үнэт цаасыг анхдагч зах зээлд санал болгох тухай мэдэгдлийг СЗХ-нд хүргүүлснээс хойш 3-аас доошгүй өдрийн дараа үнэт цаасыг нийтэд санал болгон танилцуулах аяныг зохион байгуулна. Үүнд хөрөнгийн зах зээлийн мэргэжлийн оролцогч, олон нийт болон стратегийн хөрөнгө оруулагчдад

зориулсан танилцуулга уулзалт болон олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр үнэт цаасыг танилцуулах мэдээ мэдээлэл зэрэг нь багтана.

**Анхдагч зах зээлийн арилжааны захиалга хүлээн авах**

Үнэт цаас гаргагч нь анхдагч зах зээлийн захиалга авч эхлэхээс ажлын 3-с доошгүй хоногийн өмнө анхдагч зах зээлийн арилжааг эхлүүлэх мэдэгдлийг СЗХ-нд хүргүүлснээр анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг хүлээн авах болно. Анхдагч зах зээлийн захиалгыг Биржийн гишүүн бүх үнэт цаасны компаниар дамжуулан авна.

## 9.2 Үнэт цаасны арилжаанд оролцох, захиалга авах заавар

**Схем 7. Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаанд оролцох заавар**




Үнэт цаас худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нь анхдагч зах зээлийн арилжаанд дараах зааврын дагуу оролцоно.

**Мөнгөн хөрөнгө байршуулах заавар**

Үнэт цаас худалдан авах хүсэлтэй хөрөнгө оруулагч нь өөрийн хүссэн Үнэт цаасны компанийн номинал дансанд мөнгө байршуулна.

| | |
|---|---|
| Дансны нэр: | ҮЦК-ийн нэр |
| Дансны дугаар: | ҮЦК-ийн номинал дансны дугаар /Брокероос авах/ |
| Банкны нэр: | Брокероос авах |
| Гүйлгээний утга: | Нэр, Регистр, Нөмөр Кредит Ассет ХБҮЦ |

**Арилжааны шимтгэл**

Үнэт цаасанд хөрөнгө оруулагч нь гүйлгээний үнийн дүнгийн тодорхой хувиар тооцсон үйлчилгээний хөлс буюу шимтгэлийг өөрийн сонгосон үнэт цаасны компанид төлөх ба уг шимтгэлд зохицуулагч байгууллагуудын болон үнэт цаасны компаниудын шимтгэлийн нийт дүн багтсан байна. Үнэт цаасны компаниудын шимтгэл нь харилцан адилгүй болохыг анхаарна уу.

СЗХ
numur
БҮРТГЭВ

### 9.3 Албан татвар

Үнэт цаасанд хөрөнгө оруулагч Монгол Улсад байрладаг хувь хүн нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 16.1.4-т заасан орлого (хүүгийн орлого)-ын нийт дүнгээс тус хуулийн 21.5-т заасан 5 хувийн хэмжээгээр татвар төлнө.

Үнэт цаасанд хөрөнгө оруулагч Монгол Улсад байрладаг хуулийн этгээд буюу аж ахуйн нэгж нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 18.6.3-т заасан (хүүгийн орлого) нийт дүнгээс тус хуулийн 20.2.5-т заасан 5 хувийн хэмжээгээр татвар төлнө.

Гадаад улсын иргэн, хуулийн этгээд нь холбогдох хууль тогтоомжид заасны дагуу татвар төлөх үүрэг хүлээх бөгөөд тухайн харьяаллын улстай давхар татварын гэрээ байгуулсан эсэх болон гэрээний нөхцөлийг судлан үзсэний үндсэн дээр хөрөнгө оруулахыг зөвлөж байна.

### 9.4 Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа

Үнэт цаасыг анх удаа нийтэд санал болгох ажиллагаа амжилттай болсон тохиолдолд МХБ-ийн журмын дагуу СЗХ-ны зөвшөөрлөөр үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлнэ. Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээр хувьцааг анхдагч зах зээлээс худалдан авсан хөрөнгө оруулагчид хувьцаагаа бусдад худалдаалах эрх нээлттэй болно.

### 9.5 Үнэт цаасны арилжаа, хүүгийн төлбөр, эргэн төлөлтийн график

Үнэт цаасны эргэн төлөлтийн эх үүсвэр нь ТЗК-д шилжсэн 10.0 тэрбум төгрөгийн дүн бүхий автомашины зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийн эргэн төлөлтөөс бүрдэнэ.

**Хүснэгт 25. ХБҮЦ эзэмшигчдэд төлөх төлбөрийн хуваарь**

| | У1 | У2 | У3 | У4 | У5 | У6 | У7 | У8 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| ХБҮЦ | 100,000 | 100,000 | 100,000 | 100,000 | 50,000 | 50,000 | 50,000 | 50,000 |
| Төлөгдөх үндсэн дүн | - | - | - | 50,000 | - | - | | 50,000 |
| **ХБҮЦ үлдэгдэл** | **100,000** | **100,000** | **100,000** | **50,000** | **50,000** | **50,000** | **50,000** | **-** |
| Хүү | 4,363 | 4,315 | 4,411 | 4,411 | 2,182 | 2,182 | 2,205 | 2,205 |
| Татварын дараах хүү | 4,145 | 4,099 | 4,190 | 4,190 | 2,072 | 2,072 | 2,095 | 2,095 |
| **Төлөгдөх нийт дүн** | **4,145** | **4,099** | **4,190** | **54,190** | **2,072** | **2,072** | **2,095** | **52,095** |

*Эх сурвалж: Андеррайтерийн тооцоолол*



УЛААНБААТАР ХОТ
АССЕТ ТЗК
ХХК
9022080593
6862705 СБТ19638

### 9.6 Үнэт цаас эзэмшигчийн эрх, үүрэг

Үнэт цаас эзэмшигч нь дараах эрхтэй байна:

- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг МХБ-ийн арилжааны журмын дагуу худалдан авснаар үнэт цаасыг эзэмшилдээ шилжүүлэн авах, түүнийг шаардах эрхтэй
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хүү болон үндсэн төлбөрийг хуваарийн дагуу хүлээн авах, төлбөрийг хуваарийн дагуу төлөхийг үнэт цаас гаргагчаас шаардах
- Үнэт цаас эзэмших эрхээ чөлөөтэй арилжаалах, захиран зарцуулах
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас эзэмшиж буй хугацаанд Үнэт цаас гаргагчийн санхүүгийн болон үйл ажиллагааны мэдээллийг хүлээн авах
- Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны танилцуулгад тусгасан үүргээ зохих ёсоор биелүүлээгүй бол биелүүлэхийг шаардах

### 9.7 Үнэт цаас гаргагчийн эрх, үүрэг

Үнэт цаас гаргагч нь дараах эрх үүрэгтэй байна.

- Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан хүү болон үндсэн төлөлтийн график, схемийн дагуу төлбөрийг хуваарийн дагуу төлөлт хийж барагдуулах
- Үнэт цаас гаргагч нь зохицуулах байгууллагуудын тогтоосон хүүгийн орлогын татварыг зохих хуулийн дагуу суутган үнэт цаас худалдан авагчид шилжүүлж, татварын төлбөрийг төсөвт төлөх
- Үнэт цаасны танилцуулга болон хууль, журмыг зөрчиж Үнэт цаас эзэмшигчид учруулсан аливаа хохирлыг Үнэт цаас гаргагч нь үл маргах журмаар нөхөн барагдуулах
- Үнэт цаас гаргагч нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой аливаа үйл явцын мэдээллийг ТЗК-н баталсан хууль журмын дагуу Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэх
- Бусад хууль тогтоомж, гэрээнд тусгагдсан эрх үүргийг хүлээнэ

# ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДАД ТАЙЛАГНАХ ТУХАЙ

СЗХ
numur
... өдөр
БҮРТГЭВ



2022 -09- 29
БҮРТГЭВ-03

# 10 ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДАД ТАЙЛАГНАХ

## 10.1 Хөрөнгө оруулагчдад танилцуулах мэдээллүүд, тэдгээрийн тайлангийн хугацаа

Үнэт цаас гаргагч нь хөрөнгө оруулагч болон бусад оролцогч талуудад мэдээлэл хүргэхдээ Үнэт цаас гаргагчийн Үнэт цаас эзэмшигч дэд мэдээлэл хүргүүлэх журмыг баримтлах бөгөөд тус журам нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Санхүүгийн Зохицуулах Хороо болон МХБ-ээс гаргасан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журамд нийцсэн байна.

**Хүснэгт 26. Үнэт цаас эзэмшигчдэд тайлан мэдээлэл түгээх нь**

| Давтамж | Тайлагнах хугацаа | Тайлагнах мэдээлэл |
|---|---|---|
| Улирал тутам | Улирал бүрийн эхний сарын 20-ны өдрийн дотор хүргүүлнэ. Ингэхдээ СЗХ болон МХБ-д цахимаар, болон олон нийтэд биржийн цахим хуудсаар дамжуулан хүргэх бөгөөд компанийн цахим хуудсанд мөн тайлагнана. | Багцын хөрөнгө, мөнгөн урсгалын хөдөлгөөн, үнэт цаасны төлбөр, тооцоотой холбоотой Хороо болон хөрөнгө оруулагчдад хүргүүлсэн улирал тутмын тайлан, мэдээллэл зэрэг хамаарна. |
| Хагас жил тутам | СЗХ болон МХБ-д 7 сарын 20-ны дотор тайлагнана. Ингэхдээ МХБ, СЗХ-д бичгээр болон олон нийтэд биржийн хуудсан дээр мөн компанийн цахим хуудсанд тайлагнана. | Хөрөнгийн багцын мэдээлэл, хагас жилийн санхүүгийн тайлан, төлбөр зарлага, хөрөнгө оруулалтын орлогын зарцуулалтын тайлан, хөрөнгө оруулагчид төлөх үнэт цаасны эргэн төлөлтөөс бусад хөрөнгө зэрэг орно |
| Жил тутам | СЗХ болон МХБ-д 2 дугаар сарын 10-ны өдрийн дотор бичгээр болон цахимаар, олон нийтэд биржийн цахим хуудсаар дамжуулан хүргэх бөгөөд компанийн цахим хуудсанд түгээх үүрэгтэй. | Жилийн үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлан ҮЦТ-д заасан хөрөнгийн удирлагын стандарт шалгуур, томоохон үүрэг гүйцэтгэгч, зээлийн баталгаа гаргагч сүүлийн тайлангаас гарсан баталгаат үнэт цаас болон үүсгэн байгуулагчид мэдэгдсэн мэдэгдэл, санхүүгийн баримтын талаарх мэдээлэл. ТЗК-ийн ТУЗ-ийн үйл ажиллагааны тайлан, гарсан шийдвэрүүд, тэдгээрийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл |
| Тухай бүр тайлагнах | Холбогдох шийдвэр, өөрчлөлт гарсан, тухай үйл явдал болсноос хойш 3 хоногийн дотор СЗХ болон МХБ-д бичгээр олон нийтэд биржийн хуудсан дээр мөн компанийн цахим | • Төлбөр, зарлага, хөрөнгө оруулагчдад төлөх үнэт цаасны эргэн төлөлтөөс бусад хөрөнгө, хөрөнгө оруулалтаас олсон орлогын зарцуулалт; |

Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Delivering ...
1119289111 ... 5481599
Улаанбаатар хот



УЛААНБААТАР ХОТ
НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЗК ХХК
9022080593
6862705 СБТ19638

| | | |
|---|---|---|
| | хуудсанд тайлагнана.Хорооны журмын 3.22-т заасан мэдээлэлд өөрчлөлт орсон бол Хороо болон хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчид, Биржийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 9.7.2-д заасан мэдээлэлд өөрчлөлт орсон бол Биржид тус тус өөрчлөгдсөн тухай бүр ажлын 3 хоногт багтаан мэдэгдэнэ. | • Хөрөнгийн багцын нарийвчилсан мэдээлэл, тэдгээрийн байдал;<br><br>• Хөрөнгийн багцад нэмэгдсэн, хасагдсан хөрөнгө, нэмэх хасах болсон үндэслэл, шалтгаан, үнэт цаасны жигнэсэн дундаж хүү, эргэн төлөгдөх нөхцөл, үлдэгдэл хөрөнгийн тоо хэмжээ<br><br>• Төлөгдөөгүй хөрөнгийн үлдэгдэл болон үндсэн зээлийн харьцаа, төлөгдсөн үндсэн зээл, баталгаат үнэт цаасны үлдэгдэл, бэлэн мөнгөний төвлөрсөн хэмжээ, түүний ашиглалт;<br><br>• Санхүүгийн үзүүлэлт, тоо баримтууд, улирлын санхүүгийн тайлан;<br><br>• Хууль тогтоомж , энэхүү журам, ТЗК-ийн дүрэм, гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу мэдээлэх бусад мэдээлэл.<br><br>• Хөрөнгийн багц, барьцааны зүйлийн нийт үнийн дүнгийн 10 хувиас дээш өөрчлөлт орсон тохиолдолд<br><br>• ХБҮЦ-н бүтээгдэхүүний нөхцөл, төлбөрийн хуваарь өөрчлөгдөх, хугацааны өмнө эргүүлж дуудах, нэмэлт үнэт цаас гаргах зэрэг үед<br><br>• Үнэт цаасны хүүгийн болон үндсэн өр төлбөрийн мэдээлэл, төлбөрийн гүйцэтгэл эрсдэлд орсон тохиолдолд, хүүгийн төлбөрийг хугацанд төлөөгүй тохиолдолд түүний шалтгаан авах арга хэмжээний талаар<br><br>• Бүртгэл бүхий ХБҮЦ-н 10 хувиас дээш үнийн дүн бүхий буцаан дуудсан, эргүүлэн авсан үнэт цаасны мэдээлэл цаашид 5 хувиар өөрчлөгдөх тутам |



УЛААНБААТАР ХОТ
НОМОР КРЕДИТ ХХК
9022080593

| | | |
|---|---|---|
| | | ● Компанийн үйл ажиллагаа бүтэц зохион байгуулалт, дүрэм, журам, хяналтын багц эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан, холбоо барих хаяг, байршил утас, зэрэгт өөрчлөлт орох<br><br>● Ээлжит болон ээлжит бус хуралдаан зохион байгуулах болсон тохиолдолд хурлын зар, хуралдуулах шийдвэр, хурлын мэдэгдэл, хурлын шийдвэр;<br><br>● ХБҮЦ-н харилцаанд оролцогч этгээдүүд солигдох, бүтцийн өөрчлөлт гарах, түүнтэй байгуулсан гэрээнд өөрчлөлт орох<br><br>● Төлбөр төлөх чадваргүй болох, эсхүл бусад байдлраар шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа эхэлсэнтэй холбоотой мэдээлэл<br><br>● Эрх бүхий байгууллагаас компанид авсан арга хэмжээ<br><br>● Үнэт цаас эзэмшигчид, хөрөнгө оруулагчдын шийдвэр, ХБҮЦ гаргагчийн үйл ажиллагаа, үнэт цаасны үнэ ханшинд нөлөөлөх зах зээлийг урвуулан ашиглах, дотоод мэдээлэлд хамаарах бусад мэдээллүүд |

## 10.2 Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журмын тухай

“Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журам”-д заасны дагуу Үнэт цаас гаргагч нь мэдээлэл хүргэхдээ Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны “Үнэт цаас гарагчийн мэдээллийн ил тод байдлын журам”, Монголын хөрөнгийн биржийн “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам” болон энэхүү журамд заасны дагуу мэдээллийг цаг тухайд нь үнэн зөв, агуулгын хувьд хоёрдмол утгагүй, бүрэн гүйцэт мэдээлэх үүрэгтэй гэж заасан. Түүнчлэн Үнэт цаас гаргагч нь энэхүү Журамд заасан мэдээллийг Монгол хэл дээр хүргэх ба мэдээллийг олон нийт болон хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчид өөрийн болон Биржийн цахим хуудсаар хүргэнэ. Шаардлагатай гэж үзвэл гадаад хэл дээр мэдээллийг давхар хүргэж болно. “Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журам”-ыг хавсралтаас дэлгэрэнгүй үзнэ үү.



УЛААНБААТАР ХОТ
НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЗК ХХК
9022080593
6862705 СБТ19638

СЗХ

# ҮНЭТ ЦААС ГАРГАХАД ХӨНДЛӨНГИЙН ДҮГНЭЛТ ӨГСӨН БАЙГУУЛЛАГУУД

# 11 ҮНЭТ ЦААС ГАРГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХӨНДЛӨНГИЙН ДҮГНЭЛТ ӨГСӨН КОМПАНИУД

## 11.1 Андеррайтер

Голомт Капитал ҮЦК

| | |
|---|---|
| Улсын бүртгэлийн дугаар | 9011287134 |
| Регистрийн дугаар | 5481589 |
| Үйл ажиллагааны чиглэл | Брокер, Дилер, Андеррайтер, Хөрөнгө оруулалтын зөвлөх, Номинал дансаар дамжуулан харилцагчдад мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын гүйлгээний үйлчилгээ, Харилцагчийн нэрийн өмнөөс түүний даалгавраар гүйцэтгэх хөрөнгө оруулалтын бусад үйл ажиллагаа |
| Хаяг | Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө 24, Парк плэйс оффис, 403 тоот; |
| Утас | 7012-1530 |
| Веб хуудас | www.golomtcapital.com |
| Цахим хаяг | info@golomtcapital.com |

Голомт Капитал ҮЦК нь 2011 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд Санхүүгийн Зохицуулах Хорооноос брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөх, гадаад арилжааны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл авч, санхүүгийн зуучлалын цогц үйлчилгээ үзүүлдэг компани юм.

Голомт Капитал ҮЦК ХХК нь 2015 онд Монголын анхны даатгагдсан бонд болох Эрчим бонд, 2017 онд анхны нээлттэй бонд болох Сүү бонд, 2020 онд анхны хайбрид бонд болох Мастер бонд, анхны 100 хувийн банкны баталгаат Нөмөр бонд, 2021 онд анхны ББЗЗ-ийн бонд болох Монкон бондын андеррайтераар тус тус ажилласан туршлагатай. Түүнчлэн нь 2018 онд Торонтогийн Хөрөнгийн Биржид бүртгэлтэй Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн ХК-ийн давхар бүртгэлийн туслах андеррайтер, даатгалын зах зээлд тэргүүлэгч Мандал Даатгал ХК-ийн IPO үндсэн андеррайтер, 2019 онд шувууны аж ахуйн салбарт тэргүүлэгч Түмэн Шувуут ХК-ийн IPO үндсэн андеррайтер, эрүүл мэндийн шингэн хүнсний үйлдвэрлэлийн зах зээлд тэргүүлэгч Монос Хүнс ХК-ийн IPO үндсэн андеррайтер, хамгийн олон хөрөнгө оруулагч оролцсон Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн IPO үндсэн андеррайтераар тус тус ажилласан IPO андеррайтерийн зах зээлд тэргүүлэгч компани юм.

**Андеррайтертай байгуулсан гэрээ**

Голомт Капитал ҮЦК нь 2022 оны 8 сарын 18-ны өдөр 22/59 тоот Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээг Үнэт цаас гаргагчтай байгуулсан. Тус андеррайтерийн гэрээний хүрээнд Андеррайтер нь Үнэт Цаас Гаргагчид МХБ-с 10 тэрбум төгрөг хүртэлх хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг олон нийтэд санал болгох, худалдах ажлыг удирдан зохион байгуулах, хөрөнгийн зах зээлээс санхүүжилт татан төвлөрүүлэхэд шаардлагатай магадлан шинжилгээ, тооцоолол, судалгаа, бэлтгэл ажлуудыг гүйцэтгэх, боломжит хөрөнгө оруулагчдад Үнэт цаасыг танилцуулах, санал болгох, арилжих үйлчилгээг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн үзүүлэх зорилготой.ТЗК нь үнэт цаас гаргах, түүний танилцуулга бэлтгэх, олон нийтэд хувьцааг санал болгох, худалдах, эзэмшүүлэх, хөрөнгө татан төвлөрүүлэх, хөрөнгө оруулагч татах үйл ажиллагааг мэргэжлийн өндөр түвшинд хэрэгжүүлэхийг Андеррайтераас шаардах эрхтэй. Мөн түүнчлэн үйл ажиллагааны явцын талаар бүрэн мэдээлэл авж, үр дүнд өөрийн зүгээс санал өгөх, Андеррайтераас санал болгосон хөрөнгө оруулагчтай гэрээ байгуулах, мөн тухайн хөрөнгө оруулалтыг хүлээн авахаас татгалзах боломжтой. Үнэт цаас гаргагч нь ТЗК-г Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Компанийн тухай хуульд нийцүүлэн байгуулах, Андеррайтерт ажил үүргээ гүйцэтгэхэд шаардагдах аливаа мэдээллээр хангах үүргийг хүлээнэ. Талууд эрх бүхий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд байгууллагын нууцад хамаарах мэдээллийг гэрээний хүрээнд задруулахгүй байх үүрэг хүлээнэ.

## 11.2 Зээлийн шинжилгээ гаргагч

MOORE **Мүүрь Аудит ХХК**

| | |
|---|---|
| Улсын бүртгэлийн дугаар | 9018001014 |
| Регистрийн дугаар | 5189748 |
| Үйл ажиллагааны чиглэл | Аудитын үйл ажиллагаа эрхлэх, Санхүүгийн зөвлөгөө өгөх |
| Хаяг | Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, соёл амралтын хүрээлэн /14240/, 7/3-701 тоот |
| Утас | 7015-0003 |
| Веб хуудас | www.moore-mongolia.mn |
| Цахим хаяг | info@moore-mongolia.mn |

Мүүрь Аудит ХХК нь 2008 онд Од Бүртгэл Аудит ХХК нэртэйгээр байгуулагдсан. Фирм нь аудит, баталгаажуулалт, зөвлөх үйлчилгээ үзүүлдэг Монгол Улсын 7 дахь том фирм болж байна. Од Бүртгэл Аудит нь ХХК нь 2016 онд Мүүрь Стевенс олон улсын сүлжээнд корресфондент фирмээр эрсэн

орсон. Улмаар 2019 онд жинхэнэ гишүүн фирм болж нэрээ Мүүрь Аудит ХХК болгон өөрчилсөн. Монгол Улсын Сангийн сайдын олгосон 061-2008 тоот Аудитын үйлчилгээ, Татварын зөвлөх үйлчилгээ үзүүлэх тус гай зөвшөөрөлтэй. Санхүүгийн Зохицуулах Хороонд үнэт цаасны зах зээлийн оролцогчдод аудитын үйлчилгээ үзүүлэх эрх бүхий аудитын фирмээр бүртгүүлсэн. Мүүр Глобал нь дэлхийн 114 гаран алсад үйл ажиллагаа явуулдаг, 30,200 гаруй мэргэжилтэнтэй, 3.6 тэрбум ам.долларын хөрөнгө эргэлдэх томоохон сүлжээ. Компани нь Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институтээс 2014, 2019 онуудад оны онцлох аудитын компаниар шалгарч байсан бөгөөд 2018 онд аудитын салбарын энтерпренер болж байв.

**Зээлийн шинжилгээ гаргагчтай байгуулсан гэрээ**

“Мүүрь Аудит” ХХК болон Үнэт Цаас гаргагчийн хооронд 2022 оны 5 сарын 09-нд “ Тохиролцсон горимуудыг гүйцэтгэх ажлын гэрээ”-г байгуулсан. Энэхүү гэрээний хүрээнд олон улсын стандарт болох 4400 нийцүүлж мөн СЗХ-с гаргасан “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам”-г дагаж мөрдөн нийт арван тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зорилгоор үйлчлүүлэгчийн гаргаж өгсөн зээлийн багцад аудитын шалгалт хийж тохирох эсэхэд аудитын дүгнэлт гарган шаардлага хангахгүй багцыг сольж хангуулахаар тохиролцжээ. Аудитор нь зээлийн багцтай холбоотой бүртгэл мэдээллийг хүлээн авч, зээлийн шинжилгээг олон улсын стандартын дагуу мэргэжлийн өндөр түвшинд хийж гүйцэтгэн, ХБҮЦ гаргахад зээлийн багцын шаардлага хангаж буй эсэхэд тодорхойлолт өгч, тайлан дүгнэлт гаргах үүрэгтэй. Үнэт цаас гаргагч нь аудиторт зээлийн багцын бичиг баримтыг үнэн зөвөөр, дэлгэрэнгүй, гэрээнд заагдсан хугацаанд гарган өгч, процессийн явцад аудиторын шаардсан бичиг баримтыг түргэн шуурхай хангаж ажиллах, хөндлөнгийн хяналт шалгалтын явцад компанийн зүгээс дарамт нөлөө, шахалт үзүүлэхгүй байх үүрэгтэй. Аудитын гаргасан дүгнэлт, хууль тогтоомж дүрэм, журмын хэрэгжилтийн талаар тодруулга хийж гүйцэтгэлд тайлбар аван, зээлийн шинжилгээний үйл явц процессийн талаар мэдээлэл авах эрхтэй байна.

## 11.3 Хуулийн шинжилгээ гаргагч

KhanLexPartners “ХаанЛекс Партнерс” ХХН

| | |
|---|---|
| Улсын бүртгэлийн дугаар | 9022003026 |
| Регистрийн дугаар | 6351034 |
| Үйл ажиллагааны чиглэл | Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх |
| Хаяг | Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, олимпийн, 5 |



Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Delivering diversity
1119289111 5481589
Улаанбаатар хот

УЛААНБААТАР ХОТ
НОМОР КРЕДИТ АССЕТ ТЭК ХХК
9022080593
6862705 СБТ19638

аюуд тауэр, 14 давхар 1404 тоот
Утас 7747-1122
Веб хуудас www.khanlex.mn
Цахим хаяг info@khanlex.mn

Өмгөөллийн “ХаанЛекс Партнерс” ХХН (“ХаанЛекс”) нь банк санхүү, үнэт цаас, дэд бүтэц, эрчим хүч, шүүхийн маргаан, бизнесийн болон компанийн эрх зүйн салбарт голчлон хууль зүйн мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг Монголын тэргүүлэх хуулийн фирмүүдийн нэг юм. Өнгөрсөн арван жилийн хугацаанд өөрсдийн үйлчилгээ, мэдлэг туршлагаа олон улсын зах зээлийн томоохон оролцогч нарт хүргэж ирсэн ба эдгээрт олон улсын хөгжлийн банк, санхүүгийн байгууллагууд, гадаадын төрийн өмчит болон хувийн салбарын тэргүүлэгч компаниуд багтдаг

Хуулийн фирм нь Монгол Улсад хийгдсэн олон улсын шинжтэй томоохон гэрээ, хэлцлүүдэд эрх зүйн зөвлөгөө өгч, амжилттай ажилласан ба тэдгээрийн зарим нь олон улсын хэмжээнд танигдаж, хүлээн зөвшөөрөгдсөн байдаг. Түүнчлэн, хууль зүйн зөвлөгөө өгч ажилладаг үндсэн эрх зүйн салбарууд (банк санхүү, дэд бүтэц, бизнесийн эрх зүй, шүүхийн маргаан зэрэг)-аас гадна хурдтай хөгжиж буй “ногоон санхүүжилт”-ийн эрх зүйн чиглэлээр ажилласан байдал, туршлагаараа Монгол Улсын хуулийн фирмүүдийн дунд тэргүүлэх байр суурь эзэлдэг.

Хуулийн зөвлөхийн үйл ажиллагаа явуулж буй үндсэн чиглэлийн нэг нь үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн үйлчилгээ үзүүлэх бөгөөд түүний зарим туршлагаас дурдвал дараах байдалтай байна.

Тухайлбал “ЛэндМН ББСБ” ХК, “Даваанбулаг” ХК, “Түмэншувуут” ХК, “Мон-Бийф” ХХК зэрэг компаниудын МХБ-д хувьцаагаа бүртгүүлэн олон нийтэд санал болгох (IPO болон FPO) ажилд хууль зүйн зөвлөгөө амжилттай үзүүлсэн ба Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банкнаас “Эрдэнэ Рэсурс Девелопмент Корпораци” ХК-д хувьцаанд хөрвөх санхүүжилтийн ажилд оролцсон туршлагатай. Т үүнчлэн ХБҮЦ-н чиглэлээр 2022 онд “Омни Актив” ТЗК-н гаргасан 5 тэрбум төгрөгийн ХБҮЦ-н төсөлд амжилттай зөвлөгөө өгч, хуулийн дүгнэлт гарган оролцжээ.

**Хууль зүйн үйлчилгээний гэрээ**

Үнэт цаас гаргагч компани болон хуулийн фирм “ХаанЛекс Партнерс” ХХН-ий хооронд 2022 оны 05 сарын 09-ний өдөр “Хууль зүйн зөвөлгөө үзүүлэх гэрээ 563 тоот дугаартайгаар байгуулсан. Тус гэрээний хүрээнд хуулийн фирм нь Биржээр дамжуулан нийтэд Үнэт Цаас гаргагчийн төслийн үйл ажиллагаанд дараах үйлчилгээг гүйцэтгэж үзүүлнэ. Үүнд: 1) ХБҮЦ гаргахтай холбоотой хууль зүйн дүгнэлт боловсруулах, 2) Зээлийн багцад тавигдах хууль зүйн шаардлагыг ТЗК-тай хамтран тодорхойлох, улмаар Зээлийн багц хуулийн

шалгуур үзүүлэлтэд нийцсэн эсэх талаарх хуулийн хөндлөнгийн дүн шинжилгээ хийж, тайлан гаргах, 3) ХБҮЦ гаргахтай холбоотой байгуулах гэрээ, хэлцэл, шийдвэрийн төсөл хянахаар тохирлцсон.

Хууль зүйн үйлчилгээний гэрээний хүрээнд фирм нь компанийн бичиг баримтуудтай танилцах, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэмд нийцүүлэн хуулийн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх, тодруулга тайлбарын хүрээнд түргэн шуурхай үнэн бодит мэдээллээр хангах, үйлчилгээний хүрээнд олж авсан компанийн дотоод мэдээллийг задруулахгүй байх нууцлах үүрэгтэй. Үнэт Цаас гаргагч нь Хууль зүйн зөвлөгөө үзүүлэгч фирмд гэрээнд заагдсаны дагуу үйлчилгээний хөлсийг цаг хугацаанд багтаан бүрэн төлөх, үнэн зөв бодит мэдээллээр хангах, шаардлагатай бичиг баримтуудыг түргэн шуурхай гаргаж өгөх үүргийг хүлээнэ.

### 11.4 Хэлцлийн зөвлөх, Хэлцэл эрхлэн гүйцэтгэгч

"Нөмөр Кредит Ассет ТЗК" ХХК-ийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаанд Хэлцэл эрхлэн гүйцэтгэгчийн үүргийг Юнайтед Айр Файнэнс ХХК гүйцэтгэж байна.

Талууд 2022 оны 5 дугаар сарын 6-ны өдөр "Хэлцлийн зөвлөх үйлчилгээний гэрээ"-г байгуулсан бөгөөд тус гэрээгээр Хэлцлийн зөвлөх буюу Хэлцэл эрхлэн гүйцэтгэгч нь Хөрөнгийн багцад худалдах зээлийн хөрөнгийн шалгуурыг тодорхойлох, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах хэлцлийн санхүүгийн төсөөллийг боловсруулах, эрх зүйн баримт бичгүүдийг боловсруулах, үнэт цаасны танилцуулгад санал хүргэх зэрэг асуудлаар зөвлөх үйлчилгээг үзүүлэхээр тохиролцсон.

Тус гэрээ "Нөмөр Кредит Ассет ТЗК" ХХК нь Санхүүгийн зохицуулах хорооноос Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрлийг авснаар дуусгавар болно.

Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
1119229111 5481589
Улаанбаатар хот



УЛААНБААТАР ХОТ
НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЗК ХХК
9022080593
6862705 СБТ19638

# ХАВСРАЛТУУД

## 12.1 Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, түүний бэлтгэл ажлыг хангах тухай тогтоол

**"НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЗК" ХХК-ИЙН**
**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2022.08.17 №08 Улаанбаатар хот

**Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, түүний бэлтгэл ажлыг хангах тухай**

Компанийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 76 дугаар зүйлийн 76.1.5 дахь хэсэг, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.11.2 дахь хэсэг, Компанийн дүрмийн 2.2.2 болон 6.2.7 дахь хэсгийг тус тус үндэслэн "Нөмөр Кредит Ассет ТЗК" ХХК (цаашид "Компани" гэх)-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит бус хурлаас ТОГТООХ НЬ:

1. "Нөмөр Кредит Ассет ТЗК" ХХК нь 10,000,000,000 /арван тэрбум төгрөг/ төгрөгийн нэг ширхэг нь 100000 /нэг зуун мянган төгрөг/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 100,000 /нэг зуун мянга/ ширхэг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг нийтэд санал болгохыг зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны ерөнхий нөхцөлийг энэ тогтоолын Хавсралт 1-р, Зээлийн хөрөнгийн багцад тавих шалгуур үзүүлэлтийг энэ тогтоолын Хавсралт 2-р тус тус батлагсугай.

3. Батлагдсан нөхцөлийн дагуу үнэт цаасны танилцуулгыг бэлтгэж, Санхүүгийн зохицуулах хороо болон холбогдох байгууллагад хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгүүлэн, Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд санал болгосугай.

4. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг "Нөмөр Кредит Ассет ТЗК" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД:

| | |
|---|---|
| ТУЗ-ИЙН ДАРГА | Н.Баасанхүү |
| ТУЗ-ИЙН ГИШҮҮН | Б.Ренценханд |
| ТУЗ-ИЙН ГИШҮҮН | Б.Эрдэнэжаргал |

"Нөмөр Кредит Ассет ТЗК" ХХК-ийн ТУЗ-ийн 2022
оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 08 тоот
тогтоолын Хавсралт 1

**"НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЗК" ХХК-ИЙН**
**ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААСНЫ НӨХЦӨЛ**

| | |
|---|---|
| Үнэт цаасны төрөл | Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас |
| Үнэт цаасны бүртгэл | Хөрөнгийн бирж |
| Үнэт цаасны нэр | "Нөмөр Кредит Ассет" ХБҮЦ |
| Үнэт цаасны тоо ширхэг | 100,000 ширхэг |
| Үнэт цаасны нэгжийн нэрлэсэн үнэ | 100,000 төгрөг |
| Үнэт цаасны үнийн дүн | 10,000,000,000 төгрөг |
| Үнэт цаас гаргахаар төлөвлөж буй огноо | 2022.09 сар |
| Үнэт цаасны хүү, хувь хэмжээ: /жил/ | 17.5% |
| Үнэт цаасны хугацаа: /хоног, сар, жил/ | 24 сар |
| Үнэт цаасны хүүгийн төрөл | Тогтмол |
| Үнэт цаасны хүү тооцох суурь хоног | 365 |
| Үнэт цаасны хүү төлөх хугацаа: давтамж/ | Улирал тутам |
| Үнэт цаасны үндсэн төлбөр төлөгдөх хугацаа | Жил бүр |
| Үнэт цаасны хадгалалт, төлбөр тооцоо: | Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв |
| Үнэт цаасны зарцуулалт: | Компанийн үндсэн үйл ажиллагаа |
| Барьцаа: | Автомашин барьцаалсан зээлийн багц |

"Нөмөр Кредит Ассет ТЗК" ХХК-ийн ТУЗ-ийн 2022
оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 08 тоот тогтоолын
Хавсралт-2

**"НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЗК" ХХК-ИЙН**
**ЗЭЭЛИЙН ХӨРӨНГӨД ТАВИГДАХ ШАЛГУУР**

**Автомашины зээлд тавигдах санхүүгийн шалгуур үзүүлэлт**

1. СЗХ-нд хүргүүлэх хөрөнгийн мэдээлэл нь зээлийн хувийн хэрэг дэх үндсэн баримттай нийцэж байх
2. Зээл нь Монгол төгрөгөөр олгогдсон бөгөөд Монгол төгрөгөөр эргэн төлөгдөх зээл байх
3. Зээлийн эргэн төлөлтийн хуваарьт зээлдэгчийн сар бүрийн төлөх дүнг (төлж дуусгах хугацаа) тусгасан байх, зээлийн хугацааны эцэст бүрэн төлөгдөж дуусахаар байх
4. Автомашины зээлийн хувьд фидуцийн гэрээний зүйл нь даатгалд даатгагдсан байх, даатгал нь хүчин төгөлдөр байх
5. Тасалбар болгосон өдрийн байдлаар зээл нь хэвийн төлөлттэй байх
6. Зээлийг холбогдох журмын дагуу үүсгэсэн байх бөгөөд зээлийн стандарт нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн дотооддоо хэрэгжүүлдэг ерөнхий стандартаас дутуугүй шалгуур хангасан байх
7. Тасалбар болгосон өдрөөрх зээл үнэлгээний харьцаа (ЗҮХ) 85%-с хэтрэхгүй байх.
    a. ЗҮХ = (Зээлийн үлдэгдэл)/(Үндсэн барьцаа хөрөнгийн худалдаж авч буй үнэ)
    b. Зээл олгосон өдрийн байдлаар зээлдэгч нь Банк, санхүүгийн байгууллагад хугацаа хэтэрсэн, чанаргүй зээлийн өрийн үлдэгдэлгүй байх

"Нөмөр Кредит Ассет ТЗК" ХХК-ийн ТУЗ-ийн 2022
оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 08 тоот тогтоолын
Хавсралт 2

**Автомашины зээлийн багцад тавигдах шалгуур үзүүлэлтүүд**

1. Автомашины зээлийн гэрээ нь хуульд заасан шаардлагад нийцсэн, хүчин төгөлдөр, гэрээнд заасан үүрэг нь заавал биелэгдэх шинжтэй байх;
2. Фидуцийн гэрээ нь хуульд заасан шаардлагад нийцсэн, хүчин төгөлдөр, гэрээнд заасан үүрэг нь заавал биелэгдэх шинжтэй байх;
3. Фидуцийн гэрээний дагуу автомашиныг анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд шилжүүлсэн байх, холбогдох бүртгэлийг хийлгэсэн байх;
4. Тасалбар болгох өдрийн байдлаар зээлийн гэрээ, фидуцийн гэрээ нь Үүрэг гүйцэтгэгчийн хувьд үүргээ хугацаанаас өмнө дуусгавар болгох/урьдчилан төлөх нөхцөл, хэлцлээс татгалзах, харилцан суутгал хийх замаар үүргийг дуусгавар болгох, сөрөг нэхэмжлэл гаргах, эсхүл үүргээс татгалзах (илт хохиролтой хэлцлийн улмаас үүргээс татгалзах нөхцөлийг хамааруулан) эрх үүсээгүй, эсхүл эрхээ хэрэгжүүлэх хүсэл зориг илэрхийлээгүй байх;
5. Зээлийн гэрээ, Фидуцийн гэрээний шаардах эрх гуравдагч этгээдэд шилжих боломжтой, ийнхүү шаардах эрхээ шилжүүлэх нь хууль, гэрээнд харшлаагүй байх.

СЗХ
... он ... сар ... өдөр
БҮРТГЭВ

2022 -08- 2?
БҮРТГЭВ-03

2022 оны 08-р сарын 25

“НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЗК” ХХК-ААС ОЛОН НИЙТЭД САНАЛ БОЛГОЖ БУЙ ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН БАТАЛГААТ ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ

# ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТ

KhanLexPartners
Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүрэг, 1-р хороо,
Олимпын гудамж-5, Аюуд Тауэр;
И-мэйл: info@khanlex.mn
Утас: (976)7747-1122

Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Delivering diversity
Улаанбаатар хот

УЛААНБААТАР ХОТ
НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЗК ХХК
9022080593
6862705 СБТ19638

АГУУЛГА

**1. Удиртгал болон дүгнэлтийн хүрээ** ........................................ 3

**1.1 Хууль зүйн дүгнэлт** ........................................ 3

**1.2 Дүгнэлтийн хүрээ** ........................................ 3

**1.4 Дүгнэлт гаргахад ашигласан баримт бичиг** ........................................ 4

**1.5 Хязгаарлалт** ........................................ 4

**1.6 Мэдэгдэл** ........................................ 4

**2. Нэр томьёо ба товчилсон үгийн тайлбар** ........................................ 6

**3. Хууль зүйн дүгнэлт** ........................................ 7

**3.1. ТЗК-ийг үүсгэн байгуулах ажиллагаа болон түүнийг хуулийн этгээдийн бүртгэлд бүртгүүлсэн байдал нь хууль тогтоомжийн хүрээнд хийгдсэн, холбогдох шийдвэр, гэрчилгээ, дүрэм зэрэг нь хүчин төгөлдөр эсэх талаар** ........................................ 7

**3.2. ТЗК-ийн дүрэм, үндсэн үйл ажиллагаанд ашиглагдах журам, заавруud нь хууль тогтоомжид нийцсэн эсэх талаар** ........................................ 9

**3.3. Үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч этгээдтэй байгуулсан болон ТЗК-ийн үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой бусад гэрээ, хэлцэл нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх, үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар байгаа эсэх талаар** ........................................ 14

**3.4. Үнэт цаас гаргагч нь үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч бусад этгээдтэй ашиг сонирхлын зөрчилтэй эсэх талаар** ........................................ 20

**3.5. Үнэт цаасны танилцуулга, түүнд тусгагдсан мэдээлэл нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, бусад холбогдох хууль журамд нийцэж буй эсэх, үнэн зөв, хүчин төгөлдөр эсэх** ........................................ 22

**Хавсралт № 1** ........................................ 23

"НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЗК" ХХК-ААС ОЛОН НИЙТЭД САНАЛ БОЛГОЖ БУЙ ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН БАТАЛГААТ ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГАД ТУСГАГДСАН МЭДЭЭЛЭЛ ҮНЭН ЗӨВ, ХҮЧИН ТӨГӨЛДӨР ЭСЭХ ТАЛААРХ ХУУЛЬ ЗҮЙН ШИНЖИЛГЭЭ, ДҮГНЭЛТ23

**Хавсралт № 2** ........................................ 87

"НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЗК" ХХК БОЛОН "НӨМӨР КРЕДИТ ББСБ" ХХК-ИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУДЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ ҮНЭН ЗӨВ БӨГӨӨД ХУУЛЬД НИЙЦСЭН ЭСЭХ ТУХАЙ ХУУЛЬ ЗҮЙН ШИНЖИЛГЭЭ, ДҮГНЭЛТ ........................................ 87

**Хавсралт № 3** ........................................ 99

ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТ ГАРГАХТАЙ ХОЛБООТОЙГООР ТӨРИЙН БАЙГУУЛЛАГААС АВСАН ЛАВЛАГАА, БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ ........................................ 99

**Хавсралт № 4** ........................................ 104

ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТ ГАРГАХТАЙ ХОЛБООТОЙГООР "НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЗК" ХХК, ХОЛБОГДОХ БУСАД БАЙГУУЛЛАГААС ХҮЛЭЭН АВСАН БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ ........................................ 104



УЛААНБААТАР ХОТ
НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЗК ХХК
9022080593
6862705 СБТ19638

СЗХ
2022 09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022 -09- 2 5
БҮРТГЭВ-03

1. Удиртгал болон дүгнэлтийн хүрээ

**1.1 Хууль зүйн дүгнэлт**

Өмгөөллийн "ХаанЛекс Партнерс" ХХН (цаашид "**ХаанЛекс**", эсхүл "**бид**" гэх) нь Санхүүгийн зохицуулах хороо (цаашид "**СЗХ**" гэх)-ны 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 338 тоот тогтоолын дагуу үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх этгээдээр бүртгэгдсэн ба *Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.6-д заасны дагуу* үнэт цаасны танилцуулгад тусгасан мэдээллийн үнэн зөв, хүчин төгөлдөр эсэх тухай дүгнэлт (цаашид "**Дүгнэлт**" гэх) гаргах бүрэн эрхтэй байна. Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан Монгол Улсын хуулийн этгээд болох "Нөмөр Кредит Ассет ТЗК" ХХК (РД: 6862705) (цаашид "**ТЗК**" эсхүл "**Үнэт цаас гаргагч**" гэх)-аас хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргах үйл ажиллагаатай холбоотойгоор Дүгнэлт гаргуулах тухай хүсэлт тавьсны дагуу Үнэт цаас гаргагч болон ХаанЛекс нар нь 2022 оны 05 дугаар сарын 09-ний өдөр 563 тоот "Хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ" байгуулсан ба уг гэрээний дагуу энэхүү Дүгнэлтийг гаргасан болно.

**1.2 Дүгнэлтийн хүрээ**

Үнэт цаас гаргагчаас хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргахтай холбоотой энэхүү Дүгнэлтийг Монголын хөрөнгийн бирж ТӨХК (цаашид "**МХБ**" гэх)-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн 2020/07 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам" (цаашид **"МХБ-ийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам"** гэх)-ийн 2.5.5-д заасан агуулгын хүрээнд бэлтгэсэн.

ХаанЛекс нь энэхүү Дүгнэлтийг боловсруулах үед хүчин төгөлдөр үйлчилж буй Монгол Улсын хууль тогтоомж, хэм хэмжээний актаар тогтоосон нөхцөл, журмын хүрээнд бэлтгэсэн бөгөөд гадаад улсын хууль тогтоомж, хэм хэмжээг тайлбарлах, хэрэглэх асуудал багтаагүй болно.

Хууль тогтоомжоор СЗХ-ны бүрэн эрхэд хамааруулсан болон СЗХ-оос зөвшөөрөл олгосон аливаа асуудлаар ХаанЛекс нь дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргаагүй.

Дүгнэлтэд дурдагдаж буй эрх бүхий байгууллагын лавлагаа, тодорхойлолтод үндэслэн хийж буй Дүгнэлтийн хамаарах хугацаа нь тухайн лавлагаа тодорхойлолтын огноогоор хязгаарлагдана. Тухайн тодорхойлолтын огнооноос хойших үйл явдалд ХаанЛекс нь дүгнэлт хийгээгүй бөгөөд бидний зүгээс ямар нэгэн баталгаа гаргахгүй болно.

3

Golomt Capital ҮЦК ХХК
Улаанбаатар хот

УЛААНБААТАР ХОТ
НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЗК ХХК
9022080593
6862705 СБТ19638

## 1.4 Дүгнэлт гаргахад ашигласан баримт бичиг

Энэхүү Дүгнэлтийг зөвхөн дараах баримт бичиг, мэдээлэл (цаашид "**Баримт бичиг**" гэх)-д үндэслэн боловсруулсан болно. Үүнд:

(i) ХаанЛексийн хүсэлтийн дагуу ТЗК-аас гаргаж өгсөн, энэ Дүгнэлтийн Хавсралт № 4-д жагсаасан баримт бичгүүд;

(ii) Энэ Дүгнэлтийг гаргахтай холбоотойгоор төрийн холбогдох байгууллагаас авсан бөгөөд тус Дүгнэлтийн Хавсралт № 3-д жагсаасан лавлагаа, тодорхойлолтууд;

## 1.5 Хязгаарлалт

Энэхүү Дүгнэлт нь хөндлөнгийн, хууль зүйн дүн шинжилгээ хийсэн баримт бичиг бөгөөд аливаа гуравдагч этгээдийн өмнө эрх, үүрэг, хариуцлага үүсгэхгүй ба хууль зүйн туслалцаа зөвлөгөө өгсөнд тооцогдохгүй.

Хуулийн дүгнэлтийг зөвхөн энд дурдагдсан зорилгоор боловсруулсан бөгөөд Үнэт цаас гаргагч нь өөр бусад зорилгоор ашиглах, биднээс тухайлан олгосон зөвшөөрөлгүйгээр өөрчлөлт оруулахыг хориглоно.

Дүгнэлт гаргах явцад Үнэт цаас гаргагч болон бусад холбогдох этгээд ач холбогдол бүхий баримт, мэдээллийг нуусан, орхигдуулсан зэрэг нөхцөлд үүсэх үр дагаврыг ХаанЛекс хариуцахгүй.

Үнэт цаас гаргагч болон холбогдох бусад этгээдээс ирүүлсэн лавлагаа, тодорхойлолт, албан бичиг зэргийн огноо нь харилцан адилгүй өөр байгаа бөгөөд тэдгээр баримт бичигт үндэслэн тухайн асуудлаар бидний гаргасан дүгнэлтийн хугацаа нь мөн холбогдох баримт бичгийн огноогоор хязгаарлагдана.

Энэхүү Дүгнэлтийг энд дурдсан хүрээ хязгаарын дотор зөвхөн хууль зүйн асуудлаар бэлтгэсэн бөгөөд Бид үнэт цаасны танилцуулгад тусгагдсан зах зээлийн мэдээ, бизнес, эдийн засаг, санхүү гэх мэт хуульчаас өөр тусгай мэргэжил, мэргэшил шаардагдах асуудлаар дүгнэлт гаргах эрхгүй буюу хариуцлага хүлээхгүй болно.

## 1.6 Мэдэгдэл

Бид энэхүү Дүгнэлтийг Үнэт цаас гаргагч, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч бусад этгээдүүдээс ирүүлсэн баримт бичгүүд болон төрийн

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 1

2022-03-2
БҮРТГЭВ-03

холбогдох байгууллагад хандаж авсан лавлагаа, тодорхойлолтуудад үндэслэж бэлтгэсэн болно.

Бид энэхүү Дүгнэлтийг боловсруулахдаа дараах төсөөлөл буюу хүлээн зөвшөөрөл (assumption) дээр үндэслэсэн. Үүнд:

(iii) Баримт бичгүүд дэх огноо, гарын үсэг, тамга, тэмдэг нь үнэн зөв, хүчин төгөлдөр;

(iv) Баримт бичгийн хуулбарыг хүлээн авсан бол тэр нь эх хувийн үнэн зөв, бүрэн хуулбар мөн;

(v) Хэрвээ бид Баримт бичгийн төслийг хүлээн авсан бол уг баримт бичиг нь тус төслийн дагуу үйлдэгдэнэ;

(vi) Бидэнд ирүүлсэн Баримт бичгүүдэд нэмэлт, өөрчлөлт ороогүй, эсхүл тэдгээр нь хүчингүй болоогүй;

(vii) ТЗК болон бусад оролцогч талууд нь Баримт бичгийг үйлдэх бүрэн эрхтэй бөгөөд түүнийг зохих журмын дагуу үйлдсэн буюу байгуулсан ба түүгээр хүлээсэн үүргээ биелүүлнэ;

(viii) Аливаа этгээд нь санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдлээрээ төөрөгдүүлэх, хууран мэхлэх үйл ажиллагаанд оролцоогүй. Аливаа этгээд нь энэхүү тайлангийн аливаа хэсгийг буруу болгох ямарваа үйл ажиллагаанд оролцоогүй буюу оролцохгүй;

(ix) Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан болон хавсаргагдсан андеррайтер, аудитор болон бусад мэргэжлийн оролцогчдын гаргасан судалгаа, дүгнэлт, тайлан, санхүүгийн мэдээлэл нь үнэн зөв;

(x) Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан үйл баримт, мэдээлэл нь ирээдүйд хэрэгжих тохиолдолд тус үйл баримт, мэдээлэл нь хуулийн дагуу зохих ёсоор биелэгдэнэ;

Үнэт цаас гаргагч, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч этгээдүүд, бусад эрх бүхий байгууллага болон тэдгээрийн эрх бүхий албан тушаалтнуудаас ирүүлсэн баримт, мэдээлэл нь үнэн зөв, хүчин төгөлдөр.

5

Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Delivering diversity
1119289 111 5481589
Улаанбаатар хот



УЛААНБААТАР ХОТ
НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЗК ХХК
9022080593
6862705 СБТ19638

СЗХ
2022 .09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022 -09- 20
БҮРТГЭВ-03

## 2. Нэр томьёо ба товчилсон үгийн тайлбар

Дүгнэлтэд хаалтад тодорхойлсноос гадна дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

**"Анхны үүрэг гүйцэтгүүлэгч"** гэж "Нөмөр Кредит ББСБ" ХХК-ийг;

**"МХБ"** гэж "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийг;

**"МХБ-ийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам"** гэж МХБ-ийн ТУЗ-ийн 2020 оны 2020/06 тоот тогтоолоор баталсан "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам"-ыг;

**"СЗХ"** гэж Санхүүгийн зохицуулах хороог;

**"СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам"** гэж СЗХ-ны 2011 оны 266 тоот тогтоолоор баталсан "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх тусгай зөвшөөрөл олгох тухай журам"-ыг;

**"ТУЗ"** гэж төлөөлөн удирдах зөвлөлийг;

**"УБЕГ"** гэж Улсын бүртгэлийн ерөнхий газрыг;

**"Үнэт цаасны бүртгэлийн журам"** гэж СЗХ-ны 2021 оны 225 тоот тогтоолоор баталсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ыг.



Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
1119289111 5481589



УЛААНБААТАР ХОТ
НӨМӨР КРЕДИТ
ХХК
9022080593
6862705 СБТ19638

СЗХ
2022 он 09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -09- 29
БҮРТГЭВ-03

## 3. Хууль зүйн дүгнэлт

### 3.1. ТЗК-ийг үүсгэн байгуулах ажиллагаа болон түүнийг хуулийн этгээдийн бүртгэлд бүртгүүлсэн байдал нь хууль тогтоомжийн хүрээнд хийгдсэн, холбогдох шийдвэр, гэрчилгээ, дүрэм зэрэг нь хүчин төгөлдөр эсэх талаар

ТЗК-ийг үүсгэн байгуулах ажиллагаа болон түүнийг хуулийн этгээдийн бүртгэлд бүртгүүлсэн байдал нь хууль тогтоомжийн хүрээнд хийгдсэн, холбогдох шийдвэр. гэрчилгээ, дүрэм зэрэг нь хүчин төгөлдөр эсэхийг дараах асуултад харнулт өгөх замаар шалгав:

(i) ***<u>ТЗК-ийг үүсгэн байгуулсан этгээд нь түүнийг байгуулах эрх бүхий субьект мөн эсэх?</u>***

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.4-т зааснаар тусгай зориулалтын компанийг банк, банк бус санхүүгийн байгууллага, орон сууцны санхүүжилтийн компани болон СЗХ-оос зөвшөөрсөн санхүүгийн бусад байгууллага байгуулж болох юм. "Нөмөр кредит ББСБ" ХХК нь СЗХ-ны 2015 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 189 тоот тогтоолын дагуу банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан СЗХ-нд бүртгэлтэй аж ахуй нэгж байх тул баталгаат үнэт цаас гаргах тусгай зориулалтын компанийг үүсгэн байгуулах эрх бүхий этгээд мөн байна.

(ii) ***<u>ТЗК-ийг үүсгэн байгуулах үйл ажиллагаа нь хууль тогтоомжийн дагуу явагдсан эсэх?</u>***

"Нөмөр кредит ассет" ХХК нь "Нөмөр кредит ББСБ" ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 04/29 тоот "Нөмөр кредит ассет" ХХК-ийг үүсгэн байгуулах тухай тогтоолын дагуу үүсгэн байгуулагдаж, 2022 оны 5 дугаар сарын 03-ны өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт бүртгэгдсэн байна. "Нөмөр кредит ББСБ" ХХК, түүний хувьцаа эзэмшигчид нь Компанийн тухай хуулийн 13.2, 62.1.1 дэх хэсэгт тус тус заасны дагуу дээрх шийдвэрийг гаргах бүрэн эрхтэй байна.

"Нөмөр кредит ассет" ХХК нь хувьцаа эзэмшигч, үүсгэн байгуулагчийн 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 15/27 тоот шийдвэрийн дагуу авто тээврийн хэрэгсэл барьцаалсан зээлийн хөрөнгө, финтекийн зээлийн хөрөнгө худалдан авч баталгаат үнэт цаас гаргах зорилгоор компанийн үйл ажиллагааны чиглэлийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа болгон өөрчилж, компанийн дүрмийг шинэчлэн баталсан байх бөгөөд энэ нь Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх хэсэгт нийцэж байна.



Golomt Capital
Улаанбаатар хот

УЛААНБААТАР ХОТ
НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЗК
ХХК
9022080593
6862705 СБТ19638

СЗХ
2022 он 10 сар 1 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -09- 29
БҮРТГЭВ-03

Компанийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3.6 дахь хэсэг, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт тус тус заасны дагуу хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа нь СЗХ-ны тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх үйл ажиллагаа байна. "Нөмөр кредит ассет" ХХК нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тухай хүсэлтийг СЗХ-нд 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 05-27 тоот албан бичгээр гаргасны дагуу тус үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрлийг СЗХ-оос 2022 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн 414 тоот тогтоолоор Үнэт цаас гаргагчид олгосон байна. Тус тусгай зөвшөөрлийн үндсэн дээр ТЗК нь эрхлэх үйл ажиллагааны чиглэлийн өөрчлөлт болон шинэчилсэн дүрмийг 2022 оны 8 дугаар сарын 16-ны өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар бүртгүүлсэн байна.

(iii) ***<u>ТЗК-ийн гэрчилгээ нь хүчин төгөлдөр эсэх?</u>***

"Нөмөр кредит ассет ТЗК" ХХК-ийн Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 254449 тоот гэрчилгээ нь улсын бүртгэгчийн тамга, тэмдгээр баталгаажсан байх бөгөөд түүнд тусгагдсан мэдээлэл нь хуулийн этгээдийн улсын бүртгэлийн лавлагаанд тусгагдсан мэдээлэлтэй нийцэж байх тул хүчин төгөлдөр гэж үзлээ.

*/Жич: ТЗК-ийн дүрэм хүчин төгөлдөр эсэх тухай дүгнэлтийн дэлгэрэнгүйг 3.2 дахь хэсгээс үзнэ үү./*

Иймд Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн материалын хүрээнд ТЗК-ийг үүсгэн байгуулах болон түүнийг хуулийн этгээдийн бүртгэлд бүртгүүлэх ажиллагаа нь хууль тогтоомжийн хүрээнд хийгдсэн бөгөөд ТЗК-ийн холбогдох шийдвэр, улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм нь хүчин төгөлдөр байна гэж дүгнэлээ.

8

Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Улаанбаатар хот



УЛААНБААТАР ХОТ
НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЗК ХХК
9022080593
6862705 СБТ19638

2022 09 он сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -09- 29
БҮРТГЭВ-03

3.2. ТЗК-ийн дүрэм, үндсэн үйл ажиллагаанд ашиглагдах журам, заавруud нь хууль тогтоомжид нийцсэн эсэх талаар

Үнэт цаас гаргагчаас заавал батлах дүрэм, журмыг МХБ-ийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 3.2.12-т заасан байдаг бөгөөд Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь тус журамд нийцүүлэн ТЗК-ийн үйл ажиллагаанд ашиглагдах дүрэм, журмын жагсаалтыг 2022 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн албан бичгээр бидэнд ирүүлсэн бөгөөд уг албан бичигт дараах дүрэм, журмууд багтсан байна. Үүнд:

(i) “Нөмөр кредит ассет ТЗК” ХХК-ийн дүрэм;
(ii) ТУЗ-ийн үйл ажиллагааны журам;
(iii) Хөндлөнгийн аудитор, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих тухай журам;
(iv) Эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын журам;
(v) Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам;
(vi) Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журам;
(vii) Хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах журам;
(viii) Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам.

ТЗК-ийн дүрэм болон дээр дурдсан журмуудыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг дараах байдлаар нэг бүрчлэн шалгалаа. Тодруулбал:

## I. ***<u>ТЗК-ийн дүрэм</u>***

ТЗК-ийн дүрмийг тус компанийн хувьцаа эзэмшигчийн 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 05/27 тоот шийдвэрийн хавсралтаар баталсан нь Компанийн тухай хуулийн 17.1 болон 62.1.1-т заасан шаардлагыг хангаж байна. Түүнчлэн уг дүрмийг УБЕГ-ын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт 2022 оны 08 дугаар сарын 16-ны өдөр бүртгүүлсэн тул Компанийн тухай хуулийн 17.9-д заасны дагуу хүчин төгөлдөр гэж үзэж болохоор байна.

ТЗК-ийн дүрэм нь нийт 9 зүйлтэй бөгөөд зүйл тус бүр нь дараах харилцааг зохицуулсан байна. Үүнд:

(i) *Нэгдүгээр зүйл: Компанийн зорилго, бүрэн болон товчилсон оноосон нэр, түүний хэлбэрийг тодорхойлсон товчилсон ялгах тэмдэглэгээ, компанийн хаяг, түүнчлэн баталгаат үнэт цаас бүрэн төлөгдөж дууссан тохиолдолд татан буугдах тухай;*
(ii) *Хоёрдугаар зүйл: Компанийн эрхлэх үйл ажиллагааны чиглэл;*
(iii) *Гуравдугаар зүйл: Компанийн зарласан болон гаргасан хувьцааны тоо, тэдгээрийн төрөл, нэрлэсэн үнэ, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ;*
(iv) *Дөрөвдүгээр зүйл: Компанийн эрх, үүрэг;*



Голомт Кэпитал ҮЦК ХХК
Golomt Capital
Ulaanbaatar хот



УЛААНБААТАР ХОТ
НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЗК
ХХК
9022080593
6862705 СБТ19638

СЗХ
Төн... сар 1 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2022-09-29
БҮРТГЭВ-03

(v) *Тавдугаар зүйл: Компанийн хариуцлага;*
(vi) *Зургаадугаар зүйл: Компанийн удирдлага, тэдгээрийн бүрэн эрх;*
(vii) *Долдугаар зүйл: Компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд тавих хяналт;*
(viii) *Наймдугаар зүйл: Компанийг татан буулгах үндэслэл, журам;*
(ix) *Есдүгээр зүйл: Дүрмийн хувь болон дүрмийн хүчин төгөлдөр болох үндэслэл, зохицуулах хууль.*

Агуулгын хувьд компанийн дүрэм нь Компанийн тухай хуулийн 16.2 болон Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.9-д заасан шаардлагыг тус тус хангасан байх ёстой. ТЗК-ийн дүрэм нь уг хуулийн шаардлагуудыг хангаж байгаа бөгөөд хууль тогтоомжтой зөрчилдөөгүй байна.

## II. *ТУЗ-ийн үйл ажиллагааны журам*

ТЗК-ийн ТУЗ нь 2022 оны 5 дугаар сарын 04-ний өдрийн №05/04-1 тоот шийдвэрийн хавсралтаар ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг баталсан байх бөгөөд энэ нь Компанийн тухай хуулийн 76.1.13 дахь хэсэгт заасан шаардлагад нийцэж байна.

Энэхүү журам нь нийт 6 зүйлтэй бөгөөд тэдгээр нь дараах харилцааг зохицуулсан байна. Үүнд:

(i) *Нэгдүгээр зүйл:* Журмын зорилго, ТУЗ-ийн үйл ажиллагааг зохицуулах хууль, журмууд;
(ii) *Хоёрдугаар зүйл:* ТУЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүн, гишүүнд тавигдах шаардлага;
(iii) *Гуравдугаар зүйл:* ТУЗ-ийн бүрэн эрх, зохион байгуулалт;
(iv) *Дөрөвдүгээр зүйл :* ТУЗ-ийн хурлын зар хүргэх, хуралд оролцох, санал өгөх, хурлын хүчин төгөлдөр байдал болон шийдвэр гаргалт;
(v) *Тавдугаар зүйл:* ТУЗ-ийн гишүүний ажлын нөхцөл, хангамж;
(vi) *Зургаадугаар зүйл:* ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын хүчин төгөлдөр болох нөхцөл болон түүнд нэмэлт өөрчлөлт оруулах.

ТЗК-ийн үйл ажиллагааны журам нь Компанийн тухай хуулийн 75 – 82 дугаар зүйл, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.8, СЗХ-ны 2022 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 145 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Компанийн засаглалын кодекс"-ын 2.1 дэх хэсгийн тайлбар 1 дэх хэсэг, СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 3.12, 3.13, 3.14, 3.16-д заасан шаардлагыг тус тус хангасан байвал зохих бөгөөд Хуулийн фирм нь журмыг хянаад эдгээр зохицуулалтад нийцсэн байна гэж дүгнэлээ.

## III. *Хөндлөнгийн аудитор, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих тухай журам*



Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Улаанбаатар хот



УЛААНБААТАР ХОТ
НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЗК ХХК
9022080593
6862705 СБТ19638

ТЗК-ийн Хөндлөнгийн аудитор, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох тухай журам нь Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2022 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн 05-27 тоот тогтоолоор батлагдсан байх бөгөөд энэ нь СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 3.12, ТЗК-ийн дүрмийн 6.2.7.3, ТУЗ-ийн Үйл ажиллагааны журмын 3.3.2 дахь хэсэгт тус тус нийцэж байна.

Уг журмаар хөндлөнгийн аудитор, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчид тавигдах шаардлага, тэдгээрийг сонгох, солих журам, тэдгээртэй байгуулах гэрээний нөхцөлтэй холбоотой харилцааг зохицуулсан байх бөгөөд Хуулийн фирм нь эдгээр зохицуулалтыг нэг бүрчлэн хянаад Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 33.2.3, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 19, 20, 40 дүгээр зүйл, Аудитын тухай хуулийн 19 дүгээр зүйл, СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 4, 8 дугаар зүйл, МХБ-ийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 2.7, 9.4 дэх хэсэгт тус тус нийцсэн гэж дүгнэлээ.

## IV. ***Эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын журам***

Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь 2022 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 07 тоот тогтоолоор "Эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын журам"-ыг баталсан байна. СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 3.12, ТЗК-ийн дүрмийн 6.2.7.3, ТУЗ-ийн Үйл ажиллагааны журмын 3.3.6 дахь хэсэгт тус тус заасны дагуу Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь энэхүү журмыг батлах бүрэн эрхтэй байх тул хуульд нийцэж байна.

Тус журам нь зээлдэгч, анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагч болон гадаад хүчин зүйлстэй холбоотой эрсдэл, тэдгээрийг удирдах, урьдчилсан сэргийлэх арга хэмжээ, эргэн төлөлтийг сайжруулах арга хэмжээтэй холбоотой харилцааг зохицуулсан нийт 6 зүйлээс бүрдэж байх бөгөөд эдгээр нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 41.1, МХБ-ийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 3.2.12.4 болон бусад хууль тогтоомжид заасан шаардлагын хүрээнд буюу эдгээртэй зөрчилдөхгүй байна. Иймд энэхүү журмыг хууль тогтоомжид нийцсэн гэж дүгнэлээ.

## V. ***Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх журам***

Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь 2022 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 07 тоот тогтоолоор Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх журмыг баталсан байх бөгөөд СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 3.12, ТЗК-ийн дүрмийн 6.2.7.3, ТУЗ-ийн Үйл ажиллагааны журмын 3.3.5 дахь хэсэгт тус тус заасны дагуу ТУЗ нь энэхүү журмыг батлах бүрэн эрхтэй байна. Тус журам нь нийт 7 зүйлтэй бөгөөд ТЗК-аас гаргах хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны төлбөрийг цуглуулах, үнэт цаас





Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Delivering quality
Улаанбаатар хот

УЛААНБААТАР ХОТ
НОМОР КРЕДИТ АССЕТ ТЗК ХХК
9022080593
6862705 СБТ19638

СЗХ
2022 09 21
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-09-29
БҮРТГЭВ-03

эзэмшигчдэд төлбөр төлөхтэй холбоотойгоор ТЗК, Үйлчилгээ үзүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагч болон бусад холбогдох этгээдийн хооронд үүсэх харилцааг зохицуулсан байгаа нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 19, 20 дугаар зүйл, СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 4 дүгээр зүйл болон бусад зүйл, заалтыг зөрчөөгүй бөгөөд холбогдох хуульд нийцсэн байна.

## VI. ***Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргэх журам***

Тус журмыг Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2022 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 07 тоот тогтоолоор баталсан байх бөгөөд СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 3.12, ТЗК-ийн дүрмийн 6.2.7.3, ТУЗ-ийн Үйл ажиллагааны журмын 3.3.4 дахь хэсэгт тус тус заасны дагуу ТУЗ нь энэхүү журмыг батлах бүрэн эрхтэй байна. Уг журмаар Хөрөнгө оруулагч, Үнэт цаас эзэмшигч нарт компанийн үйл ажиллагааны талаар болон хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг тогтмол хүргэх, уг мэдээллийн төрөл, хэлбэр, давтамж, мэдээллийн ил тод байдлыг хангах, нийтэд хүргэх, нэгдсэн нэг мэдээллийн урсгалтай байх, түүнийг хэрэгжүүлэх, хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулсан байх бөгөөд энэ нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20.1 дэх хэсэг болон Долоодугаар бүлгийн Нэгдүгээр дэд бүлэг, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20.2.3 дахь хэсэг, 39 дүгээр зүйл, СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 3.14.5, 3.19, 3.21, 3.22, 3.23, 3.24 дахь хэсэг, МХБ-ийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 9.5, 9.6, 9.7 дахь хэсэг, СЗХ-ны 2019 оны 72 тоот тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны зах зээл дэх дотоод мэдээллийн жагсаалт, түүнийг мэдээлэх журам"-ын холбогдох зүйл, заалтад тус тус нийцсэн байна.

## VII. ***Хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах журам***

Тус журмыг Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2022 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 07 тоот тогтоолоор баталсан байх бөгөөд СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 3.12, ТЗК-ийн дүрмийн 6.2.7.3, ТУЗ-ийн Үйл ажиллагааны журмын 3.3.3 дахь хэсэгт тус тус заасны дагуу ТУЗ нь энэхүү журмыг батлах бүрэн эрхтэй байна. Багцын хөрөнгөд өөрчлөлт оруулах журам нь нийт 5 зүйлтэй байх бөгөөд Үнэт цаас гаргагчийн гаргаж буй баталгаат үнэт цаасны баталгаа болох хөрөнгийн багцад буй хөрөнгийг солих, нэмэх, хасах замаар багцад өөрчлөлт оруулахтай холбоотой харилцааг зохицуулсан байна. Энэхүү журмын заалтууд нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 9 дүгээр зүйл, 12.11.5, 12.13, 15 дугаар зүйл, 18.2 дахь хэсэг, СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 3.12, 3.18, 3.19, 3.22 дахь хэсэгт тус тус заасан шаардлагуудыг зөрчөөгүй байх тул холбогдох хууль тогтоомжид нийцэж байна.



Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Улаанбаатар хот



УЛААНБААТАР ХОТ
НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЗК ХХК
9022080593
6862705 СБТ19638

numur
СЗХ
он сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2022 -09- 29
БҮРТГЭВ-03

**VIII.** ***Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам***

СЗХ-ны "Банкнаас бусад санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх тохиромжтой этгээдийг тодорхойлох журам"-ын 1.2.1, 2.1.1.2, 3.1.2.1 дэх хэсэг, СЗХ-ны эрх зүйн байдлын тухай хуулийн 3.1.6-д тус тус заасны дагуу Үнэт цаас гаргагч нь "Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэх, терроризмтой тэмцэх чиглэлээр тавигдах шаардлага, ёс зүйн шалгуур зэргийг тусгасан бодлого, журам"-тай байх шаардлагатай. Уг шаардлагын дагуу ТЗК-ийн ТУЗ-ийн 2022 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 07 тоот тогтоолоор уг журмыг баталсан байх бөгөөд энэхүү журам нь холбогдох хууль тогтоомжид нийцэж байна.



Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital



УЛААНБААТАР ХОТ
НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЗК ХХК
9022080593
6862705 СБТ19638

СЗХ
2022 он 09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-09-29
БҮРТГЭВ-03

### 3.3. Үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч этгээдтэй байгуулсан болон ТЗК-ийн үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой бусад гэрээ, хэлцэл нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх, үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар байгаа эсэх талаар

Баталгаат үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч этгээд гэдэгт "МХБ-ийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 2.5.5.3.-т заасны дагуу дараах этгээдийг хамруулан авч үзлээ. Үүнд:

(i) андеррайтер;
(ii) анхны үүрэг гүйцэтгүүлэгч;
(iii) үйлчилгээ үзүүлэгч;
(iv) хөрөнгө итгэмжлэн удирдагч.

ТЗК нь 2022 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн албан бичгээр ТЗК-ийн үйл ажиллагаатай холбоотойгоор байгуулагдсан болон байгуулах гэрээнүүдийн жагсаалтыг ирүүлсэн бөгөөд тус жагсаалтад тусгагдсан гэрээ, хэлцэл тус бүрийг хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг доорх байдлаар шалгалаа. Үүнд:

## I. ***<u>Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний төсөл</u>***

Үнэт цаас гаргагч нь ТУЗ-ийн 2022 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 08 тогтоолын дагуу хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, үүнтэй холбоотойгоор Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс худалдан авах зээлийн хөрөнгийн багцад тавигдах шалгуур үзүүлэлтийг баталсан байна. Түүнчлэн Үнэт цаас гаргагчид зээлийн багцын хөрөнгө худалдах тухай шийдвэрийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь 2022 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 09 тоот тогтоолоор баталсан байна. Иймд уг гэрээний төслийг ТЗК-ийн ТУЗ-ийн 2022 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 7 тоот тогтоолоор баталсан байх бөгөөд СЗХ-оос Үнэт цаас гаргагчийн баталгаат үнэт цаасыг бүртгэх зөвшөөрөл олгосны дараа "Нөмөр Кредит ББСБ" ХХК-тай байгуулахаар тогтоосон байна. Тус гэрээний төсөлд заасназр Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс Үнэт цаас гаргагчид гэрээнд заасан шалгуур үзүүлэлтийг хангасан зээлийн авлагын эрх, түүнд дагалдах эрхүүдийг худалдах, Үнэт цаас гаргагч нь хэлэлцэн тохиролцсон үнийг төлөх болон бусад холбогдох харилцааг зохицуулсан байна. Уг гэрээний төсөл нь дараах хавсралттай байх бөгөөд эдгээр нь уг гэрээний салшгүй хэсэг байна. Үүнд:

- Гэрээний ерөнхий шалгуур;
- Гэрээний тусгай нөхцөл;
- Гэрээний хавсралт №1 – Хөрөнгийн жагсаалт;
- Гэрээний хавсралт №2 – Хөрөнгөд тавих ерөнхий шалгуур;
- Бусад шаардлагатай баримт бичиг.



Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Delivering Diversity
1119293111 ☎ 5461589
Улаанбаатар хот



УЛААНБААТАР ХОТ
НӨМӨР АССЕТ ТЗК ХХК
9022080593
6862705 СБТ19638

Дээр дурдсан гэрээний төсөл нь Монгол Улсын Иргэний хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын холбогдох зүйл, заалт болон бусад хууль тогтоомжид нийцсэн байна.

## II. *Фидуцийн барьцааны гэрээний төсөл*

Үнэт цаас гаргагч болон "Нөмөр Кредит ББСБ" ХХК нарын хооронд байгуулагдах Фидуцийн барьцааны гэрээг СЗХ-оос Үнэт цаас гаргагчийн баталгаат үнэт цаасыг бүртгэх зөвшөөрөл олгосны дараа байгуулахаар ТЗК-ийн ТУЗ-ийн 2022 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 07 тоот тогтоолоор тогтсон байна. Энэхүү гэрээний төсөлд зааснаар хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны эргэн төлөлтийн үүргийн гүйцэтгэлийг хангуулах зорилгоор ТЗК болон "Нөмөр Кредит ББСБ" ХХК-ийн хооронд байгуулах "Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ"-ний дагуу шилжүүлэх Хөрөнгийн багцад буй автомашины фидуци бүхий зээлийн гэрээний үүргийг хангуулах фидуцийн эрхийг Нөмөр Кредит ББСБ" ХХК нь ТЗК-д барьцаалуулахтай холбогдох харилцааг зохицуулсан байх бөгөөд энэ нь Монгол Улсын Иргэний хууль, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцсэн байна.

## III. *Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ*

ТЗК-ийн ТУЗ нь 2022 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 07 тоот тогтоолоор хөрөнгө итгэмжлэн удирдагчаар "Юнайтед Айр Файнэнс" ХХК-ийг сонгон Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ байгуулахаар шийдвэрлэсэн байна. ТЗК нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.11.4, СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 3.17-д тус тус заасны дагуу энэхүү гэрээг байгуулах эрхтэй байх ба ТУЗ нь СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 3.12, ТУЗ-ийн Үйл ажиллагааны журмын 3.4.2-д тус тус заасны дагуу ТЗК-ийн нэрийн өмнөөс энэхүү гэрээг байгуулах, гэрээг батлах шийдвэрийг гаргах бүрэн эрхтэй байна. Энэхүү гэрээгээр ТЗК-ийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргах үйл ажиллагаатай холбоотой Хөрөнгө итгэмжлэн удирдагчаас үзүүлэх үйлчилгээ, үйлчилгээний хөлс төлөх болон гэрээний дагуу хамтран ажиллах зарчим, талуудын эрх, үүргийг зохицуулсан байх бөгөөд гэрээ нь үндсэн хэсгээс гадна 16 зүйл бүхий ерөнхий нөхцөл, 3 зүйл бүхий тусгай нөхцөлөөс бүрдсэн байна. Хуулийн фирм нь энэхүү гэрээний заалтыг нэг бүрчлэн хянаад тэдгээр нь Монгол Улсын Иргэний хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйл, СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 4 дүгээр зүйл, МХБ-ийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 2.7 заалтыг тус тус зөрчөөгүй, холбогдох хууль тогтоомжид нийцсэн гэж дүгнэлээ.

СЗХ 2022 он 09 сар 21 өдөр БҮРТГЭВ № 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2022-09-29 БҮРТГЭВ-03

## IV. *Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээ*

ТЗК-ийн ТУЗ нь 2022 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 07 тоот тогтоолын дагуу Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээг "Нөмөр Кредит ББСБ" ХХК болон "Юнайтед Айр Файнэнс" ХХК нартай байгуулахаар шийдвэрлэсэн байна. ТЗК нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.11.4, СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 3.17-д тус тус заасны дагуу энэхүү гэрээг байгуулах эрхтэй байх ба ТУЗ нь СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 3.12, ТЗК-ийн дүрмийн 6.2.7.3, ТУЗ-ийн Үйл ажиллагааны журмын 3.4.5, 3.5.3 дахь хэсэгт тус тус заасны дагуу ТЗК-ийн нэрийн өмнөөс энэхүү гэрээг байгуулах шийдвэрийг гаргах бүрэн эрхтэй байна. Тус гэрээ нь нийт 9 зүйлтэй бөгөөд Үйлчилгээ үзүүлэгч нь Үнэт цаас гаргагчийн гаргах хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны төлбөрийг цаг хугацаанд нь цуглуулан, шилжүүлэх, бүртгэлийг хөтлөх, тайлагнах, Зээлийн эрсдэлийг удирдах журмын дагуу зээлийн төлөлтөд хяналт тавьж, зээл төлүүлэх ажиллагаа явуулах болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчаас эдгээр үйл ажиллагаанд хяналт тавих, Үнэт цаас гаргагч нь үйлчилгээний төлбөрийг төлөхтэй холбоотой харилцааг зохицуулсан байна. Гэрээний заалтууд нь Монгол Улсын Иргэний хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 19 дүгээр зүйл, СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 4 дүгээр зүйл, МХБ-ийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 2.7 дахь хэсэг болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцсэн байна.

## V. *Санхүүгийн тайланд аудит хийх ажлын гэрээ*

ТЗК-ийн ТУЗ-ийн 2022 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн 12 тоот шийдвэрийн дагуу Хөндлөнгийн аудитын үйлчилгээ үзүүлэгчээр "Мүүрь аудит" ХХК-г томилж, гэрээ байгуулсныг хүчин төгөлдөрт тооцох шийдвэрийг гаргасан ба уг гэрээнд гарын үсэг зурах бүрэн эрхийг ТУЗ-ийн дарга Н.Баасанхүүд олгосон байна. ТУЗ нь Иргэний хуулийн 53 дугаар зүйлийн 53.1, СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 3.12, ТЗК-ийн дүрмийн 6.2.7.3, ТУЗ-ийн Үйл ажиллагааны журмын 3.5.3 -д тус тус заасны дагуу гэрээ байгуулах шийдвэр гаргах бүрэн эрхтэй байна. Энэхүү гэрээгээр Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 40.1, СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 8.1-т заасан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд жилд нэгээс доошгүй удаа хийх хөндлөнгийн аудитын хяналт, шалгалттай холбоотой харилцааг зохицуулсан байх бөгөөд энэ нь Аудитын тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль тогтоомжид нийцэж байна.



Голомт Капитал ҮЦК ХХК Golomt Capital Улаанбаатар хот



УЛААНБААТАР ХОТ НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЗК ХХК 9022080593 6862705 СБТ19638

VI. ***Тохиролцсон горимуудыг гүйцэтгэх ажлын гэрээ***

"Нөмөр Кредит Ассет" ХХК болон "Мүүрь аудит" ХХК нар нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахад зориулсан зээлийн багц нь ТЗК-аас ирүүлсэн шалгуур үзүүлэлтүүдэд нийцэж буй эсэхэд дүгнэлт гаргах, талуудын харилцан тохиролцсон горимыг гүйцэтгэх ажлыг холбогдох хууль тогтоомж болон үйлчилгээнний олон улсын стандартын дагуу гүйцэтгэхтэй холбоотойгоор талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулах зорилгоор 2022 оны 5 дугаар сарын 09-ний өдөр МА-2022-ТГГА-02 тоот "Тохиролцсон горимуудыг гүйцэтгэх ажлын гэрээ"-г байгуулсан байх бөгөөд тус гэрээ нь Аудитын тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль тогтоомжид нийцэж байна.

Түүнчлэн "Мүүрь аудит" ХХК нь Аудитын тухай хуулийн 19 дүгээр зүйл, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.3, СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 8.2 болон Үнэт цаасны бүртгэлийн журмын 11 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангаж байгаа аудитын компани болох нь түүний улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм, Аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн 061-2008 тоот гэрчилгээ, Үнэт цаасны зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг шинэчлэн бүртгэх тухай СЗХ-ны 2016 оны 04 дүгээр сарын 6-ны өдрийн 121 дүгээр тогтоол, "Мүүрь аудит" ХХК-ийн 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн в-118/22 тоот Баталгаа зэргээр нотлогдож байна.

VII. ***Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээ***

ТЗК болон Өмгөөллийн "ХаанЛекс Партнерс" ХХН нар нь 2022 оны 5 дугаар сарын 09-ний өдөр 563 тоот "Хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ" байгуулсан бөгөөд уг гэрээгээр Үнэт цаас гаргагчаас хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг нийтэд санал болгон нээлттэй гаргахтай холбоотой хууль зүйн дүгнэлт гаргах, Зээлийн багц нь хуулийн шалгуур үзүүлэлтэд нийцсэн эсэх талаарх хууль зүйн хөндлөнгийн дүн шинжилгээний тайлан бэлтгэх, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахтай холбоотой байгуулах гэрээ, хэлцэл, шийдвэрийн төсөл хянахтай холбогдон талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулсан байна. Энэ гэрээ нь Монгол Улсын Иргэний хууль, МХБ-ийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 2.5.5, 2.7 дахь хэсэг болон холбогдох хуульд нийцсэн байна.

Өмгөөллийн "ХаанЛекс Партнерс" ХХН нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахтай холбоотой хөндлөнгийн хууль зүйн дүгнэлт гаргах бүрэн эрхтэй бөгөөд үүнд харшлах шалтгаан байхгүй болох нь түүний үүсгэн байгуулах баримт бичиг, улсын бүртгэлийн гэрчилгээ, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг "Улсын бүртгэлийн ерөнхий газар"-ын http://opendata.burtgel.gov.mn/ хаягт заасан нээлттэй мэдээлэл, Санхүүгийн зохицуулах хорооны 338 тоот тогтоол болон Баталгаа гаргах тухай албан бичгээр нотлогдоно. Түүнчлэн ТЗК-ийн ТУЗ нь СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 3.12,



Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Улаанбаатар хот

УЛААНБААТАР ХОТ
НӨМӨР КРЕДИТ
ХХК
9022080593
6862705 СБТ19638

ТЗК-ийн дүрмийн 6.2.7.3, ТУЗ-ийн Үйл ажиллагааны журмын 3.4.2-д тус тус заасны дагуу ТЗК-ийн нэрийн өмнөөс энэхүү гэрээг байгуулах шийдвэрийг гаргах бүрэн эрхтэй байх тул гэрээг хүчин төгөлдөр гэж үзнэ.

## VIII. *Андеррайтерын үйлчилгээний гэрээ*

"Нөмөр Кредит Ассет ТЗК" ХХК болон "Голомт капитал ҮЦК" ХХК нар нь арван тэрбум хүртэлх төгрөгийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг олон нийтэд санал болгох, худалдах ажлыг удирдан зохион байгуулах, хөрөнгийн зах зээлээс санхүүжилт татан төвлөрүүлэхэд шаардлагатай магадлан шинжилгээ, тооцоолол, судалгаа, бэлтгэл ажлуудыг гүйцэтгэх, боломжит хөрөнгө оруулагчдад Үнэт цаас гаргагч, түүний олон нийтэд санал болгож буй үнэт цаасыг танилцуулах, санал болгох, арилжих үйлчилгээг андеррайтерын зүгээс үзүүлэх, үүнтэй холбогдон талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулах зорилгоор 2022 оны 8 дугаар сарын 18-ны өдөр 22/59 тоот "Андеррайтерын үйлчилгээний гэрээ"-г байгуулсан байна. Тус гэрээгээр талуудын эрх, үүрэг, хариуцлага, гүйцэтгэх ажил үйлчилгээ, үнэ, хугацаа зэргийг зохицуулсан байгаа нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 41 дүгээр зүйл, МХБ-ийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн бүртгэлийн журмын 2.4, 2.7-д заасан шаардлагыг хангаж байгаа бөгөөд холбогдох хуульд нийцсэн байна.

Түүнчлэн "Голомт капитал ҮЦК" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм, 2011 оны 11 дүгээр сарын 2-ны өдрийн ТЗ 301/97 тоот тусгай зөвшөөрлийн гэрчилгээ болон уг компанийн "*Мэдэгдэл гаргах тухай*" 2022 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 22/186 тоот албан бичиг зэргээс дүгнэвэл тус компани нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, СЗХ-ны Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журмын дагуу андеррайтерын үйл ажиллагааг эрхлэн, дээрх гэрээг байгуулах эрхтэй этгээд байна.

## IX. *Захиргааны ажилд үйлчилгээ үзүүлэх гэрээ*

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2022 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 07 тоот шийдвэрийн дагуу ТЗК болон "Нөмөр Кредит ББСБ" ХХК нар нь 2022 оны 08 дугаар сарын 18-ны өдөр "Захиргааны ажилд үйлчилгээ үзүүлэх гэрээ"-г байгуулсан байна. Тус гэрээгээр ТЗК-ийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулахтай холбоотой захиргааны үйлчилгээ үзүүлэх ажлыг захиргааны үйлчилгээ үзүүлэгч хийж гүйцэтгэх, ТЗК нь ажлын хөлсийг төлөхтэй холбоотой харилцаанд талуудын эдлэх эрх, хүлээх үүргийг тодорхойлсон байх бөгөөд эдгээр нь Монгол Улсын Иргэний хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.11.4, 12.12.5 дахь хэсэг, СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 3.17 дахь хэсэгт тус тус нийцсэн байна.

## X. *Хэлцлийн зөвлөх үйлчилгээний гэрээ*

Хэлцлийн зөвлөх үйлчилгээний гэрээг Үнэт цаас гаргагч болон "Юнайтед Айр Файнэнс" ХХК нар нь 2022 оны 05 дугаар сарын 06-ны өдөр байгуулсан байна. Тус гэрээ нь СЗХ-ноос ТЗК-ийн болон хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зөвшөөрөл олгогдох хүртэлх

18

хугацаанд хүчин төгөлдөр үйлчлэх бөгөөд ТЗК-ийг үүсгэн байгуулах, зохицуулалттай үйл ажиллагааны хүрээнд үнэт цаас гаргах, хөрөнгө оруулалт татан төвлөрүүлэх ажилд хэлцлийн зөвлөхөөс зөвлөх үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулж байна. СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 3.17 дахь хэсэгт заасанчлан "*ТЗК нь хөдөлмөрийн гэрээгээр ажилтан авч ажиллуулахгүй ба баталгаат үнэт цаас гаргахтай холбоотой үйлчилгээг гэрээний үндсэн дээр үүсгэн байгуулагч болон бусад гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх*" боломжтой байх бөгөөд энэхүү гэрээний агуулга болон заалтууд нь Иргэний хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан хуулийн агуулгад харшлаагүй байх тул хуульд нийцсэн гэж дүгнэлээ.

**XI.** ***Зээлийн эргэн төлөлтийн дансны барьцааны гэрээний төсөл***

Үнэт цаас гаргагч, "Нөмөр Кредит ББСБ" ХХК болон Хөрөнгө итгэмжлэн удирдагч нарын хооронд байгуулагдах Зээлийн эргэн төлөлтийн дансны барьцааны гэрээг СЗХ-оос Үнэт цаас гаргагчийн баталгаат үнэт цаасыг бүртгэх зөвшөөрөл олгосны дараа байгуулахаар ТЗК-ийн ТУЗ-ийн 2022 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 07 тоот тогтоолоор тогтсон байна. Тус гэрээгээр ТЗК болон Үйлчилгээ үзүүлэгч нарын хооронд байгуулсан Төлбөр цуглуулах, үйлчилгээ үзүүлэх гэрээний 2.3-т заасан зээлийн эргэн төлөлтийн дансанд цуглarах зээлийн төлбөрийн орлогыг барьцаалах, ТЗК-ийн ХБҮЦ-ны төлбөрийг төлөх зорилгоор ТЗК-ийн Төлбөр цуглуулах дансанд тохирсон хугацаанд үл маргах журмаар шилжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулсан байна. Хуулийн фирм нь энэхүү гэрээг нэг бүрчлэн хянаад Иргэний хууль болон Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн холбогдох заалтад нийцсэн байна гэж дүгнэлээ.

**XII.** ***Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааг нөхцөлтэй санхүүжүүлэх гэрээ***

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааг нөхцөлтэй санхүүжүүлэх гэрээг Үнэт цаас гаргагч болон "Нөмөр Кредит ББСБ" ХХК (Анхны үүрэг гүйцэтгүүлэгч) нар нь 2022 оны 8 дугаар сарын 16-ны өдөр байгуулсан байна. Тус гэрээгээр Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаатай холбоотой зардлыг санхүүжүүлэх, Үнэт цаас гаргагч нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг амжилттай арилжсаны дараа тус зардлыг бүртгэж Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид төлж барагдуулахтай холбоотой харилцааг зохицуулсан байх бөгөөд гэрээний агуулга болон заалтууд нь Иргэний хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд харшлаагүй байх тул хуульд нийцсэн гэж дүгнэлээ.

### 3.4. Үнэт цаас гаргагч нь үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч бусад этгээдтэй ашиг сонирхлын зөрчилтэй эсэх талаар

Үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч бусад этгээд гэдэгт дараах этгээдийг хамааруулан авч үзсэн болно. Үүнд:

(i) андеррайтер;
(ii) анхны үүрэг гүйцэтгүүлэгч;
(iii) үйлчилгээ үзүүлэгч;
(iv) хөрөнгө итгэмжлэн удирдагч;
(v) зээлийн шинжилгээ гаргагч аудитор;
(vi) хуулийн фирм.

Ашиг сонирхлын зөрчил байгаа эсэхийг тогтоохын тулд мөн Компанийн тухай хуулийн 89 дүгээр зүйлд заасан нөхцөл байдал үүссэн болон ТЗК, үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч этгээдүүд нь  Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 13.3 болон Банкны тухай хуулийн 3.1.2-т заасан харилцаатай эсэхийг тогтоон шалгах шаардлагатай болсон ба үүнийг дараах байдлаар гүйцэтгэсэн болно:

(i) Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагч болох “Нөмөр кредит ББСБ” ХХК-аас 2022 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн 08/18-тоот албан бичгээр Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 13.3 болон Банкны тухай хуулийн 3.1.2-т заасан холбоотой этгээдийн жагсаалтыг бидэнд ирүүлсэн болно. Уг албан бичигт дурдсан этгээдүүдэд андеррайтер, хөрөнгө итгэмжлэн удирдагч, хөндлөнгийн аудитор болон хуулийн фирм нар нь байхгүй буюу тэдгээр нь холбоотой этгээдүүд биш болно.

(ii) Үнэт цаас гаргагч болон “Нөмөр кредит ассет ББСБ” ХХК-аас андеррайтер, хөрөнгө итгэмжлэн удирдагч, хөндлөнгийн аудитор болон хуулийн фирмтэй санхүүгийн болон санхүүгийн бус нэгдмэл ашиг сонирхолгүй тухайгаа дор дурдсан албан бичгээр бидэнд ирүүлсэн болно. Үүнд:
- “Нөмөр кредит ассет” ХХК-ийн 2022 оны 5 дугаар сарын 05-ны өдрийн 09 тоот Баталгаа гаргах тухай албан бичиг;
- “Нөмөр кредит ББСБ” ХХК-ийн 2022 оны 5 дугаар сарын 05-ны өдрийн 05/05 тоот албан бичиг.

(iii) Үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч этгээдүүд нь Үнэт цаас гаргагчтай санхүүгийн болон санхүүгийн бус нэгдмэл ашиг сонирхолгүй тухай дор дурдсан албан бичгийг бидэнд ирүүлсэн. Үүнд:
- “Юнайтед Айр Файнэнс” ХХК-ийн 2022 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 05-07 тоот албан бичиг;
- “Мүүрь Аудит” ХХК-ийн 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн В-118/22 тоот албан бичиг;

- “Голомт Капитал ҮЦК” ХХК-ийн 2022 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 22/186 тоот албан бичиг;
- Өмгөөллийн “ХаанЛекс Партнерс” ХХН-ийн 2022 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн Б/22/315 тоот албан бичиг.

Дээрхээс дүгнэвэл үйлчилгээ үзүүлэгч этгээдээс бусад хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч этгээдүүдийн хооронд ашиг сонирхлын зөрчил үүсээгүй байна.

Үйлчилгээ үзүүлэгч этгээд болох “Нөмөр кредит ББСБ” ХХК нь Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч байх тул хуульд заасны дагуу холбогдох этгээдүүд байх боловч Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 19.8-д заасны дагуу анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь үйлчилгээ үзүүлэгчийн үүргийг гүйцэтгэж болохоор байна.

3.5. Үнэт цаасны танилцуулга, түүнд тусгагдсан мэдээлэл нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, бусад холбогдох хууль журамд нийцэж буй эсэх, үнэн зөв, хүчин төгөлдөр эсэх

Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны танилцуулга нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.5, СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 2.9, МХБ-ийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 4 дүгээр зүйлд заасан шаардлагыг тус тус хангасан байх ёстой. Үнэт цаас гаргагчийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны танилцуулга нь нийт 11 бүлгээс бүрдэх бөгөөд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны танилцуулгад заавал тусгах суурь мэдээллийг бүрэн багтаасан байх тул холбогдох хууль журамд нийцэж байна гэж үзэж болохоор байна.

Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан мэдээллийн үнэн зөвийг оролцогч этгээдүүдийн үүсгэн байгуулах болон бусад холбогдох баримт бичигтэй тулган шалгах, оролцогч этгээдүүд болон төрийн эрх бүхий байгууллагаас тодруулга, лавлагаа авах замаар шалгахад түүнд тусгагдсан мэдээллүүд нь тухайн баримт бичигтэй нийцэж байх тул үнэт цаасны танилцуулга, түүнд тусгагдсан мэдээллийг үнэн зөв, хүчин төгөлдөр гэж дүгнэж байна. Дэлгэрэнгүй хууль зүйн шинжилгээ, дүгнэлтийг Хавсралт № 1-ээс үзнэ үү.

Түүнчлэн үнэт цаасны танилцуулгад тусгагдсан ТЗК болон "Нөмөр кредит ББСБ" ХХК-ийн эрх бүхий албан тушаалтнуудын талаарх мэдээлэл үнэн зөв бөгөөд хуульд нийцсэн эсэх тухай хууль зүйн шинжилгээ, дүгнэлтийг Хавсралт № 2-оос үзнэ үү.

Дүгнэлт гаргасан:

..............................
Гомбосүрэнгийн Батжаргал
Хуульч, нөхөрлөлийн гишүүн

..............................
Идэрхангайн Учралбаяр
Гүйцэтгэх захирал, хуульч, нөхөрлөлийн гишүүн

2022 оны 08 дугаар сарын 25-ны өдөр

22

MOORE

# ТОХИРОЛЦСОН ГОРИМООР ГҮЙЦЭТГЭСЭН ГЭРЭЭТ АЖЛЫН ТАЙЛАН

НӨМӨР КРЕДИТ АССЕТ ХХК-ИЙН ЗАХИАЛГААР ЗЭЭЛИЙН БАГЦЫН МЭДЭЭЛЭЛД ГҮЙЦЭТГЭСЭН ГОРИМ

2022 оны 4-р сарын 30-ны өдрөөр тасалбар болгосон



Улаанбаатар 2022

**АГУУЛГА**


| | |
|---|---|
| ГЭРЭЭТ АЖЛЫН ТАЙЛАН | 1-2 |
| ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУРААНГУЙ | 3 |
| ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД БОЛОН ТОХИРОЛЦСОН ГОРИМУУД | 3-6 |
| ГҮЙЦЭТГЭСЭН ГОРИМУУДЫН ҮР ДҮН | 7-8 |
| ХАВСРАЛТ-1 | 9-12 |
| ХАВСРАЛТ-2 | 13 |

MOORE

Мүүрэ Аудит ХХК
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
1-р хороо Олимпийн гудамж 7/3,
Центрум тев 7 давхар, 701 тоот
Утас : +976 7015 0003
Факс: +976 7015 0003
И-мэйл: info@moore-mongolia.mn
www.moore-mongolia.mn

# ТОХИРОЛЦСОН ГОРИМООР ГҮЙЦЭТГЭСЭН ГЭРЭЭТ АЖЛЫН ТАЙЛАН

## НӨМӨР КРЕДИТ АССЕТ ХХК-ИЙН УДИРДЛАГАД

Бид Нөмөр Кредит Ассет ХХК-ийн (цаашид Компани гэх) Хөрөнгөөр Баталгаажсан Үнэт Цаас гаргахтай холбоотой 2022 оны 04 дүгээр сарын 30-ны өдрөөр тасалбар болгосон автомашины зээлийн багц бүтээгдэхүүний мэдээлэлд энэхүү тайлангийн 2.2-р хэсэгт заасан шалгуур үзүүлэлтүүдийг хангаж байгаа эсэхэд тохиролцсон горимуудыг хийж гүйцэтгэлээ.

Бид гэрээт ажлыг Холбогдох Үйлчилгээний Олон Улсын Стандарт 4400 (ХҮОУС)-ын дагуу гүйцэтгэж дууслаа. Бид Нягтлан бодогчдын Ёс зүйн олон улсын стандартын зөвлөл (НБЁЗОУСЗ)-өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол улсын Аудитын тухай хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагын дагуу компаниас хараат бус бөгөөд хууль болон НБЁЗОУСЗ-өөс гаргасан дүрмийн шаардлагын дагуу тавигддаг ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн.

**Баримтаар олж илрүүлсэн зүйлсийн үр дүн**

Автомашины зээлийн хувьд түүвэрт сонгогдсон нийт 3,432,247 мянган төгрөгийн үлдэгдэл бүхий 169 зээлийг Компанийн ирүүлсэн шалгуур үзүүлэлтүүдийг хангасан эсэхэд тохиролцсон горимуудыг гүйцэтгэхэд тус зээлүүд нь шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангасан байна.

Энэхүү тайлангийн 2.2 -т заасан горимууд нь Аудитын Олон Улсын Стандарт, эсвэл Нягтлах Гэрээт Ажлын Олон Улсын Стандартын дагуу хийгдэх аудит, нягтлах гэрээт ажил биш учир бид эдгээр зээлд ямар нэг баталгаа гаргаж, дүгнэлт илэрхийлэхгүй.

1-13



Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital

УЛААНБААТАР ХОТ
НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЗК ХХК
9022080593
6862705

СЭХ
2022 он сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022 -06- 20
БҮРТГЭВ-03

Хэрэв бид нэмэлт горимуудыг гүйцэтгэсэн, эсвэл Аудитын Олон Улсын Стандарт болон Нягтлах Гэрээт Ажлын Олон улсын Стандартын дагуу зээлд аудит эсвэл нягтлах ажил хийсэн бол та бүхэнд тайлагнахуйц бусад асуудлууд бидний анхаарлыг ертөж болох байсан гэдгийг үгүйсгэх мэдэгдэж байна.

Бидний бэлтгэсэн тайлан нь зөвхөн энэ тайлангийн эхний хэсэгт заасан зорилгын дагуу уг тайланг бэлтгэсэн ба та бүхэнд мэдээлэл өгөхөд чиглэсэн бөгөөд өөр зориулалтаар ашиглахгүй. Энэхүү тайлан нь зөвхөн Компанийн ирүүлсэн автомашины зээлийн багцын мэдээлэлд хамааралтай болно.

Энэхүү тайлан нь тайлангийн тодруулга болон хавсралт мэдээллийн хамт хүчин төгөлдөр болно.

МЭРГЭЖЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ

Н.МЯГМАРЖАВ

Огноо: 2022.05.27

**Хаяг:** Улаанбаатар хот 14240, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпын гудамж 7/3 байр, Centrum төв, 7 давхар 701 тоот.

Утас: +976 7015 0003, И-мэйл: info@moore-mongolia.mn

MOORE 2-13

Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Улаанбаатар хот



УЛААНБААТАР ХОТ
НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЗК ХХК
9022080503
6862705 СБТ19638

**НӨМӨР КРЕДИТ АССЕТ ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ ТОХИРОЛЦСОН ГОРИМООР ГҮЙЦЭТГЭСЭН ГЭРЭЭТ АЖИЛ ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

## 1. ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУРААНГУЙ

### 1.1. МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖ

Гэрээт ажлыг гүйцэтгэхэд ашигласан зээлийн багцын мэдээлэл болон холбогдох бусад мэдээллийг анхны үүрэг гүйцэтгүүлэгч болох Нөмөр Кредит ББСБ ХХК бэлтгэж өгсөн бөгөөд мэдээллийн үнэн зөв байдал нь Компанийн үүрэг хариуцлага юм. Бид мэдээллийн үнэн зөв байдалд ямар нэг баталгаа гаргахгүй.

### 1.2. ТАЙЛАНГИЙН ХЭРЭГЛЭЭ

Энэхүү тайлан нь Нөмөр Кредит Ассет ХХК-ийн автомашины зээлээр баталгаажсан үнэт цаас гаргахтай холбоотой ажилд зориулагдсан бөгөөд өөр зориулалтаар ашиглахыг хориглоно.

## 2. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД БОЛОН ТОХИРОЛЦСОН ГОРИМУУД

### 2.1. ТҮҮВЭРЛЭЛТ

Бид түүврийн хэмжээг үнийн дүнгийн хувьд эх олонлогийн хамгийн багадаа 30 хувийг хамарч байхаар тооцож автомашины нийт 587 зээлээс 169 ширхэг түүвэр сонгосон. Түүврийг сонгохдоо 130 зээлийг Компаниас ирүүлсэн түүвэрлэлт хийхэд баримтлах зарчмуудыг харгалзан үзэж мэргэжлийн шийдэл ашиглан өндөр дүнтэй болон урт хугацаат зээлүүдээс сонгосон. Үлдсэн 39 автомашины зээлийн түүврийг санамсаргүй сонголтын аргаар түүвэрлэсэн. Компаниас түүвэрлэлт хийхэд баримтлах зарчмуудыг дараах байдлаар тодорхойлж өгсөн бөгөөд бид түүврийг сонгохдоо тус зарчмуудыг мөн харгалзан үзсэн:

MOORE 3-13

Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital

УЛААНБААТАР ХОТ
НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЗК ХХК
9022080593
6862705 СБТ19638

**НӨМӨР КРЕДИТ АССЕТ ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ ТОХИРОЛЦСОН ГОРИМООР ГҮЙЦЭТГЭСЭН ГЭРЭЭТ АЖИЛ ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

## 2. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД БОЛОН ТОХИРОЛЦСОН ГОРИМУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

### 2.1. ТҮҮВЭРЛЭЛТ (ҮРГЭЛЖЛЭЛ)

| № | Компаниас ирүүлсэн түүвэр хийхэд баримтлах зарчимууд | Түүвэрлэлтийн үр дүн |
|---|---|---|
| 1 | Үлдэгдэл өндөртэй зээлийг түүвэрт аль болох ихээр хамруулах | Бид мэргэжлийн үнэлэмжээр 14,500 мянган төгрөгөөс дээш үлдэгдэлтэй зээлийг өндөр үлдэгдэлтэй гэж тодорхойлсон бөгөөд тус дүнгээс дээш үлдэгдэлтэй зээл түүврийн нийт үнийн дүнгийн 89 хувийг эзэлж байгаа учир тус зарчим хангагдсан гэж үзсэн. |
| 2 | Хамгийн урт хугацаатай зээлийг түүвэрт аль болох ихээр хамруулах | Бид мэргэжлийн үнэлэмжээр 24 сар буюу түүнээс дээш хугацаатай зээлийг урт хугацаатай гэж тодорхойлсон. Түүвэрт сонгогдсон урт хугацаат зээл нь түүврийн нийт үнийн дүнгийн 98 хувийг эзэлж байгаа учир тус зарчим хангагдсан гэж үзсэн. |

Зээлийн багцын мэдээлэл болон сонгогдсон түүврийн мэдээлэл дараах байдалтай байна:

| | Эх олонлог | | Түүвэрт сонгогдсон | | |
|---|---|---|---|---|---|
| | Дүн /Мян.төг/ | Тоо | Дүн /Мян.төг/ | Тоо | Эх олонлогт эзлэх % |
| Автомашины зээл | 11,093,854 | 587 | 3,432,247 | 169 | 31% |

4-13



Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Deliver Diversity
Улаанбаатар хот

УЛААНБААТАР ХОТ
НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЭК ХХК
9022080593
6862705 СБТ19638

БҮРТГЭВ
БҮРТГЭВ-03

2022-09-21 өдөр
БҮРТГЭВ

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-09-29
БҮРТГЭВ-03

**НӨМӨР КРЕДИТ АССЕТ ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ ТОХИРОЛЦСОН ГОРИМООР ГҮЙЦЭТГЭСЭН ГЭРЭЭТ АЖИЛ ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

**2.2. ТҮҮВРЭЭР СОНГОГДСОН ЗЭЭЛД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН ТОХИРОЛЦСОН ГОРИМУУД**

Үйлчлүүлэгчээс ирүүлсэн автома шины зээлд тавигдах шалгуур үзүүлэлтүүд болон тохиролцсон горимууд:

| | Компанийн ирүүлсэн шалгуур үзүүлэлтүүд | Тохиролцсон горим | Горимын үр дүн |
|---|---|---|---|
| 1 | СЗХ-нд хүргүүлэх хөрөнгийн мэдээлэл нь зээлийн хувийн хэрэг дэх үндсэн баримттай нийцэж байх | Түүвэрлэсэн 169 зээлийн хувьд зээлийн мэдээллийг зээлийн гэрээ болон зээлийн хувийн хэрэг дэхь бусад баримт бичигтэй нийцэж байгаа эсэхийг шалгасан. | 3.1 -р хэсгээс харна уу |
| 2 | Зээл нь Монгол төгрөгөөр олгогдсон бөгөөд Монгол төгрөгөөр эргэн төлөгдөх зээл байх | Захиалагчийн арилжааны банкан дахь зээл олгож буй дансдын тодорхойлолтыг авч төгрөгийн данс эсэхийг шалгасан. | 3.1 -р хэсгээс харна уу |
| 3 | Зээлийн эргэн төлөлтийн хуваарьт зээлдэгчийн сар бүрийн төлөх дүнг (төлж дуусгах хугацаа) тусгасан байх, зээлийн хугацааны эцэст бүрэн төлөгдөж дуусахаар байх | Түүвэрлэсэн 169 зээлийн хувьд зээлийн график авч, тооцооллыг давтан шалгасан. | 3.1 -р хэсгээс харна уу |
| 4 | Автомашины зээлийн хувьд фидуцийн гэрээний зүйл нь даатгалд даатгагдсан байх, даатгал нь хүчин төгөлдөр байх | Түүвэрлэсэн 169 зээлийн хувьд холбогдох даатгалын гэрээнүүд хийгдсэн бөгөөд хүчин төгөлдөр эсэхийг шалгасан. | 3.1 -р хэсгээс харна уу |
| 5 | Тасалбар болгосон өдрийн байдлаар зээл нь хэвийн төлөлттэй байх | Түүвэрлэсэн 169 зээлийн хувьд эргэн төлөлтийн мэдээллийг авч эргэн төлөлтийн графикийн дагуу төлөгдөж буй эсэхийг шалгасан. | 3.1 -р хэсгээс харна уу |



Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Уламбаатар хот



УЛААНБААТАР ХОТ
НӨМӨР КРЕДИТ
ХХК
9022080593
6862705 СБТ19638

**НӨМӨР КРЕДИТ АССЕТ ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ ТОХИРОЛЦСОН ГОРИМООР ГҮЙЦЭТГЭСЭН ГЭРЭЭТ АЖИЛ ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

**2.2.1 Үйлчлүүлэгчээс ирүүлсэн автомашины зээлд тавигдах шалгуур үзүүлэлтүүд болон тохиролцсон горимууд (Үргэлжлэл)**

| | Компанийн ирүүлсэн шалгуур үзүүлэлтүүд | Тохиролцсон горим | Горимын үр дүн |
|---|---|---|---|
| 6 | Зээлийг холбогдох журмын дагуу үүсгэсэн байх бөгөөд зээлийн стандарт нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн дотооддоо хэрэгжүүлдэг ерөнхий стандартаас дутуугүй шалгуур хангасан байх: | | |
| 6.1 | Тасалбар болгосон өдрөөрх зээл үнэлгээний харьцаа (ЗҮХ) 85%-с хэтрэхгүй байх.<br>ЗҮХ = (Зээлийн үлдэгдэл)/(Үндсэн барьцаа хөрөнгийн худалдаж авч буй үнэ) | Түүвэрлэсэн 169 зээлийн хувьд зээл үнэлгээний харьцааг тооцож тус шалгуур үзүүлэлтийг хангасан эсэхийг тодорхойлсон. | 3.1 -р хэсгээс харна уу |
| 6.2 | Зээл олгосон өдрийн байдлаар зээлдэгч нь Банк, санхүүгийн байгууллагад хугацаа хэтэрсэн, чанаргүй зээлийн өрийн үлдэгдэлгүй байх | Түүвэрлэсэн 169 зээлийн хувьд зээлдэгчийн Монгол банкны зээлийн мэдээллийн сангийн мэдээллийн дагуу хэвийн бус зээлийн үлдэгдэлгүй эсэхийг шалгасан. | 3.1 -р хэсгээс харна уу |

6-13



Гэгээнт Кэпитал ҮЦК ХХК
Golomt Capital
Delivering diversity
Улаанбаатар хот

УЛААНБААТАР ХОТ
НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЗК ХХК
9022080593
6862705 СБТ19638

**НӨМӨР КРЕДИТ АССЕТ ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ ТОХИРОЛЦСОН ГОРИМООР ГҮЙЦЭТГЭСЭН ГЭРЭЭТ АЖИЛ ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

## 3. ГҮЙЦЭТГЭСЭН ГОРИМУУДЫН ҮР ДҮН

### 3.1. АВТОМАШИНЫ ЗЭЭЛД ГҮЙЦЭТГЭСЭН ГОРИМУУДЫН ҮР ДҮН

Компанийн ирүүлсэн шалгуур үзүүлэлтүүдийн дагуу нийт 587 автомашины зээлээс 169 зээлийг түүвэрлэн шалгахад 161 зээл бүх шалгуур үзүүлэлтүүдийг хангасан бол 8 зээл хамгийн багадаа 1 шалгуур үзүүлэлтийг хангаагүй байна. Хангагдаагүй шалгуур үзүүлэлтүүдийг харуулбал:

*Шалгуур 1: СЗХ-нд хүргүүлэх хөрөнгийн мэдээлэл нь зээлийн хувийн хэрэг дэх үндсэн баримттай нийцэж байх*

Автомашины зээлийн шалгуур хангаагүй нийт 8 зээлээс 2 зээлийн СЗХ-нд хүргүүлэх мэдээлэл нь зээлийн хувийн хэрэг дэх мэдээллээс зөрүүтэй байна. Тус зээлүүдийн хувьд зээлдэгчийн овог нэр болон зээлийн хугацааны мэдээлэл зөрүүтэй байсан бөгөөд зээлийн багцаас хассан.

*Шалгуур 6: Зээлийг холбогдох журмын дагуу үүсгэсэн байх бөгөөд зээлийн стандарт нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн дотооддоо хэрэгжүүлдэг ерөнхий стандартаас дутуугүй шалгуур хангасан байх:*

- *Тасалбар болгосон өдрөөрх зээл үнэлгээний харьцаа (ЗҮХ) 85%-с хэтрэхгүй байх.*
- *Зээл олгосон өдрийн байдлаар зээлдэгч нь Банк, санхүүгийн байгууллагад хугацаа хэтэрсэн, чанаргүй зээлийн өрийн үлдэгдэлгүй байх*

Автомашины зээлийн шалгуур хангаагүй нийт 8 зээлээс 6 зээл нь тус шалгуур үзүүлэлтийг хангаагүй байна. Үүнээс 4 зээлдэгч нь зээл олгосон өдрийн байдлаар Монгол Банкны зээлийн мэдээллийн санд хэвийн бус зээлийн үлдэгдэлтэй байсан. 2 зээлийн хувьд зээл үнэлгээний харьцааг тооцоход шаардлагатай барьцаа хөрөнгийн зах зээлийн мэдээлэл хангалттай, зохистой биш байсан тул тус харьцаа үзүүлэлтийг тооцох боломжгүй байсан. Бид эдгээр зээлүүдийг зээлийн багцаас хассан.

*Автомашины зээлийн түүвэрт гүйцэтгэсэн горимуудын үр дүнг зээл тус бүрээр хавсралт 1-с харна уу.*

MOORE 7-13

**НӨМӨР КРЕДИТ АССЕТ ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ ТОХИРОЛЦСОН ГОРИМООР ГҮЙЦЭТГЭСЭН ГЭРЭЭТ АЖИЛ ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

**3.2. ЗЭЭЛИЙН БАГЦЫН МЭДЭЭЛЭЛД ГҮЙЦЭТГЭСЭН НЭМЭЛТ ГОРИМ**

Автомашины зээлийн шалгуур үзүүлэлт хангаагүй 180,355 мянган төгрөгийн үлдэгдэлтэй 8 зээлийг бид тус зээлийн багцад ороогүй нэмэлт 108,746 мянган төгрөгийн үлдэгдэлтэй 8 зээлээр сольж 2.2-д тохиролцсон горимуудыг гүйцэтгэхэд Компанийн ирүүлсэн бүх шалгуур үзүүлэлтүүдийг хангасан байна.

Шалгуур хангаагүй зээлүүдийг нийт зээлийн багцаас хасаж, нэмэлт зээл оруулсантай холбоотой нийт зээлийн багц дараах байдлаар өөрчлөгдсөн:

| | Анхны зээлийн багц | | Шинэчлэгдсэн багц | | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|---|
| | Дүн /Мян.төг/ | Тоо | Дүн /Мян.төг/ | Тоо | Дүн /Мян.төг/ | % |
| Автомашины зээл | 11,093,854 | 587 | 11,022,245 | 587 | 71,609 | 0.65% |

Дээрх сольсон зээлүүдтэй холбоотойгоор нийт зээлийн багц мэдэгдэхүйц өөрчлөгдөөгүй учир 2.1-д заасан Компанийн түүвэрлэлт хийхэд баримтлах зарчим алдагдах нөхцөл үүсээгүй.

*Нэмэлт зээлийн түүвэрт гүйцэтгэсэн горимуудын үр дүнг зээл тус бүрээр хавсралт 2-с харна уу.*

8-13

**Хавсралт-1**

**Тохиролцсон горимын үр дүн – Автомашины зээл**

Тэмдэгтийн тайлбар:

✓ - Шалгуур үзүүлэлтийг хангасан

× - Шалгуур үзүүлэлтийг хангаагүй

Доорх шалгуур үзүүлэлтүүд нь энэхүү тайлангийн 2.2.1-р хэсэгт дурдсан захиалагч талаас ирүүлсэн шалгуур үзүүлэлтүүд бөгөөд холбогдох горимуудын үр дүнг 3.1-р хэсэгт нэгтгэн харуулсан болно.

| № | Гэрээний дугаар | Шалгуур үзүүлэлтүүд | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 1 | ЗГ-22/847 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 2 | ЗГ-22/832 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 3 | ЗГ-22/845 | × | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 4 | ЗГ-21/676 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 5 | ЗГ-22/848 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 6 | ЗГ-21/783 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 7 | ЗГ-22/846 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 8 | ЗГ-22/790 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 9 | ЗГ-22/850 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 10 | ЗГ-21/782 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 11 | ЗГ-21/789 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 12 | ЗГ-22/901 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 13 | ЗГ-21/746 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 14 | ЗГ-22/831 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 15 | ЗГ-22/811 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 16 | ЗГ-21/707 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 17 | ЗГ-22/855 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 18 | ЗГ-22/837 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 19 | ЗГ-22/872 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 20 | ЗГ-21/748 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 21 | ЗГ-22/862 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 22 | ЗГ-22/863 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 23 | ЗГ-21/673 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 24 | ЗГ-21/760 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 25 | ЗГ-22/883 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 26 | ЗГ-21/501 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 27 | ЗГ-21/685 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 28 | ЗГ-22/882 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 29 | ЗГ-22/867 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 30 | ЗГ-22/902 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 31 | ЗГ-22/797 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 32 | ЗГ-21/761 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 33 | ЗГ-22/895 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 34 | ЗГ-21/776 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 35 | ЗГ-22/892 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 36 | ЗГ-21/695 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 37 | ЗГ-22/836 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 38 | ЗГ-22/830 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 39 | ЗГ-22/835 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 40 | ЗГ-21/436 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 41 | ЗГ-22/822 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |

СЭХ
БҮРТГЭВ
№ 01

УЛААНБААТАР ХОТ
НОМОР КРЕДИТ АССЕТ ТЗК ХХК
9022080593
6862705 СБТ19638

numur
20?? он ?? сар ?? өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022-09-29
БҮРТГЭВ-03

| № | Гэрээний дугаар | Шалгуур үзүүлэлтүүд | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 42 | ЗГ-21/696 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 43 | ЗГ-21/448 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 44 | ЗГ-21/620 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 45 | ЗГ-22/799 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 46 | ЗГ-21/395 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 47 | ЗГ-21/686 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 48 | ЗГ-21/373 | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 1 | Жунаууз овогтой Баатарсүрэн-а Гүйцэтгэх захирал-р томилсныг бүртгэв. | 2017 05.03 | Э.Эрдэнэбилэг |
| 2 | Дахин гэрчилгээ олгов. | 2017.06.09 | С.Мөнхсанчир |
| 1 | Өөрийн хөрөнгийн хэмжээ 200000 мян.төг-р нэмэгдэж нийт 1000000 мян төг болсон өөрчлөлтийг бүртгэв. | 2018.04.18 | С.Мөнхсанчир |
| 2 | Хувь нийлүүлэгчээс 1 нэмэгдэж үүсгэн байгуулагчийн тоо нийт 2 болж өөрчлөгдсөнийг бүртгэв. | 2018.04.18 | С.Мөнхсанчир |
| 3 | Улаанбаатар, Баянгол, 2-р хороо, 2-р хороолол, энхтайваны өргөн чөлөө, . Гранд плаза цогцолбор 8-801 тоот. Утас1 99114745, Утас2 , Факс хаягийг шинээр бүртгэв. | 2018.04.18 | С.Мөнхсанчир |
| 4 | 'Сонгинохайрхан дүүрэг дэх салбар' Улаанбаатар, Сонгинохайрхан, 32-р хороо, , , , Автоцогцолбор худалдааны төв байрлах салбар нэгжийг бүртгэв. | 2018.10.15 | Д.Гангаморен |
| 5 | Өөрийн хөрөнгийн хэмжээ 400000 мян.төг-р нэмэгдэж нийт 1400000 мян.төг болсон өөрчлөлтийг бүртгэв. | 2019.02.18 | Ж.Нямдорж |
| 6 | Өөрийн хөрөнгийн хэмжээ 500000 мян.төг-р нэмэгдэж нийт 1900000 мян.төг болсон өөрчлөлтийг бүртгэв. | 2019.08.08 | С.Цолмон |
| 7 | Хувь нийлүүлэгчээс 1 нэмэгдэж, 0 хасагдаж үүсгэн байгуулагчийн тоо нийт 3 болж өөрчлөгдсөнийг бүртгэв. | 2019.08.08 | С.Цолмон |
| 8 | Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 600000 мян.төг-р нэмэгдэж нийт 2500000 мян.төг болсон өөрчлөлтийг бүртгэв. | 2019 11.28 | Г.Санжаа |
| 9 | Эцсийн өмчлөгч 1 иргэн бүртгэв. | 2020.09 15 | Н.Долгоржав |
| 10 | Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 2000000 мян.төг-р нэмэгдэж нийт 4500000 мян.төг болсон өөрчлөлтийг бүртгэв. | 2020.11.09 | Н.Долгоржав |
| 11 | Хувьцаа эзэмшигч 1 нэмэгдэж 0 хасагдаж хувьцаа эзэмшигчийн тоо **нийт** 4 болж өөрчлөгдсөнийг бүртгэв. | 2020.11.09 | Н.Долгоржав |
| 12 | Эцсийн өмчлөгч 1 иргэн бүртгэв. | 2020.11.10 | Н.Долгоржав |
| 13 | 64300 Итгэлцлийн үйлчилгээ үйл ажиллагаа шинээр бүртгэв. | 2020.12.04 | Г.Санжаа |
| 14 | Хувьцаа эзэмшигч 3 нэмэгдэж эзэмшигчийн тоо нийт 7 болж өөрчлөгдсөнийг бүртгэв. | 2021.06.11 | Э.Батчир |
| 15 | Улаанбаатар, Хан-Уул, 2-р хороо, үйлдвэр 2-3, 59 тоот-д байрлах салбар нэгжийг бүртгэв. | 2021.06.16 | Э.Батчир |
| 16 | Улаанбаатар, Сүхбаатар, 4-р хороо, 1 40 мянгат, 44-р байр, 34 тоот Утас1: 95953454, Утас2: , Факс: хаягийг шинээр бүртгэв | 2021.06.23 | Г.Батмөнх |
| 17 | Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 2000000 мян.төг-р нэмэгдэж нийт 6500000 мян.төг болсон өөрчлөлтийг бүртгэв. | 2021.12.14 | Ш.Очирсүрэн |
| 24 | Улаанбаатар, Баянгол, 2-р хороо, 2-р хороолол, энхтайваны өргөн чөлөө, Гранд плаза цогцолбор 8-801 Утас1: 99192208, Утас2: 95953454, Факс: хаягийг шинээр бүртгэв. | 2022.02.14 | Г.Санжаа |
| 25 | Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 4000000 мян.төг-р нэмэгдэж нийт 10500000 мян.төг болсон өөрчлөлтийг бүртгэв. | 2022.02.14 | Г.Санжаа |
| 26 | Хувьцаа эзэмшигч 1 нэмэгдэж хувьцаа эзэмшигчийн тоо нийт 8 болж өөрчлөгдсөнийг бүртгэв. | 2022.02.14 | Г.Санжаа |
| 27 | Эцсийн өмчлөгч бүртгэв. | 2022.02.14 | Г.Санжаа |

*0001448 26*

Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
11193011 · 5461539
Улаанбаатар хот

УЛААНБААТАР ХОТ
НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЗК
ХХК
9022080593
6862705 СБТ19638

numur

Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 1 сарын 13-ны өдрийн НКХЭШ22/01 тоот шийдвэрийн 1 дүгээр хавсралтаар батлав.

**НӨМӨР КРЕДИТ ББСБ ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН ДҮРЭМ**

**Нэг.Нийтлэг үндэслэл**

1.1. "НӨМӨР КРЕДИТ ББСБ" ХХК-ийн /цаашид компани гэх/ энэхүү дүрэм нь Монгол улсын Компанийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулах компанийн эрх зүйн үндсэн баримт бичиг мөн.

1.2. Компанийн оноосон нэр /монголоор/
   а) Бүрэн нэр **НӨМӨР КРЕДИТ ББСБ ХХК** /цаашид энэхүү дүрэмд "Компани" гэх/
   б) Товчилсон нэр **НӨМӨР КРЕДИТ ББСБ ХХК**
   в) Англиар **NUMUR CREDIT NBFI** гэж нэрлэнэ.

1.3. Компанийн оршин байгаа газар:
- Улсын нэр: Монгол Улс,
- Аймаг, нийслэлийн нэр: Улаанбаатар хот,
- Сум, дүүргийн нэр: Баянгол дүүрэг,
- Баг, хороо, хорооллын нэр: 2-р хороо, 2-р хороолол
- Гудамж, өргөн чөлөө, тойрог, талбайн нэр: /16051/ Энхтайваны өргөн чөлөө
- Хашаа, байшин, хаалганы дугаар: 46-р байр Гранд плаза цогцолбор 8 - 801 тоот,
- Шуудангийн хаяг: Улаанбаатар
- Шуудангийн хайрцагны дугаар
- Харилцах утасны дугаар: 99192208, 95953454
- И-мэйл хаяг: sales@numurcredit.mn

1.4. Компанийн үүсгэн байгуулагч, Хувьцаа эзэмшигчид:

| № | Овог нэр | Регистр № | Гэрийн хаяг | Утас |
|---|---|---|---|---|
| 1. | Баатарсүрэн овогтой Гантулга | ОЭ87082911 | УБ хот, ХУД, 15-р хороо, жаргалан хотхон 2-12 тоот | 99192208 |
| 2. | Новатек интернэшнл ХХК | 9011050091 2715376 | УБ хот, СХД 17-р хороо, 1-р хороолол, өнөр хороолол 32-228 тоот | 75118999 |
| 3. | Эрчим электрик ХХК | 9011166114 5254841 | УБ хот, БГД 2-р хороо, 2-р хороолол ЭТӨЧ-46, Гранд плаза 14-1406 тоот | 75100008 |
| 4. | Юнайтэдлартс ХХК | 9011356124 5619106 | УБ хот, СБД, 19-р хороо, Сансар, 13-174 тоот | 75112255 |
| 5. | Болдбаатар овогтой Болортуяа | ЕА90041801 | Дорноговь, Сайншанд 4-р баг, 26 байр 1 тоот | 95953454 |
| 6. | Бат-Эрэнэ овогтой Эрэнэбилэг | ФБ91070317 | УБ хот, Баянзүрх дүүрэг 25-р хороо, 56-р байр, 1-10 | 88029070 |
| 7. | Амарсайхан овогтой Энхжин | УХ90070458 | УБ хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо бага тойруу гудамж 18 байр, 14 тоот | 94010751 |
| 8 | Кемекс ХХК | 9011078126 2659352 | Улаанбаатар, Сонгинохайрхан, 12-р хороо, 1-р хороолол, Москвагийн гудамж-37, 1-р үйлчилгээний төв. | 75112288 |

1.5. "Нөмөр кредит ББСБ" ХХКомпани нь /цаашид "компани" гэх/ Монгол Улсын Компанийн тухай хуулийн дагуу зохион байгуулагдсан, бие даасан тайлан тэнцэлтэй, банкинд харилцах данстай, өөрийн нэрийн өмнөөс эрх эдлэн, үүрэг хүлээх хуулийн этгээд, хувьцаа эзэмшигчдийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж түүнийг захиран зарцуулах эрх нь дүрмээр хязгаарлагдах хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэрээр ажиллана.

1.6 Компани нь орлого ашигаа арвижуулах замаар хувьцаа эзэмшигчдийн эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэх явдлыг үндсэн зорилгоо болгон Банк бус санхүүгийн үйл ажиллагааг эрхэлнэ.
   1.6.1. Зээлийн үйл ажиллагаа
   1.6.2. Итгэлцлийн үйлчилгээ

1

numur

1.7. Компани үйл ажиллагаагаа хугацаагүй явуулна. Компани нь Монгол Улсад болон гадаад улсад өөрийн салбар, төлөөлөгчийн газартай байж болно. Компанийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу салбар, төлөөлөгчийн газраа байгуулан, бүртгэх байгууллагад бүртгүүлж, үйл ажиллагаагаа явуулна.

1.7.1. Салбар нэгжийн дотоод хяналтын үйл ажиллагааг "ДОТООД ХЯНАЛТ, САЛБАР НЭГЖИД ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ"-д заасны дагуу зохицуулна.

1.8. Компани тодорхой мэргэжил тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагааг хуульд заасны дагуу холбогдох эрх бүхий байгууллагаас зөвшөөрлийг бичгээр авч, энэхүү дүрэмдээ өөрчлөлт оруулан бүртгэх байгууллагад бүртгүүлнэ.

1.9. Компани нь үүсгэн байгуулах баримт бичигт болон улсын бүртгэлийн жагсаалтад агуулагдаж байгаа бусад мэдээлэлд оруулсан өөрчлөлтүүдээ хуульд заасан хугацаанд бүртгэх байгууллагад бүртгүүлнэ.

**Хоёр. Компанийн эрх**

2.1. Компанийн иргэний эрх зүйн чадвар нь улсын бүртгэлд бүртгүүлснээр үүснэ.
2.2. Компани нь өөрийн бэлгэдэл /эмблем/, албан бичгийн хэвлэмэл хуудас, өөрийн нэр бүхий тэмдэг хэрэглэнэ.
2.3. Компани нь Компанийн тухай хуулийн 6.1-6.8 дахь хэсэгт заасны дагуу хараат болон охин компани байгуулж болох бөгөөд үүнийгээ бүртгэх байгууллагад бүртгүүлнэ.
2.4. Компани нь үйл ажиллагаагаа бие даасан байдлаар болон бусад хуулийн этгээдтэй хамтран Монгол Улсын хуулийн хүрээнд эрхлэн явуулна.
2.5. Компани нь дүрмэндээ нэмэлт өөрчлөлт оруулж болно.
2.6. Компани нь үндсэн болон туслах үйл ажиллагаагаа хэвийн явуулах зорилгоор мэргэжил, ур чадвар, дадлага туршлагатай хүмүүсийг хөдөлмөрийн гэрээгээр авч ажиллуулах, тэдний ажиллах нөхцөл цалин хөлс, урамшууллын хэмжээг тогтооно.

**Гурав. Компанийн үүрэг**

3.1. Компани нь энэхүү дүрмийн 1.6-д заасан үйл ажиллагааг Монгол улсын хуульд заасны дагуу эрхлэнэ.
3.2. Компани нь Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Аудитын тухай хууль болон Компанийн тухай хуулийн 96 дугаар зүйлд заасны дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөн, санхүүгийн тайлан гаргана.
3.3. Компани нь Монгол Улсын албан татварын хуулийн дагуу орлого, татвараа өөрөө тодорхойлж, албан татвараа сайн дураар төлнө.
3.4. Компани нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шаардлагатай мэдээ, мэдээллийг тухай бүр эрх бүхий байгууллагуудад гаргаж өгнө.
3.5. Компани нь хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсадын өмнө хуулиар өгөгдсөн үүргүүдийг биелүүлнэ.
3.6. Компани нь энгийн хувьцааг заавал гаргах үүрэг хүлээнэ.
3.7. Компани нь хувьцаа эзэмшигчийн шаардлагаар компанийн дүрэм, түүнд орсон нэмэлт, өөрчлөлтийг түүнд танилцуулах үүрэгтэй.
3.8. Компанийн дүрэмд оруулсан нэмэлт өөрчлөлт, шинэчлэн найруулсан дүрэм нь улсын бүртгэлтийн газар бүртгүүлснээр хүчин төгөлдөр болно.
3.9. Компани нь хувьцаагаа нэгтгэх, хуваахдаа түүнийг худалдан авах эрхийн бичиг болон түүнд хөрвөх үнэт цаасны бүрдүүлбэрт зохих өөрчлөлт оруулах үүргийг хүлээнэ.
3.10. Компани нь ногдол ашиг аваагүй хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг түүнд төлөх өр болгон нягтлан бодох бүртгэлд хувьцаа эзэмшигчийн нэрээр тусгайлан бүртгэнэ.
3.11. Хувьцаагаа худалдахаар санал болгож байгаа хувьцаа эзэмшигч нь уг саналаа компанид мэдэгдэх бөгөөд энэ тухай компани нь бусад хувьцаа эзэмшигчид бичгээр мэдэгдэнэ.
3.12. Компанийн тухай хуулийн 84.1, 84.2 дахь хэсэгт заасны дагуу ТУЗ-ийн гишүүд, нарийн бичгийн дарга,Гүйцэтгэх захирал, Санхүүгийн менежер, Нягтлан бодогч, Менежер-г компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно.
3.13. Компани нь Компанийн тухай хуулийн 97 дугаар зүйлд заасан баримт бичгийг хадгалах, байнга хадгалах, хувьцаа эзэмшигчийн шаардлагаар танилцуулах, тэдгээрийг архивт шилжүүлнэ.

**Дөрөв. Компанийн хариуцлага**

4.1. Компани нь Компанийн тухай хуулийн 9.1 дэх хэсэгт заасан хариуцлага хүлээнэ.



СЭХ numur ... өдөр БҮРТГЭВ №01

2022-09-29 БҮРТГЭВ-03

Голомт Капитал ҮЦК ХХК Golomt Capital

УЛААНБААТАР ХОТ НОМОР КРЕДИТ АССЕТ ТЗК ХХК 9022080593 6862705 СБТ19638

numur

4.2. Компани нь хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсадын эрхийг зөрчсөн тохиолдолд холбогдох хуульд заасан хариуцлага хүлээнэ.
4.3. Компани нь улсын бүртгэлд бүртгүүлэхээс өмнө иргэний эрх зүйн харилцаанд бие даан оролцохыг хориглоно. Энэхүү заалтыг зөрчсөний улмаас бусдад гэм хор учруулсан бол буруутай этгээд гэм хорыг арилгана.
4.4. Компани нь Монгол Улсын хуульд заасан бусад хариуцлагыг хүлээнэ.

**Тав. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө, хувьцаа, үнэт цаас**

5.1. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг Компанийн тухай хуулийн 30.1 дэх хэсэгт зааснаар тодорхойлно.
5.2. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь 10,500,000,000 ₮ /арван тэрбум таван зуун сая/ төгрөгийн мөнгөн хөрөнгөөс бүрдэнэ.
5.3. Компанийн хувь нийлүүсэн хөрөнгөнд оруулах аливаа хөрөнгө нь зөвхөн Монгол төгрөгөөр илэрхийлэгдэнэ.
5.4. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь нэг бүр нь 10,000 ₮ /арван мянга/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 1,050,000 /нэг сая таван зуун мянга/ ширхэг энгийн хувьцаа байна. Хувьцааг нэрлэсэн үнээс доогуур үнэтэй бүртгэх, нэрлэсэн үнээс доогуур үнэтэй хувьцаа гаргахыг хориглоно.
5.4.1. Хувьцаа эзэмшигчид дараах байдлаар хувьцааг эзэмшинэ.

| № | Хувьцаа эзэмшигчид | Хувьцааны тоо | Үнэ | Хувьцаа эзэмшлийн хувь |
|---|---|---|---|---|
| 1. | Б.Гантулга | 110,000 | 1,100,000,000 | 10,48% |
| 2. | Новатек интернэшнл ХХК | 145,000 | 1,450,000,000 | 13,81% |
| 3. | Эрчим электрик ХХК | 25,000 | 250,000,000 | 2,38% |
| 4. | Юнайтэд партс ХХК | 356,500 | 3,565,000,000 | 33,95% |
| 5. | Б.Болортуяа | 4,500 | 45,000,000 | 0,43% |
| 6. | Б.Эрэнэбилэг | 4,500 | 45,000,000 | 0,43% |
| 7. | А.Энхжин | 4,500 | 45,000,000 | 0,43% |
| 8 | Кемекс ХХК | 400,000 | 4,000,000,000 | 38,09% |
| | **Нийт** | **1,050,000** | **10,500,000,000** | **100%** |

5.5. Компанийн өөрийн хөрөнгийн хэмжээг Компанийн тухай хуулийн 30.2 дахь хэсэгт зааснаар тодорхойлно.
5.6. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь компанийн өөрийн хөрөнгийн хэмжээнээс илүүгүй байна.
5.7. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөхдөө Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасныг баримтлана.
5.8. Компанийн хувьцаа, компанийн зарласан болон гаргасан хувьцаатай холбоотой асуудлыг Компанийн тухай хуулийн 32, 33 дугаар зүйлд зааснаар шийдвэрлэнэ.
5.9. Компани нь хувьцаа эзэмшигчдийн хүлээх үүргийг хариуцахгүй. Хувьцаа эзэмшигч нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү эзэмшиж байгаа хувьцааны хэмжээгээр хариуцлага хүлээнэ.

**Зургаа. Компанийн удирдлага, хяналт**

6.1. Компанийн эрх барих дээд байгууллага нь Компанийн тухай хуулийн 59.1 дэх хэсэгт зааснаар хувьцаа эзэмшигчдийн хурал болно.
6.2. Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл байна.
6.3. Төлөөлөн Удирдах Зөвлөл нь энэхүү дүрэм болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааны журамд заасан эрх, үүргийг хэрэгжүүлнэ.
6.4. Компани нь Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс тогтоосон бүтцийн дагуу алба, хэлтэс, нэгжид хуваагдаж үйл ажиллагаагаа явуулна. Батлагдсан бүтцийн дагуу компанийн өдөр тутмын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж, компанийн дотоод дүрэм, журамд нийцүүлэн явуулах үүргийг Гүйцэтгэх захирал хүлээнэ.
6.5. Компани нь шаардлагатай тохиолдолд ТУЗ-ийн шийдвэрээр томилогдсон дотоод аудиттай байж болно. Дотоод аудит нь Гүйцэтгэх захирал болон компанийн ажилчдын үйл ажиллагаанд хяналт тавьж буй ТУЗ-ийн хяналтын нэг хэлбэр болно. Дотоод аудитын шаардсан баримт бичиг, мэдээллийг Гүйцэтгэх захирал болон бусад компанийн ажилчид нэн даруй гаргаж өгөх бөгөөд дотоод аудит нь тавьсан шалгалтын тайланг ТУЗ-д тайлагнана.

3

numur

6.6. Аудитын тухай хуульд заасны дагуу Компани нь санхүүгийн тайланг шалгуулж баталгаажуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийлгэх зорилгоор хөндлөнгийн аудитын байгууллагыг ТУЗ сонгож, түүнтэй гэрээ байгуулж ажиллуулна.
6.7. Компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийх аудитын байгууллагын шалгалт нь ээлжит ба ээлжит бус байна.
6.8. Компанийн жилийн санхүүгийн тайланг баталгаажуулахын тулд хийсэн аудитын байгууллагын шалгалт нь ээлжит байна.
6.9. Аудитын байгууллагын шалгалтын хөлсийг Компанийн тухай хуулийн 94.8 дахь хэсэгт заасны дагуу компани төлнө.
6.10. Компани нь санхүүгийн тайлангаа эрх бүхий этгээдэд танилцуулна.
6.11. Компанийн санхүүгийн жил 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхэлж, 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болно.
6.12. Компани нь компанийн санхүүгийн тайланд компанийн тухай хуулийн 96.1 дэх хэсэгт заасан зүйлийг тусгана.
6.13. Компани нь Компанийн тухай хуулийн 97 дугаар зүйлд заасан баримт бичгийг хадгалах, байнга хадгалах эрх бүхий этгээдийн шаардлагаар танилцуулах, хуульд заасан хугацаа дууссаны дараа архивт шилжүүлнэ.

**Долоо. Хувьцаа эзэмшигчдийн хурал**

7.1. Компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байна.
7.2. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь ээлжит ба ээлжит бус байна. Ээлжит хурлыг ТУЗ нь Компанийн тухай хуульд заасан хугацаанд буюу санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор жилд нэг удаа зарлан хуралдуулна.
7.3. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит ба ээлжит бус хурал, хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах шийдвэр гаргах, хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрх, хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр хүчин төгөлдөр болох, хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрх, хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг хүргэх, хувьцаа эзэмшигчдийн хурлын хэлэлцэх асуудалд санал оруулах, хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комисс, хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох журам, хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц, хувьцаа эзэмшигчдийн хурал хүчин төгөлдөр болох, хувьцаа эзэмшигчдийн хурал, түүний шийдвэрийн талаар гомдол гаргах, саналын хуудас, саналын хуудсыг хүчинтэйд тооцох, эчнээ санал хураалтаар компанийн хувьцаа эзэмшигчид шийдвэр гаргах, хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэлтэй холбоотой асуудлыг Компанийн тухай хуулийн 59-74 дүгээр зүйлд заасанаар зохицуулна.
7.4. Дараах тохиолдолд ТУЗ хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулна. Үүнд:
   7.4.1. ТУЗ-ийн нийт гишүүдийн 50-аас дээш хувь нь ажиллах боломжгүй буюу ажиллахгүй болсон;
   7.4.2. ТУЗ-ийн хараат бус гишүүн, эсхүл саналын эрх бүхий хувьцааны 10 буюу түүнээ дээш хувийн хувьцаа эзэмшигч санал, шаардлага гаргасан;
   7.4.3. ТУЗ шаардлагатай гэж үзэж шийдвэр гаргасан;
   7.4.4. Компанийн тухай хууль болон энэхүү дүрэмд заасан бусад тохиолдолд.
7.5. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал нь дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх бүрэн эрхтэй. Үүнд:
   7.5.1. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу түүний шинэчилсэн найруулгыг батлах;
   7.5.2. Нийлэх, нэгдэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх хэлбэрээр компанийг өөрчлөх байгуулах;
   7.5.3. Нэмж гаргах хувьцаа, бусад үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг хэрэгжүүлэх эсэх;
   7.5.4. Компанийн үйл ажиллагааны чиглэлийг нэмэх, хасах, өөрчлөн тогтоох;
   7.5.5. Компанийн хэлбэрийг өөрчлөх;
   7.5.6. Компанийг татан буулгах буюу татан буулгах комиссыг томилох;
   7.5.7. Хувьцааг хуваах буюу нэгтгэх;
   7.5.8. ТУЗ-ийн гишүүдийг сонгох, ТУЗ-ийн гишүүн өөрөө хүссэн болон хуульд заасан бусад нөхцөл үүссэнээс бусад тохиолдолд бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;
   7.5.9. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
   7.5.10. Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс энэхүү дүрэм болон Компанийн тухай хуульд заасны дагуу баталж чадаагүй их хэмжээний хэлцлийг хэлэлцэх, батлах;
   7.5.11. Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс энэхүү дүрэм болон Компанийн тухай хуульд заасны дагуу баталж чадаагүй сонирхлын зөрчилтэй хэлцлийг хэлэлцэх, батлах;
   7.5.12. ТУЗ-ийн гишүүд, ТУЗ-ийн нарийн бичгийн даргын цалин урамшууллын хэмжээг тогтоох;
   7.5.13. ТУЗ-ийн шийдвэрээр ХЭХ-аар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн бусад асуудлууд;
   7.5.14. Компанийн тухай хууль болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааны журамд заасан бусад асуудал.

4



УЛААНБААТАР ХОТ
НӨМӨР КРЕДИТ ХХК
9022080593
6862705 СБТ19638

numur

7.6. Дараах асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхийн саналаар батална. Үүнд:
7.6.1. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, дүрмийн шинэчилсэн найруулгын төслийг батлах;
7.6.2. Давуу эрхийн хувьцаа гаргах;
7.6.3. Хувьцааг хуваах буюу нэгтгэх;
7.6.4. Хувьцааг тэргүүн ээлжинд авах эрхийг эдлүүлэхгүй байх эсэх;
7.6.5. Аливаа байдлаар компанийг өөрчлөн байгуулах;
7.6.6. Компанийн өрийг хувьцаагаар солих, нэмж хувьцаа гаргах, түүний тоог тогтоох;
7.6.7. Компанийн хэлбэрийг өөрчлөх
7.6.8. Хууль тогтоомж болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааны журамд заасан бусад.
7.7. ТУЗ-ийн гишүүдийг сонгох асуудлаар хэлэлцэж гаргасан шийдвэр дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэгдэнэ.

## Найм. Төлөөлөн Удирдах Зөвлөл

8.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт Компанийн эрх барих дээд байгууллага нь ТУЗ байна.
8.2. ТУЗ-ийн үйл ажиллагааг "Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааны журам"-аар зохицуулна.
8.3. Компани нь Төлөөлөн Удирдах зөвлөлтэй байна. Гурваас багагүй есөөс ихгүй тооны гишүүдтэй байх бөгөөд ТУЗ-ийн нийт гишүүдийн 1/3 (гуравны нэг) нь хараат бус гишүүн байна.
8.4. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн тоог тухайн жилийн үйл ажиллагаа, төсөв, санхүүжилт, компанийн дотоод засаглалын асуудалтай холбогдуулан Хувьцаа эзэмшигчдийн хурлаар жил бүр тогтоож болно.
8.5. ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа сонгогдсоноос хойш 3 жил байна.
8.6. ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас тогтооно.
8.7. ТУЗ нь Компанийн дүрмээр ХЭХ болон Гүйцэтгэх захиралд олгосноос бусад буюу дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:
8.7.1. Компанийн үйл ажиллагааны чиглэл, стратегийг тодорхойлох, компанийн жил бүрийн бизнес төлөвлөгөөг батлах;
8.7.2. Жилийн тайлан батлах;
8.7.3. Компанийн үнэт цаасыг гаргах;
8.7.4. Компанийн зарласан хувьцааны төрөл болон тоонд багтаан хувьцаа гаргах;
8.7.5. Компанийн үндсэн үйл ажиллагааг санхүүжүүлэх, стратеги, бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор арилжааны эх үүсвэр татан төвлөрүүлэх;
8.7.6. Гүйцэтгэх удирдлагын эрх хэмжээг тогтоох;
8.7.7. Гүйцэтгэх захирлыг томилох, түүнтэй гэрээ байгуулах, түүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх, бүрэн эрхийг хугацаанаас өмнө дуусгавар болгох;
8.7.8. Хөндлөнгийн аудитыг сонгож гэрээ байгуулах;
8.7.9. Компанийн салбар болон төлөөлөгчийн газрыг байгуулах;
8.7.10. Компанийн эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тодорхойлох;
8.7.11. Байгууллагын бүтцийг батлах;
8.7.12. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах;
8.7.13. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдөр болон хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахтай холбогдох бусад асуудлыг шийдвэрлэх;
8.7.14. Өөрийн гаргасан хувьцаа, бусад үнэт цаасыг худалдан авах, эргүүлэн авах;
8.7.15. Их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
8.7.16. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
8.7.17. Эрх бүхий албан тушаалтны компанид учруулсан хохирлыг гаргуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах;
8.7.18. Компанийн дүрэм, хувьцаа эзэмшигчдийн хурлаас эрх олгосон бусад асуудал, түүнчлэн Компанийн тухай хууль, компанийн дүрмээр хувьцаа эзэмшигчдийн хурал, гүйцэтгэх удирдлагын эрхэд хамааруулснаас бусад буюу ТУЗ шийдвэрлэх шаардлагатай гэж үзсэн асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх.
8.8. ТУЗ нь хууль тогтоомжид ТУЗ хэрэгжүүлэхээр зааснаас бусад бүрэн эрхийг Гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээний үндсэн дээр Гүйцэтгэх захиралд шилжүүлж болно.
8.9. ТУЗ-ийн хурлыг хагас жилд нэг удаа ээлжит байдлаар хуралдуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд ТУЗ-ийн дарга, Гүйцэтгэх захирал болон ТУЗ-ийн гишүүдийн нэмэлт саналаар ээлжит бус, эчнээ байдлаар хуралдуулж болно.
8.10. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас тогтоол гарах бөгөөд түүнд ТУЗ-ийн дарга гарын үсэг зурж, компанийн тамгыг дарсанаар хүчин төгөлдөр болно.

5

numur

8.11. ТУЗ-ийн хурлын тогтоол нь тус хуралдааны тэмдэглэлээр баталгаажна. Тэмдэглэлд хуралд оролцсон гишүүд зөвшөөрсөн тохиолдолд гарын үсэг зурна.
8.12. ТУЗ-ийн гишүүнд Компанийн тухай хууль болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан шаардлагуудыг хангасан этгээдийг сонгож ХЭХ-д нэр дэвшүүлнэ.
8.13. ХЭХ-аас Төлөөлөн Удирдах зөвлөлийн гишүүдийг ердийн журмаар нэгж хувьцаанд ногдож буй саналын хэмжээгээр санал өгөх ба олонхийн санал авсан этгээдийг ТУЗ-ийн гишүүнээр сонгоно.
8.14. ТУЗ-ийн даргыг ТУЗ-ийн гишүүд дунд санал хураалт явуулах замаар сонгоно.
8.15. ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг ТУЗ-ийн даргын санал болгосноор ТУЗ-ийн хурлаас томилно.
8.16. ТУЗ-ийн хараат бус гишүүн нь Компанийн тухай хуульд заасан хараат бус гишүүний шаардлагыг хангасан этгээд байна.
8.17. Компанийн ТУЗ нь шаардлагатай гэж үзвэл хороотой байж болно. ТУЗ-ийн хороодын бүрэлдэхүүнийг ТУЗ-ийн шийдвэрээр зохион байгуулна.
8.18. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгосон Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдсанаас хойш 3 жилийн хугацаанд ТУЗ-ийн гишүүний бүрэн эрх хэвээр хадгалагдана.

**Ес. Гүйцэтгэх удирдлага**

9.1. Компанийн гүйцэтгэх удирдлагыг хувь хүн буюу Гүйцэтгэх захирал дангаар хэрэгжүүлнэ.
9.2. Гүйцэтгэх захирал нь Төлөөлөн Удирдах Зөвлөлтэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.
9.3. Компанийн хувьцаа эзэмшигч, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүн нь гүйцэтгэх захирал байж болно.
9.4. Компанийн гүйцэтгэх захирлын бүрэн эрх нь дуусгавар болсон өдрөөс хойш байгуулсан гэрээ, хэлцэл, хүчин төгөлдөр бус байна.
9.5. Компанийн гүйцэтгэх захирал нь компанийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна.
9.6. ТУЗ-өөс зөвшөөрөл олгосон тохиолдолд гүйцэтгэх захирал нь өөр хуулийн этгээдийн удирдлагад давхар ажиллаж болно.
9.7. Гүйцэтгэх захирал нь эрх хэмжээний хүрээнд тушаал гаргаж хэрэгжилтийг хангана. Эрх хэмжээний хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлыг Төлөөлөн Удирдах Зөвлөлд тайлагнана.
9.8. Гүйцэтгэх захирал нь компанийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж, компанийн дүрэм, зохицуулагч байгууллагаас тавьж буй шаардлага, төлөвлөгөө, төсөв болон ТУЗ-өөс олгосон эрх хэмжээ, удирдамж, шийдвэрийн хүрээнд удирдах бөгөөд сар, улирал, жилийн тайлан, шаардлагатай бусад тайланг ТУЗ, ХЭХ болон холбогдох бусад байгууллагад хүргүүлнэ.
9.9. Гүйцэтгэх захирал нь эрх хэмжээнийхээ хүрээнд тушаал гаргаж биелэлтийг хангуулах эрхтэй.

**Арав. Компанийн эрх бүхий албан тушаалтан, түүний хүлээх хариуцлага**

10.1. Компанийн эрх бүхий албан тушаалтан Компанийн тухай хуулийн 84, 85 дугаар зүйлд заасан хариуцлагыг хүлээнэ.
10.2. Эрх бүхий албан тушаалтанд Гүйцэтгэх захирал, Санхүүгийн менежер, Нягтлан бодогч, ТУЗ-ийн гишүүд, ТУЗ-ийн дарга, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга зэрэг албан ёсны шийдвэр гаргах, гэрээ хэлцэл хийхэд оролцдог албан тушаалтан багтана.
10.3. Эрх бүхий албан тушаалтан компанийн дотоод журам, ажил үүргийн хуваарийн дагуу ажиллах ба компанийн ашиг сонирхлын төлөө үнэнч шударгаар ажиллахын зэрэгцээ компанийн эрх ашигт нийцүүлэн шийдвэр гаргах, компанийн ажил үүргийг гүйцэтгэсний төлөө бусдаас шан харамж авахгүй байх үүрэгтэй.
10.4. Эрх бүхий албан тушаалтан компанийн нууц мэдээг гурав дахь этгээдэд дамжуулах, хувийн ашиг сонирхлын төлөө ашиглахыг хориглоно. Түүнчлэн ажлаас гарснаас хойш 3 жилийн дотор нууцыг задруулахгүй байна.
10.5. Эрх бүхий үйл ажиллагаанаас /үүнд бизнесийн эрсдэл үл хамаарна/ компанид учруулсан тухайлбал, мэдээлэл өгөх үүргээ биелүүлээгүй, хуурамч мэдээлэл өгсөн, компанийн нэрийг хувийн зорилгод ашигласан, баримт бичгийг зөв хадгалаагүй г.м хохирлыг өөрөө хариуцна.
10.6. Компанийн эрх бүхий албан тушаалтан түүний эрх үүргийн хэм хэмжээ, түүнд тоocох хариуцлагыг хөдөлмөрийн дотоод журмын дагуу шийдвэрлэнэ. Сахилгын арга хэмжээ авагдсан явдал хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

**Арван нэг. Ногдол ашиг компанийн өмчийг шилжүүлэх**

11.1. Компанийн ногдол ашиг хувиарлах шийдвэрийг хувьцаа эзэмшигчид гаргана.
11.2. Энэ шийдвэрт хувьцаа бүрт ногдох ашгийн хэмжээгээр ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн ногдол ашиг төлөх өдрийг тогтоно. Хувьцаа эзэмшигчдийн хурал болох өдөр нь бүртгэлийн өдөр болно.

6

- Ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байна.
- Ногдол ашиг төлсний дараах компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь энэ дүрмийн 5.2-д заасан хувьцаа эзэмшигчдийн оруулсан хөрөнгийн хэмжээнээс их байна.
- Ногдол ашгийг жилд нэг удаа санхүүгийн жилийн эцсийн тайлан тэнцлийг үндэслэн ногдол хувьтай нь хувь тэнцүүлэн хувиарлана. Ногдол ашгийг бэлэн мөнгө болон эд хөрөнгийн түүнчлэн компанийн болон бусад этгээдийн үнэт цаасны хэлбэрээр төлж болно.
- Бүртгэлийн өдрөөс ногдол ашиг төлөх өдөр хүртэл хугацаанд өөрийн эзэмшилд байсан хувьцааг бусдад шилжүүлсэн тохиолдолд ногдол ашиг авах эрх нь уг хувьцааны хуучин этгээдэд үлдэнэ.
- Компани эргүүлж авсан өөрийн хувьцаанд ногдол ашиг хувиарлахгүй.
- Компани энгийн хувьцаагаа хувьцаа эзэмшигчидтэй нь тохиролцсоны дагуу худалдан авах буюу эргүүлж авах асуудлыг тухайн үед нь хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

## Арван хоёр. Компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах

12.1. Компанийн хувьцаа эзэмшигч нь Компанийг өөрчлөн байгуулахдаа Компанийн тухай хуулийн 18-23 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.
12.2. Компанийг Компанийн тухай хуулийн 26 дугаар зүйлд заасан үндэслэлээр татан буулгана.
12.3. Компанийг татан буулгах шийдвэр гаргасан эрх бүхий этгээд татан буулгах комиссыг томилно.
12.4. Компанийг татан буулгах шийдвэр гаргасан эрх бүхий этгээд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 24.1 дэх хэсэгт заасан хугацаанд бүртгэх байгууллагад бичгээр мэдэгдэж, холбогдох баримт бичгийг хавсаргасан байна.
12.5. Татан буулгах комисс Иргэний хуулийн 32.2-32.10 дахь хэсэг, Компанийн тухай хуулийн 26, 27, 28 дугаар зүйлд заасны дагуу компанийг татан буулгах ажлыг эрхлэн гүйцэтгэнэ.
12.6. Компани татан буугдсаныг улсын бүртгэлд бүртгүүлэхдээ Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 25 дугаар зүйлд заасан баримт бичгийг бүрдүүлж бүртгэх байгууллагад илгээнэ.

## Арван гурав. Компанийн санхүүгийн үйл ажиллагаа, бүртгэл тайлан

13.1. Компанийн санхүүгийн жилийн эхлэх, дуусах хугацаа нь тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл байна.
13.2. Компанийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлан болон эрх бүхий байгууллагын журмаар тогтоосон мэдээ, тайлангийн үнэн зөвийг компанийн Гүйцэтгэх захирал хариуцна.

## Арван дөрөв. Дүрэм хүчин төгөлдөр болох

14.1. Энэхүү дүрмийг монгол хэлээр тус бүр 2 хувь үйлдэж нэг хувийг УБЕГ-ын харьяа Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт, компани өөртөө нэг хувийг хадгална.
14.2. Компанийн дүрмийг улсын бүртгэлд бүртгүүлснээр хүчин төгөлдөр болсонд тооцогдоно.
14.3. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах эсэхийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж, хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор батлах бөгөөд тухайн нэмэлт, өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс эхлэн энэхүү дүрмийн нэгэн адил хүчинтэй байна.

УЛСЫН БҮРТГЭГЧ 11/161





Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital

УЛААНБААТАР ХОТ
НОМОР КРЕДИТ ХХК
9022080593
6862705 СБТ19638

МОНГОЛ УЛСЫН
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

# ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар ТЗ 101/464

2015 оны 04 сарын 10 өдөр

Монгол улсын "Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль", "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль", бусад холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 04 сарын 10 өдрийн 189 дугаар тогтоолоор

"НӨМӨР КРЕДИТ ББСБ" ХХК -д

Банк бус санхүүгийн

үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрч, энэхүү гэрчилгээг олгов.

ДАРГА "тамга" С.ДАВААСҮРЭН

Энэхүү гэрчилгээ нь хавсралтын хамт хүчинтэй

УЛААНБААТАР ХОТ
НӨМӨР КРЕДИТ АССЕТ БЭК ХХК
9022080593
6862705 СБТ19638

(Энэхүү хавсралт нь тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хамт хүчинтэй)

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

13 1017464 ТООТ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН
ГЭРЧИЛГЭЭНИЙ ХАВСРАЛТ

"Тэмдэг"

Тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдэд зориулсан тэмдэглэлүүд

НЭГ. Хуулийн этгээдийн оноосон нэр: **"НӨМӨР КРЕДИТ ББСБ" ХХК**

ХОЁР. Хуулийн этгээдийн ангилал: **БАНК БУС САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

ГУРАВ. Үйл ажиллагааны төрөл, хэлбэрийн тэмдэглэл:

| Д/д | Үйл ажиллагааны төрөл, хэлбэр | Олгосон огноо | Олгосон шийдвэрийн дугаар | Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, сэргээсэн, сунгасан хүчингүй болгосон огноо, шийдвэрийн дугаар |
|---|---|---|---|---|
| 1. | Зээл | 2015.04.10 | №189 тогтоол | |
| 2. | Итгэлцэл | 2020.11.25 | №981 тогтоол | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |

Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Delivering diversity
Улаанбаатар хот

УЛААНБААТАР ХОТ
НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЗК ХХК
9022080593
6862705 СБТ19638

Бесткредит инвестмент ББСБ" ХХК-ийн оноосон нэрийг "Нөмөр кредит ББСБ" ХХК болгон өөрчлөхийг зөвшөөрөв. 2017.05.31 №301 тушаал.

ДӨРӨВ. Хуулийн этгээдийн хаяг, хаягийн өөрчлөлтийн тэмдэглэл:

| Д/д | Хаяг | Утас | Тэмдэглэл хийсэн огноо, тэмдэг |
|---|---|---|---|
| 1. | Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2-р хороо, 2-р хороолол, Энхтайваны өргөн чөлөө, Гранд плаза цогцолбор 8-801 тоот. | 99192208<br>95953454 | 2018.04.02 №7/1679 албан тоот |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |

ТАВ. Хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлтийн тэмдэглэл:

| Д/д | Хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлсэн, хорогдуулсан хэмжээ | Зөвшөөрөл олгосон огноо | Зөвшөөрөл олгосон шийдвэрийн дугаар | Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ |
|---|---|---|---|---|
| 1. | | 2015.04.10 | №189 | 400,000,000 /анх олгосон/ |
| 2. | 400,000,000 /нэмэгдүүлсэн/ | 2017.01.19 | №56 | 800,000,000 |
| 3. | 200,000,000 /нэмэгдүүлсэн/ | 2018.04.02 | №233 | 1,000,000,000 |
| 4. | 400,000,000 /нэмэгдүүлсэн/ | 2019.01.09 | №08 | 1,400,000,000 |
| 5. | 500,000,000 /нэмэгдүүлсэн/ | 2019.06.20 | №416 | 1,900,000,000 |
| 6. | 600,000,000 /нэмэгдүүлсэн/ | 2019.11.13 | №536 | 2,500,000,000 |
| 7. | 2,000,000,000 /нэмэгдүүлсэн/ | 2020.10.28 | №350 | 4,500,000,000 |
| 8. | 2,000,000,000 /нэмэгдүүлсэн/ | 2021.12.06 | №322 | 6,500,000,000 |
| 9. | 4,000,000,000 /нэмэгдүүлсэн/ | 2022.01.27 | №32 | 10,500,000,000 |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |



Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Улаанбаатар хот

УЛААНБААТАР ХОТ
НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЗК ХХК
9022080593
6862705 СБТ19638

ЗУРГАА. Хувьцаа эзэмшигчийн талаар:

| Д/д | Овог нэр /Хуулийн этгээдийн нэр/ | Регистрийн дугаар | Хувь нийлүүлсэн хөрөнгийн дүн | Хувь | Зөвшөөрөл олгосон огноо | Зөвшөөрөл олгосон шийдвэрийн дугаар, тэмдэг |
|---|---|---|---|---|---|---|
| 1. | "Кемекс" ХХК | 2659352 | 4,000,000,000 | 38,09% | 2022.01.27 | №32 тушаал |
| 2. | "Юнайтед партс" ХХК | 5619106 | 3,565,000,000 | 33,95% | 2022.01.27 | №32 тушаал |
| 3. | "Новатек интернэшнл" ХХК | 2715376 | 1,450,000,000 | 13,81% | 2022.01.27 | №32 тушаал |
| 4. | Б.Гантулга | ОЭ87082911 | 1,100,000,000 | 10,48% | 2022.01.27 | №32 тушаал |
| 5. | "Эрчим-Электрик" ХХК | 5254841 | 250,000,000 | 2,38% | 2022.01.27 | №32 тушаал |
| 6. | Б.Болортуяа | ЕА90041801 | 45,000,000 | 0,43% | 2022.01.27 | №32 тушаал |
| 7. | Б.Эрдэнэбилэг | ФБ91070317 | 45,000,000 | 0,43% | 2022.01.27 | №32 тушаал |
| 8. | А.Энхжин | УХ90070458 | 45,000,000 | 0,43% | 2021.01.27 | №32 тушаал |
| 1. | "Кемекс" ХХК | 2659352 | 4,000,000,000 | 38,10% | 2022.05.25 | №282 тушаал |
| 2. | "Юнайтед партс" ХХК | 5619106 | 3,565,000,000 | 33,95% | 2022.05.25 | №282 тушаал |
| 3. | "Новатек интернэшнл" ХХК | 2715376 | 1,450,000,000 | 13,81% | 2022.05.25 | №282 тушаал |
| 4. | Б.Гантулга | ОЭ87082911 | 762,500,000 | 7,26% | 2022.05.25 | №282 тушаал |
| 5. | "Эрчим-Электрик" ХХК | 5254841 | 250,000,000 | 2,38% | 2022.05.25 | №282 тушаал |
| 6. | Б.Болортуяа | ЕА90041801 | 157,500,000 | 1,50% | 2022.05.25 | №282 тушаал |
| 7. | Б.Эрдэнэбилэг | ФБ91070317 | 157,500,000 | 1,50% | 2022.05.25 | №282 тушаал |
| 8. | А.Энхжин | УХ90070458 | 157,500,000 | 1,50% | 2022.05.25 | №282 тушаал |

ДОЛОО. Хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газрын тэмдэглэл:

| Д/д | Нэр, дугаар | Хаяг, хаягийн өөрчлөлт | Зөвшөөрөл олгосон огноо | Зөвшөөрөл олгосон шийдвэрийн дугаар | Зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон огноо, шийдвэрийн дугаар |
|---|---|---|---|---|---|
| 1. | Салбар-01 | Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг. | 2018.09.24 | №519 тушаал | |
| 2. | Салбар-02 | Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг. | 2021.06.04 | №144 тушаал | |



УЛААНБААТАР ХОТ
НӨМӨР КРЕДИТ
ХХК
9022080593
6862705 СБТ19638

**НӨМӨР КРЕДИТ ББСБ-ИЙН**
**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2022.08.17 № 09 Улаанбаатар хот

**Сонирхлын зөрчилтэй болон**
**их хэмжээний хэлцлийн тухай**

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.16, 76.1.17 дахь заалт, 87 дугаар зүйлийн 87.1 дэх хэсэг, 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсэг, Иргэний хуулийн 243 дугаар зүйлийн 243.1 дэх хэсгийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Тус компанийн охин компани болох "Нөмөр кредит ассет ТЗК" ХХК (**"Охин компани"** гэх)-ийн гаргах хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэх зөвшөөрлийг Санхүүгийн зохицуулах хороо олгосны дараагаар Охин компанид 10,000,000,000 /арван тэрбум төгрөг/ төгрөгийн үнийн дүн бүхий зээлийн хөрөнгийн багцыг худалдсугай.

2. Дээр дурдсан зөвшөөрөл олгогдсоны дараагаар энэхүү тогтоолын Хавсралт №1 болон Хавсралт №2-т тус тус заасан дараах гэрээг байгуулахыг гүйцэтгэх захирал Ж.Баатарсүрэнд зөвшөөрсүгэй. Үүнд:
   a. Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ;
   b. Фидуцийн барьцааны гэрээ;
   c. Зээлийн эргэн төлөлтийн дансны барьцааны гэрээ.

3. Энэхүү тогтоолыг баталснаар буюу дээр дурдсан зөвшөөрөл олгогдохыг хүлээхгүйгээр тус тогтоолын Хавсралт №2-т заасан Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээ болон Захиргааны ажил гүйцэтгэх гэрээг тус тус байгуулахыг гүйцэтгэх захирал Ж.Баатарсүрэнд зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Б.Гантулгад даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Б.ГАНТУЛГА

# МОНГОЛ УЛС
# ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000236781

2021.09.16
/ Бүртгэсэн он,сар,өдөр /

9011831586
/ Хувийн хэргийн дугаар /

2870657
/ Регистрийн дугаар /

Юнайтед айр файнэнс — Хязгаарлагдмал хариуцлагатай компани
/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм
/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

| Шийдвэр | 01 | 2005.01.27 |
|---|---|---|
| / шийдвэрийн нэр / | / дугаар / | / он, сар, өдөр / |

| 46100 | Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа |
|---|---|
| / Код/ | / Үйл ажиллагааны чиглэл / |

| Хугацаагүй | 1 | 50,000.00 |
|---|---|---|
| / хугацаа / | / гишүүдийн тоо / | / хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр / |

Улаанбаатар, Сүхбаатар, 8-р хороо, СТӨ-ний 10 давхарт 1005 тоот, Утас1: 80808888, Утас2: , Факс:
/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг/

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГАЗАР
/ Бүртгэсэн байгууллагын нэр /

УЛСЫН БҮРТГЭГЧ — Э.БАТОЧИР
/ албан тушаал/ — /гарын үсэг/

УЛСЫН БҮРТГЭГЧ 11/123

УЛААНБААТАР ХОТ
НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЗК ХХК
9022080593
6862705 СБТ19638

Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

| Д/д | Нэмэлт өөрчлөлтийн агуулга | Бүртгэсэн | |
|---|---|---|---|
| | | Огноо | Ажилтан тэмдэг |
| 1 | Хүрэл овогтой Маргадэрдэнэ-н Гүйцэтгэх захирал -р сонгдсон(томилсон)-ыг бүртгэв. | 2021.09.16 | Э.Балдоржр |
| 2 | 46100 Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа үйл ажиллагааг хассаныг бүртгэв.<br>68200 Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа /2021.10.28-/ үйл ажиллагаа шинээр бүртгэв. | 2021.11.09 | Т.Зулзаяа |
| 3 | 68200 Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа үйл ажиллагааг хассаныг бүртгэв.<br>66110 Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа үйл ажиллагаа шинээр бүртгэв. | 2022.04.19 | Т.Зулзаяа |

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

000236781

УЛААНБААТАР ХОТ
НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЗК ХХК
9022080593
6862705 СБТ19638

МОНГОЛ УЛСЫН
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

# ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар ТЗ 316/18

2021 оны 10 сарын 28 өдөр

Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 10 сарын 28 өдрийн 473 дугаар тогтоолоор "ЮНАЙТЕД АЙР ФАЙНЭНС" ХХК -д ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД ЗОХИЦУУЛАЛТТАЙ үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрч, энэхүү гэрчилгээг олгов.

ДАРГА Д.БАЯРСАЙХАН

"Тамга"

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

Энэхүү гэрчилгээ нь хавсралтын хамт хүчинтэй



УЛААНБААТАР ХОТ
НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЗК ХХК
9022080593
6862705 СБТ19638

## Санхүүгийн ашиг сонирхлын талаарх мэдэгдэл

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРООНД

2022/08/28 № 08/28-03

***Тайлбар хүргүүлэх тухай***

"Нөмөр Кредит Ассет ТЗК" ХХК нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгүүлэхтэй холбоотойгоор дараах тайлбарыг хүргүүлж байна. Үүнд:

1. "Нөмөр Кредит Ассет ТЗК" ХХК болон үүсгэн байгуулагч "Нөмөр Кредит ББСБ" ХХК түүний эрх бүхий албан тушаалтан нь Санхүүгийн Зохицуулах Хороо болон төрийн эрх бүхий байгууллагаас аливаа захиргааны болон эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй болно.
2. "Нөмөр Кредит Ассет ТЗК" ХХК нь үүсгэн байгуулагч, анхны үүрэг гүйцэтгүүлэгч "Нөмөр Кредит ББСБ" ХХК болон хөрөнгө худалдагч этгээдтэй аливаа байдлаар ашиг сонирхлын зөрчилгүй бөгөөд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд гэрээ хэлцэл байгуулан ажиллана.
3. "Нөмөр Кредит Ассет ТЗК" ХХК нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахтай холбоотойгоор санхүүгийн хөдлөнгийн шинжээч, зөвлөхийн үйлчилгээ үзүүлэгч "Мүүре Аудит" ХХК, хуулийн хөндлөнгийн шинжээч, зөвлөх үйлчилгээ үзүүлэгч "Хаанлекс Партнерс" ХХН, Хөрөнгө итгэмжлэн удирдагч болон Хэлцлийн зөвлөх "Юнайтед Аайр Файнанс" ХХК, Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэгч "Голомт Капитал ҮЦК" ХХК-тай тус тус аливаа байдлаар ашиг сонирхлын зөрчилгүй болохыг үүгээр тодорхойлж байна.

Хүндэтгэсэн,

ТУЗ-ИЙН ДАРГА Н.БААСАНХҮҮ

СЗХ 2022.09.21 БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2022-09-20 БҮРТГЭВ

**Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан мэдээлэл үнэн зөв болохыг батлав:**

| | |
|---|---|
| Овог нэр: Н.Баасанхүү<br><br>Албан тушаал: Үнэт цаас гаргагч “Нөмөр Кредит Ассет ТЗК” ХХК-ийн ТУЗ-ийн дарга<br><br>Гарын үсэг: .............................................<br><br>(Тамга/тэмдэг) | Овог нэр: Б.Гантулга<br><br>Албан тушаал: Үүсгэн байгуулагч “Нөмөр Кредит ББСБ” ХХК-ийн ТУЗ-ийн дарга<br><br>Гарын үсэг: .............................................<br><br>(Тамга/тэмдэг) |
| Овог нэр: Р.Рэнцэнханд<br><br>Албан тушаал: Үнэт цаас гаргагч “Нөмөр Кредит Ассет ТЗК” ХХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн<br><br>Гарын үсэг: .............................................<br><br>(Тамга/тэмдэг) | Овог нэр: Ж.Баатарсүрэн<br><br>Албан тушаал: Үүсгэн байгуулагч “Нөмөр Кредит ББСБ” ХХК-ийн Гүйцэтгэх захирал<br><br>Гарын үсэг: .............................................<br><br>(Тамга/тэмдэг) |
| Овог нэр: Б.Эрдэнэжаргал<br><br>Албан тушаал: Үнэт цаас гаргагч “Нөмөр Кредит Ассет ТЗК” ХХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн<br><br>Гарын үсэг: .............................................<br><br>(Тамга/тэмдэг) | Овог нэр: С.Ган-Эрдэнэ<br><br>Албан тушаал: “Голомт Капитал ҮЦК” ХХК-ийн Гүйцэтгэх захирал<br><br>Гарын үсэг: .............................................<br><br>(Тамга/тэмдэг) |